

Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II үе Төсөл

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК-ын хамтаар**

2012 оны 3-р сар



Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага – II үе
Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

Түлшний нийлүүлэлтийн сүлжээний үнэлгээний
тайлан

Бүтээгдэхүүн # 22, Ажлын даалгавар 3.7.1/3.7.2

Огноо: 2012 оны 3-р сарын 7

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

ЕСБХБ

БОАЖЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн ТЭМДЭГЛЭЛ

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
0	2012 оны 1-р сарын 12	Ч.Эрдэнэбаяр Онно ван ден Хеувел Р. Сарангоо Э.Билгүүн	Пиет де Вилдт СюзаннРоелофс		
1	2-р сарын 12	Пиет де Вилдт	Онно ван ден Хеувел		
2	3-р сарын 9		Д.Эрдэнэ		
	3-р сарын 15		Пиет де Вилдт Д.Эрдэнэ		

АГУУЛГА

1.	Оршил	1
1.1.	ҮНЭЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ	2
2.	Боловсруулсан түлшний түгээлтийн систем	5
2.1.	Дүн шинжилгээ	5
2.2.	Гол санал зөвлөмж	12
2.3.	Цаашдын арга зам	13
3.	Түүхий нүүрс	16
3.1.	Оршил.....	16
3.2.	Нүүрсний уурхайнууд	16
3.3.	Налайх.....	17
3.4.	Багануур.....	19
3.5.	Шарын гол	21
3.6.	Алагтолгой/Элдэв	22
4.	Боловсруулсан түлш	23
4.1.	Үртсэн шахмал түлш	23
4.2.	Боловсруулсан нүүрсэн түлш	27
4.3.	Эдийн засаг ба үнийн асуудал	42
4.4.	Байгаль орчны нөлөөлөл ба мониторинг	44
4.5.	Саад бэрхшээл.....	45
4.6.	Агуулахууд	46
4.7.	Хороод руу тээвэрлэх	51
4.8.	Системийн тогтвортой байдал.....	52
5.	Олон нийттэй хийсэн зөвлөлдөх уулзалт	54
5.1.	Танилцуулга.....	54
5.2.	Гол ажиглалт, үр дүн.....	56
5.3.	Бэрхшээлүүд холбогдох санал зөвлөмж	63
6.	ХАВСРАЛТ	67

Хавсралт 1. Ярилцлагын тэмдэглэл, олон нийттэй хийсэн зөвлөлдөөний ҮР ДҮН	
Хавсралт 2. Хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэгчдээ авсан судалгаа.....	105
Хавсралт 3. Хагас коксжуулсан нүүрсний талаарх Монгол Улсын СТАНДАРТ.....	108
Хавсралт 4. Хагас коксжуулсан шахмал түлшний талаарх Монгол Улсын СТАНДАРТ.....	109
Хавсралт 5. Тээвэрлэлтийн компанийн ачааны машинуудын сул зогсолт, сааталтай холбоотой төлбөрийн зардлын тооцоолол.....	112
Хавсралт 6. Түгээлтийн компанийн зүгээс ажиллагсаддаа сул зогсолт ба илүү цагийн хөлс болгон олгох төлбөр	113
Хавсралт 7. Нүүрсний төрлүүд ба зэрэглэл.....	114
Хавсралт 8. Олон нийттэй зөвлөлдөх хөтөлбөр	115
Хавсралт 9. ФОТО зургууд.....	116
Хавсралт 10. Иргэдтэй хийсэн ярилцлагын асуултууд	117
Хавсралт 11. Н FORM.....	124
Хавсралт 12. Зөвлөлдсөн хүмүүсийн нэрс	125
Хавсралт 13. Нэмэлт тэмдэглэл.....	129

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Боловсруулсан түлшний гэрээт нийлүүлэгчид.....	4
Хүснэгт 2. Хагас коксжсон нүүрсний төлөвлөгөөт ба бодит нийлүүлэлтийн тоо.....	8
Хүснэгт 3. Боловсруулсан түлшний гэрээлсэн хэмжээ ба нэгжийн үнэ	10
Хүснэгт 4. Түүхий ба хагас коксжсон нүүрсний харьцуулалт (төгрөгөөр).....	11
Хүснэгт 5. Боловсруулсан түлшний татаас олгосон зардлын задаргаа	12
Хүснэгт 6. ЦАС-гийн 2011 онд боловсруулсан түлшид зарцуулсан зардал (төгрөгөөр).....	12

Хүснэгт 7. Уурхайнуудаас Улаанбаатарт хангадаг нүүрсний төрөл ба чанар	17
Хүснэгт 8. Шарын гол JSC-ны үйлдвэрлэсэн түүхий нүүрсний хэрэглээ	21
Хүснэгт 9. Шарын гол JSC Нүүрсний үнэ (2012 оны 1-р сар)	22
Хүснэгт 10. Үртсэн түлш нийлүүлж буй аж ахуйн нэгжүүд	23
Хүснэгт 11. Үртсэн шахмал түлшний нийлүүлэлт 2011 оны байдлаар	24
Хүснэгт 12. Үртсэн шахмал түлшний үйлдвэрлэлийн 2012 оны төлөвлөгөө	24
Хүснэгт 13. 2011-2012 онуудад Засгийн газрын үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ	26
Хүснэгт 14. Боловсруулсан нүүрсэн түлш үйлдвэрлэгчид	28
Хүснэгт 15. Боловсруулсан түлшний үйлдвэрлэлд зориулсан Засгийн газрын нийт татаасны хэмжээ	28
Хүснэгт 16. 2011 онд нийлүүлэгдэхээр төлөвлөгдсөн боловсруулсан түлшний нийт хэмжээ	29
Хүснэгт 17. Шарын гол энерго ХХК –ийн 2011 ба 2012 онуудын сар тутмын үйлдвэрлэл (Тонноор)	33
Хүснэгт 18. “НАКО түлш”-ний 2011 ба 2012 онууд дахь хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний сар тутмын нийлүүлэлт	34
Хүснэгт 19. МАК-ийн 2011 & 2012 оны тутмын гэрээлсэн хэмжээ	38
Хүснэгт 20. Хагас коксжсон нүүрсний талаарх стандарт - MNS 5679-1: 2011	39
Хүснэгт 21. Шахмал түлшний талаарх үндэсний стандарт - MNS 5679: 2011	39
Хүснэгт 22. Шарын гол энерго ХХК-ийн сар тутмын зардлын анализ	43
Хүснэгт 23. Агуулахуудын байршил ба түрээслэгдсэн талбай	47
Хүснэгт 24. Түрээслэсэн талбай, үнэ, хугацаа ба нийт зардлын анализ	47

Зургийн жагсаалт

Зураг 1. Багануурын нүүрсний уурхай	19
Зураг 2. Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь үйлдвэрүүдийн байршил	25
Зураг 3. Булган аймгийн Хялганат тосгон дахь үйлдвэрүүдийн байршил	26
Зураг 4. Шахмал түлш хийх үйлдвэрийн шат дамжлага	30
Зураг 5. Шарын гол энерго	31
Зураг 6. НАКО түлш”-ний үйлдвэр ба шахмал түлш	34
Зураг 7. Хагас коксжсон нүүрс боловсруулах механизм	36
Зураг 8. МАК-ийн хагас коксжсон нүүрсний үйлдвэрийн байршил	37
Зураг 9. Шарын гол энергогийн шахмал түлшний уутны синтетик давхарга	40
Зураг 10. НАКО-ийн шахмал түлшний уут	40
Зураг 11. НАКО түлшний савлагдсан түлшүүдийг гадаа, ил задгай газар хадгалсан байдал	41
Зураг 12. “НАКО түлш”-ний нүүрс хадгалалтын байдал	44
Зураг 13. НАКО түлшний шахмал түлш үйлдвэрлэхдээ хэрэглэдэг цавуу	45
Зураг 14. Агуулахуудын байршил	48
Зураг 15. 10-р хорооны байрлал	57
Зураг 16. 23-р хорооны байршил	57

Графикийн жагсаалт

График 1. Улаанбаатар хотод нийлүүлэгдэж буй нүүрсний уурхайн тооцоологдсон нөөц (сая тонноор)	17
График 2. Боловсруулсан түлш ба боловсруулсан нүүрсэн түлшний үйлдвэрлэлийн эзлэх хувь	30
График 3. Агуулахуудын багтаамж (хороодоор)	48
График 4. ЦАС-ын агуулах ашиглалтын зарцуулалт (хувиар, хороогоор)	49

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Нийлүүлэлтийн сүлжээг судлах явц	2
Схем 2. Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын түүхий нүүрсний нийлүүлэлтийн сүлжээ	16
Схем 3. Түлшний нийлүүлтийн сүлжээ	27

Товчилсон үгийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
АЧА	Агаарын чанарын алба
ЦАС	Цэвэр агаар сан
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
НХХ	Ногоон хөгжлийн хөтөч ТББ
км	километр
кг	килограмм
ШБХ	Шингэрүүлсэн байгалийн хий
ШНХ	Шингэрүүлсэн нефтийн хий
МАК	Монголын алт корпораци
МСС	Мянганы сорилтын сан
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
НСҮ	Нийлүүлэлтийн сүлжээний үнэлгээ
НАЧА	Нийслэлийн агаарын чанарын алба
Ам.доллар	АНУ доллар

Зарим нэр томъёоны тайлбар

Хагас коксжсон нүүрс: Барьцалдуулагч ашиглан шахмал хэлбэрт оруулаагүй задгай хэлбэрээр байгаа боловсруулсан түлшийг хэлнэ. Нэн түгээмэл.

Хагас коксжсон шахмал түлш: Барьцалдуулагч ашиглан хэлбэрт оруулсан шахмал цул хэлбэрээр байгаа боловсруулсан түлшийг хэлнэ. Олдоцтой гэвч ховор.

Хагас коксжсон нүүрс, үртсэн холимог түлш: Энэ нь хагас коксжсон нүүрс, үртэс хоёрыг янз бүрийн орц хэмжээгээр хольж хийсэн шахмал түлш юм. Төдийлөн түгээмэл биш.

Боловсруулсан нүүрсэн түлш: Дээрх төрлийн бүхэл нүүрс орж боловсруулсан түлшийг нэгтгэн нэрлэнэ.

Үртсэн шахмал түлш: Энэ нь цэвэр модны үртсийг барьцалдуулагч ашиглан хэлбэрт оруулсан шахмал цул хэлбэрээр байгаа боловсруулсан түлшийг хэлнэ.

Голлон энэхүү түлшийг хагас коксжсон нүүрс болон хагас коксжсон шахмал түлштэй хамтруулан ашиглана. Ховор.

Боловсруулсан түлш: Дээрх төрлийн бүхэл түлшийг нэгтгэн нэрлэнэ.

1. Оршил

Монгол Улсын Засгийн газар нь нийслэл Улаанбаатар хотын агаарын чанарыг эрс сайжруулах зорилгоор гэр ахуйн халаалтын хэрэгсэлд түүхий нүүрс ашиглахыг ойрын жилүүдэд багтаан хориглох зорилго тавьж байна. Улаанбаатар хот дахь агаарын бохирдол нь үндэсний эрүүл мэндийн стандартын зохих түвшингээс нь их хэмжээгээр илүү байгаа нь хотын хүн амыг эрүүл мэндийн эрсдэлд оруулж байгаа билээ.

Түүхий нүүрстэй холбоотой өнөөгийн төрөөс тавьсан хориг нь зөвхөн тодорхой хороодын нутаг дэвсгэрээр хязгаарлагдаж байгаа ба уурын зуухнууд, цахилгаан станц, үйлдвэрүүдэд хэрэглэхийг зөвшөөрсөн хэвээр байна. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэх болсон үндсэн шалтгаан нь айл өрхүүдийн зуухнуудаас үүсэж буй агаарын бохирдол (нарийн ширхэгт тоос_{2.5}) нь нийт агаарын бохирдлын 59¹ хувийг бүрдүүлж байгаа явдал юм.

Хэрэв түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр солих өнөөгийн төлөвлөгөө амжилттай хэрэгжсэн тохиолдолд Улаанбаатар хотын жилийн түүхий нүүрсний хэрэглээ нь одоогийн жилийн нийт хэрэглээ болох ойролцоогоор таван сая тонныг ойролцоогоор жилд 800,000 тонноор багасгах юм.

Энэхүү судалгааны хүрээнд манай төсөл нь түүхий нүүрс ба боловсруулсан түлшний үйлдвэрлэл, тээвэрлэлт, түгээлтийн одоогийн системийг судалсан бөгөөд энэхүү судалгаа нь Нийслэлийн Засаг даргын 351 тоот тогтоол ба А-116/331 тоот тушаалын дагуу түүхий нүүрсийг хориглосон Баянгол дүүрэгт голлон явагдлаа. Энэхүү дүүргийн тодорхой хорооны оршин суугчид хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлшийг хэрэглэдэг ба түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон юм. Засгийн газар эдгээр түлшийг түгээх ба татаас олгох зорилгоор туршилтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ.

Энэ судалгаа нь нийлүүлэлтийн сүлжээний үнэлгээнд төвлөрч нь туршилтын хөтөлбөрийн хүрээнд хагас коксжсон нүүрс, хагас коксжсон шахмал түлш, үртсэн шахмал түлшний үйлдвэрлэгчдээс борлуулагчид, хэрэглэгчид хүртэлх түгээлтийн системийн шатлал бүрийг хамарч олон нийттэй хийсэн зөвлөлдөх ажлын үр дүнг мөн багтаав..

¹Улаанбаатар дахь агаарын бохирдол – Суурь судалгаа (Дэлхийн банк) 2009.

1.1. ҮНЭЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ

Хагас коксжсон нүүрс ба хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэлийн энэхүү Нийлүүлэлтийн сүлжээний үнэлгээ (НСҮ) нь.) боловсруулсан түлшний үйлдвэрлэл ба түгээлтийн системтэй холбоотой төрөл бүрийн асуудлуудыг судлах зорилгоор хийгдсэн ба дараах хэсгүүдийг хамарсан болно. Үүнд:

- Боловсруулсан нүүрсэн түлш үйлдвэрлэж байгаа бүх аж ахуйн нэгжүүд (хагас коксжсон нүүрс эсвэл хагас коксжсон шахмал түлшний аль нэг нь);
- Боловсруулсан түлшний тээвэрлэлт ба агуулахын менежмент (Агуулахыг ашиглахтай холбоотой зарим нэгэн ажиглалтууд нь боловсруулсан нүүрсэн түлш ба үртсэн шахмал түлшний аль алинтай нь хамаарах юм.);
- Түлшийг жижиглэнгээр борлуулагчдад түгээдэг тээврийн компаниуд.

Энэ судлагааны үндсэн зорилго нь боловсруулсан нүүрс үйлдвэрлэгчид, түгээлтэд оролцон ажиллаж байгаа оролцогч талууд мөн энэхүү түгээлтийн хөтөлбөртэй холбоотой байгаль орчин ба нийгэм, эдийн засгийн төрөл бүрийн асуудлуудыг тодорхойлох байсан юм.

Хийгдсэн үйл ажиллагаанууд:


- Төслийн багийн гишүүд, НАЧА, боловсруулсан түлш үйлдвэрлэгчид, агуулах хариуцсан ажилтнууд, хороо ба борлуулах цэгүүд рүү тээвэрлэгчид зэрэг холбогдох хувийн байгууллагуудтай уулзалт хийв.
- Боловсруулсан түлшний үйлдвэрлэлтэй холбоотой мэдээлэл цуглуулав.
- Гарч болзошгүй байгаль орчны нөлөөлөлд дүн шинжилгээ хийв.

1.1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь боловсруулсан түлшний үйлдвэрлэл ба түгээлтийн одоогийн уялдаа холбоог дүгнэх мөн энэ судалгаанд үндэслэн энэ системийг сайжруулах зорилгоор зөвлөмж санал болгох мөн боловсруулсан түлш үйлдвэрлэгч компаниуд ба боломжит зах зээлд одоо оршиж байгаа, цаашид үүсэж болзошгүй саад бэрхшээлийг тодорхойлох зорилготой юм.

1.1.2. АРГА ЗҮЙ

Судалгааны явцыг Схем 1.-д харуулснаар тогтоосон юм. Оролцогч тал бүрт зориулсан ярилцлаганд оролцогчдын нэрс ба судлах асуудлуудыг тодорхойлсон юм.



Схем 1. Нийлүүлэлтийн сүлжээг судлах явц

Төслийн баг нь боловсруулсан түлшний үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг хоёр үе шаттайгаар явуулсан. Үүнд урьдчилсан судалгаа болон орон нутагт хийсэн судалгаа багтана. Урьдчилсан судалгаа нь интернэтээс баримт, тайлан, түүхийн нүүрс нийлүүлэгчид, боловсруулсан түлшний үйлдвэрлэгчид, төрийн удирдлагууд ялангуяа ЦАС ба НАЧА зэрэг нийлүүлэлтийн систем дэх гол оролцогч талуудаас авсан мэдээлэл зэргийг ашигласан юм. Орон нутгийн судалгаануудыг 2011 оны эцэс мөн 2012 оны эхэнд-нд урьдчилсан судалгааны үр дүнд боловсруулсан мэдээлэлд нэмэлт оруулах мөн уг мэдээллүүдийг хянах, баталгаажуулах зорилгоор хийсэн юм.

Хагас коксжсон нүүрс ба хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэлт, тээвэрлэлт ба түгээлтэд оролцож байгаа төрийн байгууллагууд болон хувийн компаниудад зориулсан асуулга бэлтгэн(Хавсралт 2.) ярилцлага хийж нарийвчилсан судалгаа явуулсан. Энэ судалгаа нь боловсруулсан түлшний нийлүүлэлтэд оролцож буй бүр гол оролцогч талуудыг хамарсан ба боловсруулсан түлш үйлдвэрлэгч компанийн менежментийн механизм мөн тээвэрлэлт ба түгээлтийн дадал зуршлыг багтаасан тэдгээрийн стратегийн талаар ойлголттой болох зорилготой юм.

1.1.3.АНАЛИЗ ХИЙГДЭХ ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Ерөнхийдөө үйлдвэрлэгчид түүхий нүүрс болон бусад нэмэлт бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн эцсийн бүтээгдэхүүн боловсруулдаг. Эдгээр нь хагас коксжсон нүүрс эсвэл хагас коксжсон шахмал түлшний аль нэг байдлаар хэрэглэгчдэд хүрдэг юм. Энэ судалгаанд нэг хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчид ба дөрвөн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэгчид, долоон үртсэн шахмал түлш үйлдвэрлэгчид мөн найман агуулах ба нэг түгээгч компанийг судалсан юм.

Одоогийн боловсруулсан түлшний түгээлтийн механизмийн хүрээнд ЦАС болон НАЧА нь 100 тонноос их боловсруулсан түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрлэгчидтэй гурвалсан гэрээ байгуулж байгаа юм. Түүнчлэн эдгээр компаниудын өмнөх жилүүдийн гүйцэтгэл 75% буюу түүнээс дээш байх ёстой юм. Мөн боловсруулсан түлш үйлдвэрлэгчид нь өөрсдийн эцсийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчидэд зөөвөрлөхөд тохиромжтой уутанд савлах (20 кг, 25 кг 40 кг) шаардлагатай юм.

Одоогийн байдлаар хотын засаг даргын 351 тоот захирамжийн дагуу НАЧА боловсруулсан түлш үйлдвэрлэгч 11 компанитай (Хүснэгт 1.) гэрээ байгуулсан ба Улаанбаатар хотод агуулахууд түрээслэж байна. ЦАС нь үйлдвэрлэгчдээс боловсруулсан түлш худалдаж авах, агуулах түрээслэх, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчидэд түгээх зэргийн санхүүжилтийг хариуцна.

Гурван талт гэрээнд гарын үсэг зурсан 11 компаниас гурав нь боловсруулсан, нүүрсэн суурь бүхий түлшийг нийлүүлж байна. Эдгээр түлш нь хагас коксжсон түлш эсвэл хагас коксжсон нүүрсэн шахмал түлш юм. Саяхан 2-р цахилгаан станц хагас коксжсон нүүрсэн шахмал түлш нийлүүлэхээр Засгийн газартай гэрээ байгуулсан ба үйлдвэр ашиглалтанд орсноор энэ нь Боловсруулсан нүүрсэн түлшний дөрөв дэх гол ханган нийлүүлэгч болж байгаа юм.

Хүснэгт 1. Боловсруулсан түлшний гэрээт нийлүүлэгчид

Компани	Байршил
Үртсэн шахмал түлшний үйлдвэрлэгчид	
ТАРА ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Хайрхан Буянт	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Хүслэн Өлзий ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Голден блейз ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
“Үртэсшахмалтүлшнийүйлдвэр” НӨҮГ	Булган аймаг, Хялганат тосгон
Теноте ХХК	Булган аймаг, Хялганат тосгон
Өлзий Төв ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Хагас коксжсон нүүрс ба шахмал түлш үйлдвэрлэгчид	
Шарын гол энерго ХХК	Аж үйлдвэрийн хэсэг, Дархан хот
НАКО түлш ХК	Аж үйлдвэрийн хэсэг, Дархан хот
Монголын алт “МАК” ХХК	Даланжаргалан сум, Дорноговь аймаг
2-р цахилгаан станц (үйл ажиллагаа нь хараахан эхлээгүй байгаа)	<i>Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот</i>

(Эх сурвалж: НАЧА 2011)

2. Боловсруулсан түлшний түгээлтийн систем

2.1. Дүн шинжилгээ

Боловсруулсан түлшний үйлдвэрлэл ба хэрэглээ нь сүүлийн жилүүдэд Монгол Улсын эн тэргүүний анхаарах асуудлуудын нэг бөгөөд Улаанбаатар хот ба бусад хотуудын агаарын бохирдлыг бууруулах хамгийн чухал арга замуудын нэг болоод байгаа юм. Улсын төсвийн үлэмж хэсэг нь гэр хороололд голдуу ЦАС-аар дамжин боловсруулсан түлшний хэрэглээг дэмжихэд татаас хэлбэрээр зарцуулагдаж байна. Монгол Улсын Засгийн газар нь боловсруулсан түлшийг гурван төрөлд ангилдаг. Эдгээрт 1) Хагас коксжсон нүүрс, 2) Үртсэн шахмал түлш болон 3) Шингэрүүлсэн нефтийн хий юм (ШНХ) юм. Энэ судалгаа нь зөвхөн хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлшинд голлон анхаарна учир нь ШНХ нь Монгол Улсад хараахан өргөнөөр хэрэглэдэггүй юм².

2.1.1. Бодлогын тогтолцоо

Боловсруулсан түлшийг дэмжих зорилго бүхий үндэсний тусгайлсан бодлого стратеги байхгүй. Боловсруулсан түлшний үйлдвэрлэл ба хэрэглээ нь хэд хэдэн бодлогын бичиг баримтын бүрэлдэхүүн хэсэг болж байна. Эдгээрт боловсруулсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих асуудал нь **“Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө”**-ний чухал хэсэг болж орсон ба гэр хорооллын халаалтанд хэрэглэгддэг түлшийг орлуулах бүрэлдэхүүн хэсэг болж багтсан байдаг. **“Нүүрсний үндэсний стратеги”**-д боловсруулсан түлш нь мөн тодорхой тусгагдсан ба одоогийн байдлаар УИХ-аар хэлэлцэгдэх шатандаа явж байна. Ерөнхийдөө энэ хөтөлбөрийн зорилго нь нүүрс боловсруулах ба энэхүү нүүрсийг орлуулах боловсруулсан нүүрсэн суурь бүхий бүтээгдэхүүнүүд, ШНХ, ШБХ зэрэг төрөл бүрийн боловсруулсан түлш үйлдвэрлэх, тэдгээрийг хэрэглээнд оруулах талаарх асуудлуудыг тодорхойлсон. Сүүлийн 10 жилд эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг оруулах оролдлого хийгдэж байсан боловч одоог хүртэл ямар ч хууль батлагдсангүй³. Сэргээгдэх эрчим хүчний талаар үндэсний тусгай хөтөлбөр байдаг боловч гэрийг халаахад нүүрсний оронд ашиглагдаж болохуйц сэргээгдэх эрчим хүчний найдвартай эх үүсвэр байхгүй байгаа юм. **Барилгын шинэ хөтөлбөр** нь боловсруулсан түлшийг дэмжих, агаарын бохирдлыг багасгах хэд хэдэн бодит зорилтыг багтаасан байдаг.

²Засгийн газраас Монгол Улсад ШНХ-н хэрэглээг дэмжих зорилгоор ШНХ-тэй холбогдон татвараас чөлөөлөх мөн бүх том оврын автобуснуудыг ШНХ-н горимд шилжүүлэх (2011 ба 2012 онуудад) мөн үүнийг мянга мянган машинд хэрэгжүүлэх зарим арга хэмжээ авсан. Одоогоор Улаанбаатар хотод хэд хэдэн ШНХ-н түгээх станцууд үйл ажиллагаа явуулж байна.

³“Эрчим хүчний хэмнэлтийн бодлого хөтөлбөрийн нарийвчилсан судалгаа” Эрчим хүчний хэрэг эрхлэх газар: (2011)

Барилгын шинэ хөтөлбөрт тусгагдсан боловсруулсан түлш ба агаарын бохирдолтой холбоотой арга хэмжээнүүд:

- Жижиг болон дунд хэмжээний даралтын зуухнуудад технологийн шинэчлэл хийгдэх
- 2013 он гэхэд бохирдуулагчдыг хамгийн багадаа 60%-аар багасгах зорилгоор гэр хороолол дахь халаалтын асуудлыг сайжруулах ба бага утаа ялгаруулдаг эрчим хүчний хэмнэлттэй зуухнуудыг суурилуулах
- Улаанбаатар хотын гэр хорооллын 2,500 өрхийг төвийн халаалтын системд холбох
- Зуух болон түлшний хамгийн сайн тохирч буй хувилбарыг тодорхойлох ба эхний үе шатдаа 10,000 айл өрхийг хангах ;
- 60,000 өрхийг дулаалгын материалаар хангах төсөл хэрэгжүүлэх
- Хагас коксжсон нүүрсний бөөний болон жижиглэнгийн худалдааны сүлжээ бий болгож, гэр хорооллын айл өрхүүдэд боловсруулсан түлшээ түгээх
- Жилд 600,000 тонн утаагүй түлш үйлдвэрлэх хүчин чадлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- Гэр хорооллын айл өрхүүдийг шингэрүүлсэн хий ашиглуулж заншуулах
- Түүхий нүүрсийг хориглох тодорхой бүсүүдийг байгуулах
- Төрийн байгууллага ба томоохон хувийн компаниудын нам даралтын блолн том оврын зуухнуудыг солих ба б байгалийн хий эсвэл тогоор ажилладаг болгох
- Түүхий нүүрсний хэрэглээг алгуур бууруулах хэрэгтэй
- Хий ба цахилгаан ашиглан, айл өрхөд зориулсан шинэ технологи бүтээх, шаардлагатай тохиолдолд татаас олгох.
- 800 том оврын автобус ба 1500 микро автобусыг ШНХ-д шилжүүлэх
- Нийтийн тээврийн талаар ТЭЗҮ хийх (жишээ нь: метро)
- 50 троллейбус хэрэглээнд оруулж тэдгээрээс 100-г нь цахилгаан системд шилжүүлэх

Одоогийн байдлаар 2011-2012 оны өвлийн улиралд Засгийн газар нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн тодоохой бүсүүдэд хэрэгжиж буй туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх замаар боловсруулсан түлшний хэрэглээг дэмжиж байна. Энэ туршилтын хөтөлбөр хэрэгжиж буй газарт түүхий нүүрсний аливаа хэрэглээг хориглосон ба цахилгааны хэрэглээний төлбөр болон боловсруулсан түлшинд татаас олгосон юм. Оршин суугчид туршилтын хөтөлбөр хамрагдснаар зөвхөн боловсруулсан түлш хэрэглэх шаардлагатай болсон юм.. Энэхүү асуудал нь хууль эрхзүйн үүднээс бат бөх

суурьтай. Өөрөөр хэлбэл Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулинд багтсан. Энэ хууль нь түлш ба цахилгааны татаас зэрэг энэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх гол арга хэмжээг тодорхойлсон байдаг. УБ хотын захиргааны 351 тоот захирамж ба А-116/361 тушаал нь Баянгол дүүргийн долоон хорооны 11,000 айл өрхийг хамарсан түүхий нүүрсийг хориглосон бүс байгуулахыг заасан юм. Оролцогч төрийн гол байгууллага нь уг хөтөлбөрийг санхүүжүүлэгч ЦАС мөн Нийслэлийн агаарын чанарын албанаас хэрэгжилтийг хянадаг юм. Нэг тээвэрлэлтийн компани ба 11 боловсруулсан түлш үйлдвэрлэгчидтэй дэд гэрээ байгуулагдсан. Түүнчлэн 8 агуулах, 14 борлуулалтын цэг ашиглагдаж байна.

Сүүлийн жилүүдэд шахмал түлшний ба хагас коксжсон нүүрсний талаар стандартыг батлах зорилгоор маш чухал дэвшилтүүд хийгдсэн. (үүнд үртсэн ба хагас коксжсон нүүрсэн шахмал түлш багтана) Одоо байгаа стандартууд нь хагас коксжсон/ үртсэн шахмал түлшний холимогтой хамааралгүй бөгөөд үйлдвэрлэгчдийн шахмал түлш үйлдвэрлэх процесс нь байгаль орчин ба хүний эрүүл мэнд дэх нөлөөллийг судлаж, түүнийхээ дагуу стандартуудаа шинэчлэх нь чухал юм.

Савлагааны стандартыг мөн судалж үзэх шаардлагай учир нь тэд уутны чанар ба тэсвэртэй байдлаас илүүтэйгээр шошгон дээрх шаардлагатай мэдээлэлд анхаардаг. Стандартууд эсвэл холбогдох журам нь зөвхөн байгаль орчин, ялангуяа ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн үртэсийг хэрэглэнэ гэж заах шаардлагатай.

2.1.2. Түүхий эдийн нийлүүлэлт

Одоогийн байдлаар Монгол Улсын нүүрсний батлагдсан нөөц нь 150 тэрбум тонн бөгөөд жилд 16 сая тонныг⁴ олборлодог тул халаалт эсвэл хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэлд зориулагдах түүхий нүүрсний нийлүүлэлтэд огтхон ч хомсдол үүсэхгүй. Түүхий нүүрс ба боловсруулсан түлш нь ирэх хэдэн арван жилд хэрэглээнээс гарахгүй учир нь шинэ зууны цахилгаан станцууд нь түүхий нүүрсийг хэрэглэсээр байх юм.

Газар нутгийн 7% нь ойгоор бүрхэгдсэн ба эдгээр ойн сан бүхий газар нь улсын хойд хэсэгт оршдог учир **үртсэн шахмал түлш** үйлдвэрлэх тодорхой хэмжээний боломж бий. Үртэс нь мод боловсруулалтын дагалдах бүтээгдэхүүн ба саяхныг хүртэл мод үнэгүй олдож байв. Гэхдээ энэ нөөц хомсдож эхэлсэн ба цаашид үлэмж багасах эрсдэлтэй. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН/GIZ) болон НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ/FAO) зэрэг олон улсын төслүүд нь эдүгээ ойн салбарын дэмжин ажиллаж байгаа ба мөн шинэ хөтөлбөр боловсруулж байна. Хагас коксжсон нүүрс хэрэглэгчдийн ихэнх нь хагас коксжсон түлшээ асаахдаа мод эсвэл үртсэн шахмал түлш ашиглаж байгаа нь харагдаж байгаа юм.

2.1.3. Боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрийн төлөвлөлт

Судалгаа нь 2012-2013 оны өвөл ба түүнээс цааших хугацааны туршилтын хөтөлбөрийн төлөвлөлтөд ашиглаж болох нилээд чухал ажиглалт, үр дүнг гаргаж ирсэн юм. Боловсруулсан түлшний хөгжлийг дэмжих зорилгоор туршилтын хөтөлбөрийн илүү урт хугацаатай хөтөлбөртэй холбох шаардлагатай. Өнөөдөр хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлшний үнэ нь түүхий нүүрсний үнэтэй өрсөлдөхгүй байгаа ба хэдийгээр Засгийн газрын татаас нь өрхийн орлогын түвшинтэй холбоотой байх боловч энэ байдлаараа үргэжлүүлвэл ирэх жилүүдэд ихээхэн хэмжээний татаас шаардлагатай байгаа нь тодорхой.

⁴ “Эрчим хүчний хэмнэлтийн бодлого хөтөлбөрийн нарийвчилсан судалгаа” Эрчим хүчний хэрэг эрхлэх газар: (2011)

Боловсруулсан түлшний үйлдвэрлэлийн зардлыг бууруулах нь хөтөлбөрт үр ашигтай байх ба хагас коксжсон нүүрсэнд чиглэх гол бодлого юм. Хагас коксжсон шахмал түлшний оронд хагас коксжсон түлш зэрэг илүү хямд төсөр түлшийг гэрийн зууханд ашиглах боломжийг судлах нь зүйтэй.

2011-2012 онуудын өвлийн хувьд боловсруулсан түлшний үйлдвэрлэлийн хүчин чадал хязгаарлагдмал сул байгаа нь хамгийн гол бэрхшээл юм. Тиймээс үртэс үйлдвэрлэгчдийн нэг өвлийн үйлдвэрлэлийн бодит хүчин чадал нь 3,000 тонноос хэтрэхгүй бөгөөд хүлээгдэж буй үйлдвэрлэл 10,500 тонн гэдэг дүгнэлтэнд хүрч болох юм. 2011 оны төлөвлөгдсөн үйлдвэрлэл нь 7,470 тонн байсан хэдий ч бодит нийлүүлэгдсэн хэмжээ нь 2,646 тонн байв. Хагас коксжсон нүүрсний хувьд энэ хэмжээ нь дөнгөж 12% байсан юм. (Хүснэгт 2.) Эдгээр тоо баримтад үндэслэн тооцоолвол төлөвлөгөө нь 30,000 тоннд тулгуурласан боловч боловсруулсан түлшний үйлдвэрлэлийн баталгаатай хүчин чадал нь ойролцоогоор 6,000 тонн байх юм.

Хүснэгт 2. Хагас коксжсон нүүрсний төлөвлөгөөт ба бодит нийлүүлэлтийн тоо

Компани	Төлөвлөгөө	Нийлүүлэлт	%
Шарын гол	9,400	531	6%
НАКО	6,850	110	2%
МАК	6,000	2,000	33%
НИЙТ	22,250	2,641	12%

Энэхүү өвлийн сургамжиндаа тулгуурлан ирэх жилүүдэд зориулан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах ёстой юм. Энэ төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ханган нийлүүлэлтийн болзошгүй хомсдол, улс төрийн гэнэтийн өөрчлөлт, цаг уурын онцгой нөхцөл байдал, түүхий эдийн үнийн ихээхэн өсөлт зэрэг болзошгүй саад тотгорыг тодорхойлж эрсдэлийн дүн шинжилгээ хийх
- Эдгээр эрсдэлийг эмзэг байдлыг бууруулах эсвэл гэнэтийн шинэ нөхцөлд дасан зохицах хувилбаруудыг боловсруулж бэлтгэх хэрэгтэй. Жишээ нь түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, хорих зорилтот бүсийн боловсруулсан түлшний бодит хэрэгцээний хэмжээ нь үйлдвэрлэх түлшний баталгаатай бэлэн байгаа хэмжээтэй нягт уялдан хамаарах ёстой. Үндсэндээ боловсруулсан түлшний үйлдвэрлэлийн бодит хүчин чадлаас энэхүү түлшээр хангагдах айл өрхийн тоо шууд порпорцианал байх нь зүйтэй.
- Боловсруулсан түлшийг хэрэглээнд оруулахтай холбоотойгоор хоёр төрлийн бүсийг байгуулах боломжтой нэг нь түүхий нүүрсийг бүрэн хориглосон нөгөөх нь арай уян хатан системтэй байх юм.

Дээр дурьдсан үр дүнд хүрэхийн тулд ямар төрлийн дэмжлэг үзүүлэхийг тодорхойлох зардлын нарийвчилсан судалгаа хийгдэх шаардлагатай. Жишээлэхэд хэрэглэгчидэдийн сэтгэл ханамж өндөр байгаа үртсэн шахмал түлшинд арай бага түвшинд татаас олгох боломжтой юм.

Өнөөгийн байдлаар хэдийгээр хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх нь илүү өндөр өртөгтэй хэдий ч хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгч болон хагас коксжсон шахмал түлшүйлдвэрлэгч хоёрын Засгийн газраас нэг тоннд өгч буй татаас адил байна. Хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэгчдийн тайлбарласнаар түүхий нүүрсний нэг тонн тутмын үнийг 55,000.төгрөгт үндэслэн хийсэн зардлын тооцоогоор нэг тонн хагас коксжсон шахмал түлшний үнэ 210,000 төгрөгт хүрч байгаа. Одоогоор хэрэглэгчдэд олгож байгаа татаас нь нэг тонн шахмал түлшний үнийг хоёр тоннийн ачааны машинаар түүхий нүүрс авсантай ижил зардалтай байна. Энэхүү үнэ нь түлшийг жижиг савлагаатай худалдаалснаас ойролцоогоор нэг тонн нь 60,000 төгрөгөөр хямд байгаа

юм. Тийм ч учрааснэг талаас хэрэглэгчдийн төлж буй нүүрсний үнэ дэндүү бага лхарин нөгөө талаас энэхүү үнэ нь шахмал түлш үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн зардлаас доогуур байгаа юм. Үнэ ба зардлын талаар нарийвчилсан судалгаа шаардлагатай бөгөөд уг судалгаагаар боловсруулсан түлшний үйлдвэрлэл болон хэрэглээг дэмжсэн үр дүнтэй татаасын системийг боловсруулан гаргах юм.

Зардалын хувилбаруудыг боловсруулсан түлшний тээвэрлэлт ба худалдааг зохицуулах өөр бусад арга зам болгож боловсруулах ёстой. Жишээлбэл Багануурын нүүрсний уурхай мэт томоохон түүхий нүүрс үйлдвэрлэгчид нь өөрсдийн нүүрс Улаанбаатар хотод хүргэгдэн ирэхэд хадгалдаггүй, орон нутгийн жижиглэн болон бөөний борлуулагчдад шууд борлуулдаг. Энэ нь агуулахууд түрээслэн тээврийн компаниар сонгогдсон борлуулагчид тээвэрлэн хүргэх зэргээр ажилладаг одоогийн түгээлтийн системийн өөр нэгэн хэмнэлттэй, хялбар хувилбар болгож боловсруулсан түлшний түгээлтэнд ашиглаж болох арга хэлбэр юм. Эдгээр бүх асуудлуудыг зардлын төрөл бүрийн хүчин зүйлсийг боловсруулахтай холбоотой өөрчилж болох нэгдсэн тооцооллын загварт оруулж болно. Ийм загвар нь үйл ажиллагаануудын зардлан үр өгөөж/хэмнэлттэй байдлын дүн шинжилгээг хийхэд суурь болж өгөх боломжтой.

2.1.4. Үйлдвэрлэл

Хэдийгээр 11 компани туршилтын хөтөлбөрт зориулан боловсруулсан түлш үйлдвэрлэхээр Засгийн газартай гэрээ байгуулсан боловч 2011 оны 12-р сарын байдлаар бодит байдал дээр эдгээр компаниудын тэн хагасаас бага нь боловсруулсан түлш үйлдвэрлэсэн байна. Мөн бусад үйлдвэрлэгчдийн бодит үйлдвэрлэл нь төлөвлөгдсөн хэмжээнээс эрс бага байна. Компаниуд төлөвлөгдсөн үйлдвэрлэлийн түвшиндээ хүрч чадахгүй мөн хүрэхийг ч хүсэхгүй байсан юм.

Боловсруулсан түлш үйлдвэрлэгч компаниуд нь (ЦАС ба НАЧА-тай) гурван талт гэрээ байгуулж ЦАС-гаас боловсруулсан түлш үйлдвэрлэхээр урьдчилсан төлбөр хүлээн авсан боловч сард ганцхан удаа түлш нийлүүлдэг эсвэл огт нийлүүлэхгүй байлаа. Засгийн газар боловсруулсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд компани ба хэрэглэгчдийн аль алинд нь дэмжлэг үзүүлж байгаа юм. Үйлдвэрлэгчид нь хагас коксжсон нүүрс ба хагас коксжсон шахмал түлшний нэг тонн тутамд 150,000 төгрөгний, үртсэн шахмал түлшний нэг тонн тутмаас 120,000 төгрөгний татаас авдаг. Түлшийг хэрэгчлэгчдэд тус тус 90,000 ба 80,000 төгрөг зэрэг хямдралтай үнээр борлуулдаг. Түүнчлэн Засгийн газар борлуулсан нэг тонн боловсруулсан түлш тутамд борлуулагчдад 6,000 төгрөгний урамшуулал олгодог.

Үйлдвэрлэгчид эхэндээ нэг тонныг 150,000 төг байхаар тохирсон байна. Энэ нь түүхий нүүрсний үнэ болох нэг тонн 33,000 төг дээр тулгуурлаж хийгдсэн юм. Түүхий нүүрсний үнэ нэг тонн нь 50,500 төгрөг болж өсөхөд хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэх зардал нь нэг тонн нь 150,000 төгрөгөөс хэтэрсэн боловч ЦАС ба НАЧА-тай хийгдсэн гэрээнд өөрчлөлт ороогүй юм.

Гэхдээ нөгөө талаасаа эдгээр компаниудад Засгийн газар нь зах зээлийн өнөөгийн нийгэмд атаархам давуу нөхцөл байдлыг үүсгэж өгч байгаа билээ. Эдгээр компаниуд нь бүтээгдэхүүний сурталчилгаа маркетинг, борлуулалт, тээвэр зэрэгт зардал төлөхгүй байгаа бөгөөд тодорхой хэмжээний урьдчилгаа төрөөс авч байгаа юм.

Боловсруулсан түлшний татаасанд зориулан гэрээний хэрэгжилтийн хугацаанд ЦАС –нд найман тэрбум төгрөгний төсөв баталсан юм. Хүснэгт харагдаж байгаачлан үртсэн шахмал түлштэй харьцуулахад төслийн ихээхэн хэсэг нь ойролцоогоор нийт 6,675 тэрбум зардалтай нүүрсэн суурь бүхийн боловсруулсан түлш худалдан авахад хуваарилагдсан юм. Засгийн газар нийт 1.26 тэрбум төгрөгөөр 10,500 тонн үртсэн шахмал түлш худалдан авах гэрээ байгуулсан юм. (Хүснэгт 3.)

Түлшний нийлүүлэлт дутмаг байгаагаас үүдэн туршилтын дүүрэгт нэлээд хүндрэл учруулж байна. Цэвэр түлш хязгаарлагдмал байгаагаас тус дүүргийн иргэд түүхий нүүрсийг хэрэглэхэд хүрээд байна.

Хүснэгт 3. Боловсруулсан түлшний гэрээлсэн хэмжээ ба нэгжийн үнэ

Түлшний төрөл	Нийлүүлэгдэж байгаа нүүрсний нийт хэмжээ (тонн)	Үйлдвэрлэгчдийн гэрээлсэн нэгж үнэ (төг/тонн)	Үйлдвэрлэгчдэд худалдан авах түлшний нийт үнэ	Хэрэглэгчдэд борлуулах үнэ (төг/тонн)	Хэрэглэгчдэд борлуулан олсон нийт орлого (төг)
Хагас коксжсон нүүрс ба шахмал түлш	44.5	150.0	6,675,000.0	90.0	4,005,000
Үртсэн шахмал түлш	10.5	120.0	1,260,000.0	80.0	840,000
НИЙТ	55.0		7,935,000.0		4,845,000

(Эх сурвалж: НАЧА 2011)

Зорилтот хязгаарлалтын бүсийн түлшний нөхцөл байдалд хангагдаж буй түлшний хомсдол хамгийн их нөлөөлсөн. Боловсруулсан түлшний хомсдолоос шалтгаалан улмаар айл өрхүүд түүхий нүүрс хэрэглэж эхэлсэн юм.

Нэг гол асуудал нь Засгийн газар нь хагас коксжсон түлшийг шахмал бус хэлбэрээр хүлээж авахгүй байгаа явдалтай холбоотой юм. НАКО энэхүү хагас коксжсон нүүрс нь НАЧА-гийн стандартуудад нийцэхгүй байгаа ба хот МАК-ийн энэ төрлийн нүүрсийг хүлээж авахгүй байгаа гэж мэдээлж байсан юм. Энэ асуудлыг ЦАС шийдвэрлэх ёстой юм. Компанийн удирдлага хэлэхдээ НАКО нь Баянгол дүүргийн ойролцоогоор 100 айл өрхөд хагас коксжсон түлшний чанарын хэд хэдэн судалгаа хийсэн байна. 68 айл өрхөөс 80% нь сэтгэл хангалуун байсан ба 10% түлшийг хэрэглэж болохуйц гэж мэдээлжээ. Тэд үр дүнгээ ЦАС ба НАЧА-тай хуваалцсан байна.

Нийлүүлэлт

Туршилтын хөтөлбөр хэрэгжиж буй газрын оршин суугчид тэдэнд учирч буй хамгийн том бэрхшээл нь нийлүүлэлтийн хомсдол гэж санал нэгтгэйгээр хариулсан юм. Нийлүүлэлт 12 %-тай байсан учир түүхий нүүрсний хориг бүрэн хэрэгжээгүй. 2011 онд хоёр түлшийг тээвэрлэлтийн нэгтгэсэн дүнгээр 18% байсан ба нийт нийлүүлсэн хэмжээ нь 5,287 тонн юм.

Үртсэн шахмал түлш үйлдвэрлэгчид хэлэхдээ нийлүүлэлтийг хангахад учирч байгаа гол саад нь өвлийн улирал дахь үнсний хомсдол мөн өвөл ажиллах боловсон хүчний дутагдал юм. Ирээдүйд эдгээр асуудлуудыг тоног төхөөрөмж ба төлөвлөгөөг сайжруулах мөн гэрээг эртнээс байгуулах замаар бэлтгэлийг хангах зэргээр шийдэх боломжтой юм. Энэ нь үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэлээ эртхэн эхлэж мод бэлтгэлийн үйлдвэрүүдтэй хангалтай хэмжээний үртэс авах гэрээг байгуулах боломжийг олгоно.

Хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчид техник, технологийн асуудал ба үнийн инфляци зэргийг гол саад гэж үзэж байгаагаа дурьдсан.

Хадгалалт

Агуулах түрээслэх шаардлага ба хэрэгцээтэй цар хүрээг дахин авч үзэх шаардлагатай. Бодит байдал дээр тээвэрлэлтийг компани түлшээ шууд төмөр замын өртөөнөөс авдаг шинэ нөхцөл үүсээд байна. Энэ байдал нь түүхий нүүрсийг түгээхтэй яг байдлаар явагддаг. Багануурын нүүрсний уурхай нь түүхий нүүрсээ авчирсан даруйдаа борлуулдаг. Агуулах түрээслэх зардлыг хасах нь Засгийн газарт хэмнэлттэй.

Хадгалалтын нийт зардал нь 43,500,000 төгрөг байгаа ба ба ялангуяа зорилтот бүлгүүд ихэнх үед нийлүүлэлтийн хомсдолд ордог зэргээс үзэхэд эдгээр агуулахууд бүрэн ашиглагдахгүй. Баримтыг авч үзвэл хадгалалтын дундаж үнэ нэг тоннд 790 төгрөг байна.

Тээвэрлэлт

2011 – 2013 оны туршилтын хөтөлбөрт зориулан нэг л тээвэрлэгч компанитай гэрээ байгуулсан юм. Үүнд нэг л гэрээлэгчтэй харьцах, хяналтын зардлыг багасгах зэрэг зарим нэгэн илэрхий давуу талтай. Жишээлбэл тээвэрлэлтийн компанийн хэрэглэсэн ба боловсруулсан түлшний хөтөлбөр сөргөөр нөлөөлөөд байгаа бие даасан тээвэрлэгчид, борлуулагчдад тулгуурласан уламжлалт системтэй холбоотойгоор судлах шаардлагатай. Тээвэрлэлтийн төсөв 2011-2012 өвлийн хүйтний үед 367 сая төгрөг байв.

Үнэ ба зардал

Өнгөрсөн өвлийн байдлаар ачааны машинтай нэг тонн түүхий нүүрсний үнэ 70,000-85,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан юм Гэвч түүхий нүүрсийг жижиглэнгээр найман кг-аар нь худалдан авахад үнэ нь өсч нэг тонн нь 162,500.- 187,500 төгрөгт хэлбэлздэг. Үртсэн шахмал түлш нэг тонн нь 120,000 төгрөг байдаг. Шаардлагатай татаасын түвшин хэрэгжиж байгаа мөн түлшний бага хэрэглээг авч үзэн хамгийн бага орлоготой өрхөд чухам аль түлшийг худалдан авах боломжтой байгаа мөн аль чанартай, өндөр илчлэгтэй түлш нь бага хэрэглээг бий болгож байгаа талаар судлах нь зүйтэй.

Нэг тонн ба найман кг ууттай түлшний үнийн ялгааг авч үзэх шаардлагатай. Татаасаар олгогдож буй нэг тонн хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлшийн нэг тонны үнэ нь түүхий нүүрсний нэг тоннын үнэтэй маш ойролцоо байгаа юм. Найман кг-ын ууттай түүхий нүүрсний үнийн түвшинтэй харьцуулахад татаас олгогдож байгаа цэвэр түлш нь хамаагүй бага үнэтэй байгаа. Савлагдсан түүхий нүүрсний үнийн дүн нилээд өндөр байгаа нь олон тооны завсрын борлуулагчдын оролцооноос шалтгаалсан байна. Татаасын түвшинг судалж байх үед нэг уут бүхий түлшний үнийг татаасын түвшинг тогтоох жишиг гэж тогтоох нь зүйтэй.

Хүснэгт 4. Түүхий ба хагас коксжсон нүүрсний харьцуулалт (төгрөгөөр)

	Нэг тонны зах зээлийн үнэ	Татаасар олгогдож буй нэг тонны үнэ	Нийт нэг тонны найман кг-ын савлагаатай уутны үнэ	Нэг тонн үзүүлэх татаас	Найман кг-ын савлагаатай нэг уут
Багануурын түүхий нүүрс	70,000*	70,000	560	0	1300
Налайхын түүхий нүүрс	85,000	85,000	680	0	1500
Алаг толгойн түүхий нүүрс	85,000	85,000	680	0	1500
Үртсэн шахмал түлш	120,000	80,000	640	40,000	тодорхойгүй
Хагас коксжсон нүүрс	150,000	90,000	720	60,000	тодорхойгүй
Татаас олгогдоогүй SCC	150,000	тодорхойгүй	1200	тодорхойгүй	тодорхойгүй

* Багануур уурхай нь улсын өмч учир Засгийн газар үнийн түвшинг тогтоодог ба энэ шууд зах зээлийн үнийн түвшингээс илүүтэйгээр түүний оронд зах зээл дээрх тогтмол үнийн тухай ярьж байсан юм. Засгийн газар ман түүхий нүүрсний дээд үнийг тогтоодог байна.

Хүснэгт 5. Боловсруулсан түлшний татаас олгосон зардлын задаргаа (төгрөгөөр)

1 тонны үнэ	Тээврийн үнэ ⁵	Агуулахын үнэ ⁶	Түлш ба худалдан авалтад шаардлага тай зардал	Борлуулагчдын төлбөр	Зах зээлийн үнэ	Татаастай үнэ
Үртсэн шахмал түлш	3200	850	126,000	6,000	120,000	80,000
Хагас коксжсон нүүрс	3200	850	156,000	6,000	150,000	90,000

Хүснэгт 6. ЦАС-гийн 2011 онд боловсруулсан түлшид зарцуулсан зардал (төгрөгөөр)

	Төлөвлөгдсөн	Зарцуулсан
Хагас коксжсон нүүрс	3,400,000	3,342,000
Үртэс	440,000	412,000

2-р цахилгаан станц нь өөр өөр нөхцөл байдлын дор үйл ажиллагаа явуулж байна. Станц нь түүхий нүүрсийн нэг тоннын үнэ нь 23,000 төгрөгөөр авч байгаа ба ийм учраас уг компани нь давуу талтай байна. Учир нь бусад үйлдвэрлэгчид нүүрсээ Шарын голын нүүрсний уурхайгаас нэг тонныг нь 50,500 төгрөгөөр худалдаг авч байна. Энэ тэгш бус байдлыг Засгийн газрын түвшинд авч үзэн шийдвэрлэх нь зүйтэй юм.

Боловсруулсан түлш хэрэглэгчид

Төслийн зүгээс боловсруулсан түлш үйлдвэрлэгчидтэй олон нийтийн зөвлөлдөөн хийсэн юм. Үүгээр 2011-2012 онуудын системийн хамгийн гол саад бэрхшээлээр түлшний нийлүүлтийн хомсдолыг тодорхойлсон юм. Хүмүүсийг түлшийн бэлэн нөөц, болзошгүй хомсдол ба хүлээлтийг хугацаануудын талаар зөв, тодорхой мэдээллээр хангадаг мэдээллийн систем бий болгох нь зүйтэй юм.

2.2. Гол санал зөвлөмж**1. Хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчдэд зориулсан урт хугацааны дэмжлэгийн хөтөлбөрийг Нүүрсний үндэсний хөтөлбөртэй нэгтгэж өгөх**

- Засгийн газар үндэсний нүүрсний хөтөлбөр боловсруулж байгаа тул хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчдэд зориулсан урт хугацааны дэмжлэгийн хөтөлбөрт тусгах боломжтой юм.
- Налайхын уурхайн хаагдах тохиолдолд эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэсэн уурхайн хаалтын болон амжиргааны тогтвортой байдлыг хангах хөгжлийн нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Үртсэн шахмал түлшний үйлдвэрлэгчидтэй холбоотойгоор тусгайлсан төрийн бодлого боловсруулах

2. Боловсруулсан түлшний талаарх улсын стандартыг дахин авч үзэх:

- Стандарт нь түлшний чанарын олон талыг хамруулан оруулсан байх
- Хагас коксжсон нүүрс/үртсэн шахмал түлшний холимог хэрэглээг стандартуудаар шийдвэрлэх

⁵Энэ зөвхөн ерөнхий тоо учир нь 2012 оны нийт зардал одоогоор тодорхойгүй байна.

⁶Дээрх харна уу.

- Шахмал түлшний эрүүл мэнд, байгаль орчны нөлөөллийг судлах, үүнтэй холбоотойгоор шахмал түлшний орц найрлагын стандартыг шинэчлэн өөрчлөлт оруулах

3. Түлшний түгээлтэд зориулан дэлгэрэнгүй тооцоолол ба төлөвлөлтийн загвар боловсруулах үүндээ бусад түлшн худалдаанд гарах хувилбарыг тооцож оруулах

- Энэ загвар нь боловсруулсан түлшний бүх төрлүүдийг зэргийг хамрах ба батлагдсан үйлдвэрлэлийн хүчин чадалд тулгуурлан бүсийг тогтооно. Боловсруулсан түлшний хэрэглээг өргөжүүлснээр өсөн нэмэгдэх буй хүчин чадлыг зохицуулахаар нэмэлт бүс байгуулж болох юм. Энэ загвар нь нэмэлт боловсруулсан түлш бэлэн болоход зориулсан нэмэлт хувилбарыг мөн боловсруулах нь зүйтэй.
- Түүхий эдийн үнийн болзошгүй өсөлт, санхүүгийн болон улс төрийн эрсдэл, өвлийн хэт хүйтрэл зэргийг тодорхойлохоор эрсдэлийн нарийвчилсан судалгааг багтаах хэрэгтэй
- Хадгалалт ба тээвэрлэлтийн загварыг түүхий нүүрсний тээврийн системтэй харьцуулан судлах

4. Боловсруулсан түлшний түгээлтийн татаасын хувилбаруудыг судлах

- Нарийвчилсан тооцоолол нь татаасын хуваарилах хамгийн оновчтой аргыг авч үзэх шаардлагатай. Худалдан авах чадамжийн тухай судалгаа нь бага орлоготой айл өрхүүдийн санхүүгийн хүчин чадлыг тэдгээрийн түлшний одоогийн зарцуулалт ба боловсруулсан түлш худалдан авах чадварыг харьцуулсан судалгаа хийх

5. Боловсруулсан түлшний нийт түгээлтийн сүлжээнд зориулан байгаль орчны нөлөөллийг бууруулах арга замыг боловсруулах

- Савлагаанд ашигласан материалын төрөл, тоос ба судалгааны явцад ажиглагдсан бусад нөлөөллүүдэд анхаарах ялангуяа нэмэлт арга хэмжээний хүрээнд хагас коксжсон нүүрсийг шатаахад ялгардаг үнсийг цуглуулах шаардлагатай.

2.3. Цаашдын арга зам

Халаалтанд зориулсан боловсруулсан түлш ба түүхий нүүрсийн түгээлтийг систем нь оршин суугчид ба Монгол Улсын Засгийн газарт их чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн түүхий нүүрс ба боловсруулсан түлш өвлийн хүйтнээс нийслэлийн хүн амын нэг хэсгийг хамгаалдгаас гадна нийт нийслэлийн хүн амын эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж байгаль орчинд хөнөөл учруулж байна. Түлшний худалдаа нь өчнөөн хүмүүст орлого, ажлын байр бий болгосон боловч үйлдвэрлэл ба тээвэрлэлтийн явцтай холбоотой аюулгүй байдал, байгаль орчинтой холбоотойгоор санаа зовниж байна. Уурхайн талаас харахад Улаанбаатар хотын ойр орчимд ирэн хэдэн арван жилийн турш түүхий нүүрсний хомсдол гарахгүй юм. Хагас коксжсон нүүрс зэрэг компаниуд нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэл эрхлэх нь өсөн нэмэгдэж буй хандлага байна. Гэвч нүүрс олборлолт, цаашлан нүүрсний салбартай холбоотой тодорхой бодлого алга байна.

Төрийн тогтоосон хиймэл тогтоолоор биш байгаль орчин, нийгэм -эдийн засгийн бодит зардалд үндэслэн нүүрсний олборлолт ба түгээлтэд зориулан дэлгэрэнгүй бодлого боловсруулах нь зүйтэй. Ялангуяа Налайхын нүүрсний уурхайд албан ёсны бодлого байхгүйгээс болоод нүүрсний олборлолт, худалдааг албан бус салбар ба нилээд олон тооны тархай бутархай жижиг компаниудыг зохицуулан чиглүүлэх хүндрэлтэй нөхцөлд хүрээд байна. Улаанбаатар хот нь түүхий нүүрсний эрэлтээс шалтгаалан энэ уурхайд илүү хамааралтай болох учир төмөр зам зэрэг асуудлуудыг шийдвэрлэх ёстой юм.

Боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрт хийсэн манай судалгааны хамгийн гол үр дүн бол хэрэгждэг хэлбэрийг сайжруулах шаардлагатай гэсэн асуудал юм. Үйлдвэрлэл ба түгээлтийн тооцооллыг гүйцэтгэх нарийвчилсан загвар боловсруулах шаардлагатай. Одоогийн систем нь үйлдвэрлэлийн баталгаажсан түвшинд тулгуурлаагүй. Боловсруулсан түлшний хангалттай нийлүүлэлт үгүй байсан нь 2011-2012 өвлийн туршилтын хөтөлбөрийн хамгийн ярвигтай асуудал байсан. Хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэгчид саяхан үйл ажиллагаагаа эхлүүлсэн учир нийлүүлэлтийн баталгаажсан түвшин тооцоолол их хуучныг баримталсан байх шаардлагатай ба зорилтот газрын хэмжээг үүнтэй уялдуулан зохицуулах нь зүйтэй. Хүмүүс буцаж түүхий нүүрс хэрэглээд байхааргүй тийм жижигхэн зорилтот газартай байх нь дээр.

Туршилтын хөтөлбөрөөс илүү өргөн хүрээтэй, олон жилийн турш боловсруулсан түлш үйлдвэрлэгчдийн дэмжигч боловсруулсан түлшний бодлого байх шаардлагатай. Ийм маягаар үйлдвэрлэгчдийн эрсдэлийг багасгаж болох энэ нь цаашид үйлдвэрлэлд нь хөрөнгө оруулахад түлхэц болох юм. Ирээдүйн загвар нь бүх оролцогч талуудын бодол санааг авч үзэр эрсдэлийн дүн шинжилгээг багтаасан байдаг. Туршилтын хөтөлбөр нь болзошгүй байгаль орчны нөлөөлөл, савлагааны стандартыг судалж, хагас коксжсон нүүрсний хаягдал үнсийг цуглуулах систем боловсруулах зүйтэй.

Үртэс нь ой модны салбарын дагалдах бүтээгдэхүүн ба өмнө нь ихэнхдээ ашиглагдахгүй орхигддог байлаа. Ойн тогтвортой менежмент мөрдөгдөж байгаа тохиолдолд үүнийг тогтвортой түлшний эх сурвалж гэж үзэж болно. Энэ материалыг шахмал түлш болгох боломжийг судлах зорилгоор мод бэлтгэлийн компаниуд мөн бусад ойн нөхөрлөлүүд нь одоогоор хэр их үртэс үйлдвэрлэдэг талаарх тооцоолол шаардлагатай. Магадгүй ойн цэвэрлэгээнээс гарсан хаягдал модноос үртэс гаргах талын эдийн засгийн үр өгөөжийг судлах шаардлагатай.

Хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэл нь Засгийн газрын боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс даяар их хэмжээгээр нэмэгдээд байна. Хэд хэдэн компани үйлдвэрлэлээ эхэлж байгаа ба цаашид ч энэ салбар хөгжих хандлагатай байна.

Хагас коксжсон нүүрсний эхний багц нь техникийн асуудалтай болоод байна. Энэ бодлого нь үнэ ба худалдан авах чадамжийн тодорхой механизмд тулгуурлах ёстой. Эдгээр шинэ бүтээгдэхүүнүүдийн чанарыг баталгаажуулах зорилгоор туршилтын дэлгэрэнгүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Одоогийн байдлаар үртсэн, хагас коксжсон нүүрс ба хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний талаарх Монгол Улсын үндэсний **стандартууд** боловсруулагдан гарсан.Стандартуудыг хагас коксжсон ба үртсэн шахмал түлшний холимогт зориулан боловсруулах шаардлагатай. Хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний үйлдвэрлэлд ашиглагдаж буй нэмэлт орц бүтээгдэхүүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөг судлах нь зүйтэй.

Олон нийтийн зөвлөлдөөнөөр боловсруулсан түлш ба тэдгээрийг хэрхэн ашиглах талаар **нийтэд сурталчилгаа** явуулах хэрэгцээ байгааг тодорхойлсон юм. Зуны улиралд энэ чиглэлээр өнгөрсөн хөтөлбөрийн үр өгөөжийг үнэлэх болон ирэх өвөл хэрэгжүүлэх үр өгөөжтэй стратеги боловсруулахад ашиглагдана.

Монгол Улсын байгалийн нөөц нь өөр хоорондоо маш нягт холбоотой байдаг. Эрдэс баялгийг олборлох нь хөрс, усанд нөлөөлдөг бол нүүрсийг түлэхэд Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээг дэлхийн гамшгийн хэмжээнд хүргэж байна. Бүх оролцогч талууд буюу уурхайчид, тээвэрлэгчид, борлуулагчид ба эцсийн шатны хэрэглэгч дээрх


байгаль орчин, нийгмийн асуудлыг авч үздэг байгалийн нөөцийн менежментийн нэгдсэн хандлага нь Улаанбаатар хотын халаалтанд зориулсан түлшний өнөөгийн түгээлтийг системийг сайжруулахад шаардлагатай юм.

3. Түүхий нүүрс

3.1. Оршил

Түүхий нүүрс нь өнөөдөр Улаанбаатар хотын гэр хороололд халаалт болон хоол унд бэлтгэхэд хамгийн өргөн хэрэглэгддэг эх сурвалж юм. Түүхий нүүрсний өрхийн хэрэглээнд зориулсан нийлүүлэлтийн сүлжээ нь хотын эргэн тойрон дахь нүүрсний уурхайгаас эхлэн олон тооны тээвэрлэгч, борлуулагчид, зах зээл, борлуулах цэгийг дамжин гэр хорооллын оршин суугчид хүрч байна. **(Схем 2.)** Түүхий нүүрс нь ард иргэдийг Монголын хүйтэн өвлийг давж гарах боломж олгодог боловч түүний хажуугаар нь агаарын бохирдлын ноцтой асуудал үүсгэж Улаанбаатар хотыг дэлхийн хамгийн их бохирдолтой хотуудын нэг болоход хүргэж байна.

Схем 2. Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын түүхий нүүрсний нийлүүлэлтийн сүлжээ



3.2. Нүүрсний уурхайнууд

Улаанбаатар хотод ашиглагддаг түүхий нүүрс нь голчлон хотын зүүн талд орших 2 том уурхай болох Налай ба Багануур уурхайгаас ирдэг. Түүхийн хувьд авч үзвэл Налайх уурхай нь хотын зүүн захад байрладаг ба гол нийлүүлэгч байсаар ирсэн боловч энэ байр сууриа алгуур өөрийн зүүн талд орших Багануур уурхайд алдсаар байгаа юм. (График 1). Хамгийн өргөн хэрэглэгддэг төрөл нь муу чанарын хүрэн нүүрс, түүний дараагаар битумжсэн (хар) нүүрс ордог юм. Битумжсэн нүүрс илүү өндөр хэмийн дулаан ялгаруулдаг учир гэр хорооллын оршин суугчид ашиглах дуртай байдаг юм. Налайхад их хэмжээний гар аргаар нүүрс олборлогчид байдаг мөн маш олон тооны жижиг борлуулагчид, хувь хүмүүсийг хамардаг тээвэрлэлт, худалдааны тархай бутархай, замбараагүй байдлаас шалтгаалан нүүрсний үйлдвэрлэл, тээвэрлэлт, худалдааны талаархи нэгдсэн мэдээлэл судалгаа хомс байна. Нүүрсний уурхайнууд өөрийн нүүрсийг чухам хаана эцсийн байдлаар хүрч байгаа талаар мэдэх боломжгүй байдаг юм. Сүүлийн жилүүдэд Налайхын нөөц хомсдож, үүний зэрэгцээ мөн нийлүүлэлт багасч байгаа юм. Монгол Улсад эдгээрээс гадна Өмнөговь дахь Тавантолгойн ихээхэн нөөцтэй орд газар гэх зэрэг хэд хэдэн томоохон уурхай үйл ажиллагаа явуулж байгаа боловч эдгээр нь голдуу экспортод чиглэгдсэн байдаг ба зөвхөн багахан хэмжээний хэсгийг ойр орчмын газруудад нийлүүлдэг.


Хүснэгт 7. Уурхайнуудаас Улаанбаатарт хангадаг нүүрсний төрөл ба чанар

Айл өрхүүдийн % 2007	Нүүрсний төрөл	Дулааны агууламжийн хэлбэлзэл MMBtu/тонн	Дулааны агууламжийн хэлбэлзэл ккал/кг
Багануурын нүүрс (25.3%)	Хүрэн	15-17 (9-17) ДБ: 14.7 Мж/кг	3,700 -4,000 (2,300 – 4,300) ДБ: 3,524
Налайхын нүүрс (76.0%)	Хүрэн	15-17 (9-17) ДБ: 14.7 Мж/кг	3,700 -4,000 (2,300 – 4,300) ДБ: 3,508
Алагтолгойн нүүрс (15.3%)	Битумжсэн	22-23 (21-30) ДБ: 25.9 Мж/кг	5,400 – 5,600 (5,300 -7,600) ДБ: 6,186
Шарын голын нүүрс (2.8%)	Дэд битумжсэн	ДБ: 14.7 Мж/кг	ДБ: 3,510

Эх сурвалж: ЕСБХБ/АНУ-ын Эрчим хүчний газар / Дэлхийн банк

Энэхүү ойролцоогоор тооцоологдсон нөөцөөс харахад түүхий нүүрсийг хот даяар хориглоогүй тохиолдолд Багануурын нүүрсний уурхай нь ойрын жилүүдэд Улаанбаатар хотын түүхий нүүрсний гол нийлүүлэгч байсаар байх боломжтой юм. Шарын голын уурхайн хувьд авч үзвэл хэд хэдэн том нөөц илэрсэн боловч уурхай нь олборлосон нүүрснийхээ ихэнх хэсгийг Дархан болон Эрдэнэтийн бүсэд нийлүүлдэг байна. Алагтолгойн ордын нүүрс нь мөн Улаанбаатараас бусад газруудад ихэвчлэн нийлүүлэгддэг. Налайхын уурхайн нүүрсний үлдсэн нөөц нь харьцангуй бага ба голдуу гүн хэсэгтээ үлдээд байгаа юм. (График 1.)

График 1. Улаанбаатар хотод нийлүүлэгдэж буй нүүрсний уурхайн тооцоологдсон нөөц (сая тонноор)



Эх сурвалж: Уурхайнууд болон Налайх дүүргийн захиргаа

3.3. Налайх

Налайхын уурхай нь Улаанбаатар хотын зүүн талд Улаанбаатар хотын нэг дүүрэг болох Налайх хотын дэргэд оршдог юм. Энэ хотын түүх 1920 оноос эхэлдэг бөгөөд Улаанбаатар хотын нүүрсний хамгийн гол нийлүүлэгч болсон юм. Энэ байдал 20-р

зууны төгсгөлд өөрчлөгдсөн юм. Энэ шилжилтийн эхэн үед Монгол Улсын Засгийн газар ажиллуулахад илүү хялбар, хямд төсөр учир ил уурхайн хэлбэрт төвлөрч ажиллахаар шийдсэн юм. Тэр үед Налайхын нүүрсний эхний 5-8 дахь давхаргыг ашиглаж дуусч байсан бөгөөд олон тооны хүн амь эрсэдсэн томоохон хэмжээний ослийн дараа энэхүү уурхай нэгдсэн байдлаар үйл ажиллагаагаа 90-ээд оны эхээр зогсоосон. 1994 оноос эхлэн Засгийн газар энэ нөхцөл байдлыг зохицуулахаар жижиг хэмжээний үйлдвэрлэгчдэд лиценз олгож эхэлсэн байна. Ингэж гар аргаар олборлогчид үйл ажиллагаагаа эхэлсэн билээ.

3.3.1. Нүүрсний үйлдвэрлэл

2012 оны 1-р сар гэхэд 105 лиценз эзэмшигч байсан ба үүнээс 42 нь ашиглалтын лиценз юм. Одоогийн байдлаар эдгээр 42 лиценз эзэмшигчийн 24 нь 101 цооногийн цэгт үйл ажиллагаа явуулж байна. Налайх дүүргийн захиргааны тооцоолж буйгаар 1,500 хүн уурхай дээр ажил эрхэлж байгаа бөгөөд үүнд гар аргаар олборлогчид мөн багтаж байгаа юм. Нүүрсний нөөцийн 30 сая тонн гэж тооцоолсон болно. Одоогийн байдлаар Налайхад нүүрсийг хагас коксжсон нүүрс болгон боловсруулахгүй байна.

3.3.1.1. Худалдаа ба тээвэрлэлт

Нилээд олон жижиг компани мөн түүнээс олон тооны хувь хүмүүсийг хамарсан нүүрсний тээвэрлэлт, худалдааны тархай бутархай нөхцөл үүссэн. Тиймээс Налайхын нүүрсний худалдааны нарийн тооцооллыг гаргах боломжгүй юм. Налайхаас гарах бүх тээвэрлэлт машин замаар хийгддэг. 1936 онд Налайхын төмөр зам Монголын хамгийн анхны төмөр зам болон байгуулагдсан юм. Гэвч төмөр замын доорх нүүрсийг ашиглахтай холбоотойгоор хөрс доош сууж төмөр зам эвдрэхэд нөлөөлсөн юм.

3.3.1.2. Аюулгүй байдал ба бодлогын асуудлууд

Аюулгүй байдал нь Налайхын уурхайн өнөөгийн хамгийн том асуудал юм. Саяхны нэгэн сонингийн нийтлэлд : *‘Өнөө үед Налайх дахь уурхайн амуудыг тохиолдлын байдлаар, уурхайн багуудын хооронд маш бага уялдаа холбоотойгоор ухдаг; уурхайн амуудын нэг нэгэндээ хэтэрхий ойрхон, өмнө нь байснаас илүү гүн байгаагаас болоод нурах тохиолдол илүү олон гарч байна. Олонхи тохиолдолд уурхайчид илүү зардал гэж үздэг тул аюулгүйн бэхлэгээг хийдэггүй байна.*

Түүнчлэн 2009 -2011 оны хооронд 47 хүн амь насаа алдсан ба голдуу 23-35 насны эрчүүд байсан гэж мэдэгдсэн байна. Дүүргийн захиргаа аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор зарим нэгэн арга хэмжээ авсан ба хуучин олснуудыг солих ажлыг гүйцэтгэсэн юм. Захиргаа мөн агааржуулалт ба бэхлэгээний хэрэгслүүдийг сайжруулахаар төлөвлөж байна.

Налайхын уурхайг ямар ирээдүй хүлээж байгаа нь тодорхойгүй юм⁷. Засгийн газраас говийн томоохон уурхайнуудтай холбогдон гэрээ хийх тал дээр ихээхэн анхаарал тавьсан боловч Налайх мэт газруудын осол аваар ихтэй, байгаль орчны ноцтой хохирол гэмтлээс үл шалтгаалан хойш тавигдаж байна. Уурхайг тэр чигээр нь хаах санал гарсан боловч тэнд ажилладаг хүмүүсийн тоо ба Улаанбаатартай ойрхон байдал зэргээс шалтгаалаад өөр өөр хувилбарыг судлах шаардлагатай юм. Саяхан уурхайгаас метанийн хий гаргаж авахын ашгийн талаарх ТЭЗҮ хийгдсэн ба энэ нь ирээдүйд ихээхэн орлого олох боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж

⁷ Налайхын уурхайн нөөцийн нарийвчилсан судалгаа хамгийн сүүлд 1991-1992 онд хийгдсэн бөгөөд үүгээр 58,8 сая тонн нөөцтэй хэмээн тооцоологдсон юм. Тийм ч учраас засгийн газрын одоогийн тооцооллоор нөөц 30 сая тонн байгаа ба нөгөөтэйгүүр Монголын Байгаль орчны консорциум 2010 тооцооллоор 24 сая тонн нөөцтэй хэмээж байгаа юм. (дараагийн тайлбарыг харна уу).

болзошгүй⁸ Судлагдсан нэг гарах гарц бол олон нийтийн бүлэг сайн дурын бүлэг байгуулах явдал юм. Монгол Улсын Засгийн газрын сүүлийн үед баталсан шийдвэр нь гар аргаар олборлолтыг хуулийн дагуу болгохоор зорьж байгаа бөгөөд энэ нь гар аргаар олборлогчдод лиценз эзэмшигчид болон Засгийн газартай албан ёсны гэрээ байгуулах, олон нийтийн бүлэг, нөхөрлөл байгуулах мөн аюулгүй байдлыг сайжруулах талаар арга хэмжээ авах боломж олгох юм. Налайхад амьжиргааны өөр цөөхөн хэдэн эх үүсвэр байгаа бөгөөд эдгээр нь нүүрсний уурхайгаас хараат байдлаар хөгжсөн юм. Налайхын уурхай хаагдах тохиолдолд үүний нөлөөг хөгжлийн дэлгэрэнгүй хөтөлбөрөөр шийдэх ба үүнд эдийн засаг, нийгэм, байгаль орчны өргөн хүрээний асуудлууд багтах шаардлагатай юм.

3.4. Багануур

Багануурын нүүрсний уурхай нь (Зураг 1 **Error! Reference source not found.**) 1978 онд байгуулагдсан ба Улаанбаатар хотоос зүүн тийш 130 км-ийн зайд оршдог Улаанбаатар хотын нэг дүүрэг юм. Энэ нь ил уурхай ба Монгол Улсын хамгийн том нүүрсний уурхайнуудын нэг буюу 1,700 га газрын эзэлдэг. Засгийн газар хувьцааны 75% эзэмшдэг ба дахин 25% борлуулах бодолтой байгаа боловч бүтнээр нь хувьчлана хэмээн хараахан төлөвлөөгүй байна⁹. Хувьцаа борлуулснаас олсон орлого нь уурхайн нүүрсний үйлдвэрлэлийн байгууламжуудад хийгдэх хөрөнгө оруулалтад зориулагдах юм. Уурхай нь ойролцоогоор 1,100 ажилчидтай. Уг компанийн Улаанбаатар хотод орших нэг салбар нь худалдааны томоохон хэсэг бөгөөд хот дахь нүүрсний түгээлтийг хариуцдаг.

Зураг 1. Багануурын нүүрсний уурхай



(Google Earth)

⁸ Монгол улс дахь Налайхын уурхайн газар нутагт метани олборлолт ба ашиглалтын талаарх урьдчилсан ТЭЗҮ –гийн эцсийн техникийн тайлан (2010), Монголын байгаль орчны консорциум

⁹ А.Энхбат, Багануур хувьцаат компанийн Санхүү хариуцсан захирал: Багануурын нүүрсний уурхай өөрийн хувьцааны 24% зарах магадлалтай байна (www.business-mongolia.com дээрх нийтлэл)

3.4.1. Нүүрсний үйлдвэрлэл

Багануурын нүүрсний нөөц нь¹⁰303,694,000 тонн гэж тооцоологдсон байна. Одоогийн үйлдвэрлэлийн хэмжээ болох жилийн 3,200,000 тонн мөн одоо байгаа бүрэн хүчин чадлаа авч үзвэл энэ нь дахин хамгийн багадаа 50-60 жил ажиллах боломжтой юм. Уг уурхай нь Монгол Улсын стратегийн ач холбогдолтой уурхайнуудын нэг гэж тодорхойлогдсон учир нь уг уурхай нь Улаанбаатар хот болон цахилгаан станцуудыг багтаасан төвийн бүсийн нийт нүүрсийн 65-70 % -ийг хангадаг юм.

3.4.1.1. Хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэл

Эрдэс баялаг, эрчим хүчний яам нь Багануурын уурхайн ойролцоо томоохон хэмжээний хагас коксжсон нүүрсэнд суурилсан цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа бөгөөд уг станц нь Оросын холбооны улсын технологид тулгуурлана. Төслийн санхүүжилтийн тухайд хувьцаа гаргах замаар шийдэж болох юм. Уг цахилгаан станц нь жилийн 200,000 тоннын бүрэн хүчин чадалтай байх ба 12 коксжих зуухнаас бүрдэхээр төлөвлөгдөөд байгаа юм.

3.4.2. Худалдаа

Энэ уурхайн нүүрсний үнийг түүний гол хувьцаа эзэмшигч Засгийн газар зохицуулдаг ба дээд үнийг тогтоодог юм. Уурхай ашигтай ажиллахгүй байгаагийн нэг шалтгаан энэ гэдгийг холбогдох хүмүүс дурьддаг. 2012 оны 1-р сард айл өрхүүдэд зориулсан нүүрсний үнэ нэг тонн нь 42,000 төгрөг, нам даралтын зуухнуудад зориулсан нүүрсний үнэ нэг тонн нь 33,000 төгрөг байв. Нам даралтын зууханд зориулсан нүүрсний үнэ хямд байгаагийн учир нь илүү муу чанарын нүүрс (тоос, жижиг бутархай хэсгүүдийг агуулсан) ашиглагддаг юм. Компанийн зүгээс нүүрсэнд ямар нэгэн савлагаа хийдэггүй яагаад гэвэл уг нүүрсийг бөөнөөр борлуулдаг.

Багануурын уурхай нь Улаанбаатар дахь өрх гэрүүдийн ашигладаг нийт 800,000 тонн түлшний 150,000 тонн нүүрсийг нийлүүлдэг гэж тооцоолж байгаа юм. “Багануулр илч” ХХК 70,000 тонн нүүрсний худалдааг хариуцдаг ба үүнээс 30,000 тонныг тоосгоны үйлдвэрүүдэд үлдсэн 40,000 тонныг өрх гэрүүд ба нам даралтын зуухнуудад нийлүүлдэг. Тоосго үйлдвэрлэгч компаниуд нь хүргүүлэлтийн урьдчилсан гэрээ байгуулдаг. “Багануур Илч” ХХК –нд зориулсан нүүрс нь Амгалан ба Толгойт өртөөнүүд рүү тээвэрлэгддэг. Улаанбаатар дахь түүхий нүүрсний нийлүүлэлтийн хомсдолоос үүдэн нүүрс нь ирсэн даруйдаа зарагддаг. Тээвэрлэлтийг вагон болон жижиг машинаар гүйцэтгэдэг учир нүүрсийг 0-200 мм хэмжээтэй болгон жижиглэдэг. Урьдчилсан гэрээ хийгддэггүй ба хэрэглэгчид ихэнхдээ нэг удаадаа 2-3 тонноор авдаг. Тиймээс тус компани ямар ч нүүрс хадгалах шаардлагагүй ба Улаанбаатарт ямар ч агуулах байгууламж байдаггүй юм. Үлдсэн нүүрсийг уурхайгаас вагон хөлслөдөг компани болон хувь хүмүүст уурхай дээрээс шууд борлуулдаг. Үүнийг голдуу нүүрс шаардлагатай байгаа компани ба хувь хүмүүст тэндер зарлан гүйцэтгэдэг юм.

3.4.3. Бодлогын асуудлууд

Түүхий нүүрсний түгээлтийг сайжруулахын өмнөх гол саад бэрхшээл нь уурхайн үйлдвэрлэлийг өргөтгөхөд учирч буй бэрхшээлүүд мөн уурхайнуудаас галт тэргээр тээвэрлэх боломж байхгүй байгаа зэрэг юм. Хэдийгээр үйлдвэрлэлийг ухагч машин техникийн тоог нэмэх эсвэл технологийг сайжруулах зэргээр үйлдвэрлэлийг өргөтгөх бололцоотой боловч төмөр замын тээвэрлэлтийн ерөнхий өргөтгөл хийх нь мөн үр өгөөжтэй байх болно.

Улаанбаатар хотын төвийн халаалтын системийг бараг бүхлээр нь төр хариуцдаг боловч гэр хороолол дахь айл өрхүүдийн нүүрсний нийлүүлэлтийг зохицуулдаггүй юм.

¹⁰ Үүнтэй харьцуулахад Өмнөговь дахь Таван толгойн ордын нөөц 6.5 тэрбус тонн гэж тооцоологдсон байна.

Түүхий нүүрсний хэрэгцээний талаар албан ёсны төлөвлөлт байхгүй мөн 9-р сараас дараагийн жилийнх нь 6-р сар хүртэл амьдарч буй оюутнууд гэх зэрэг их хэмжээний түр оршин суугчдтйн эргэлт хөдөлгөөнөөс шалтгаалаад хүн амын тоо бодитой тооцоологдоход хүндрэл учирч байгаа ядал юм. Багануур компанийн таван дүүргийн 840 айл өрхөд хийсэн судалгаанаас үзэхэд оршин суугчдын 48% нь гэрт амьдарч үлдсэн 52% нь байшинд амьдарч байна.

Компанийн үзэж байгаагаар ойрын ирээдүйд түүхий нүүрсийн бүрэн хориглох боломжгүй ба түүхий нүүрсний нийлүүлэлт ч төдийлөн хангалтгүй байгаа юм. Түүнхий нүүрс болон боловсруулсан нүүрсний хомсдол нь эдгээрийн оронд иргэд хог хаягдал өргөнөөр түлэхэд хүргэж байна. Хог хаягдлыг түлш болгон ашиглаж байгаад үнэлгээ хийх нь манай төслийн цар хүрээнд хальж байгаа юм. Хангалттай нийлүүлэлтээр хангахын тулд нүүрсний үйлдвэрлэлийг Улаанбаатар хотын түүхий нүүрсний хэрэгцээтэй нийцүүлэх шаардлагатай юм.

3.5. Шарын гол

Шарын голын ил нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос хойд зүгт 215 км-т, Дархан хотоос зүүн тийш 45 км-т оршдог юм. Уг замын сүүлийн 41 км нь засмал зам биш. Энэхүү уурхай нь Улаанбаатар- Эрдэнэтийг төмөр замтай холбогдсон өөрийн төмөр замтай. Шарын голын нүүрсний орд газрыг 1930-аад онд нээсэн юм бөгөөд хайгуулын ажлыг 1958-1961 онуудын хооронд Монгол-ЗХУ-ын хамтарсан үйлдвэр гүйцэтгэсэн юм. Уурхайн барилгын ажил 1962 онд эхэлсэн ба 1965 онд анхны олборлолт эхэлсэн ба 1975 онд жилийн 1.1 сая тонноос 1976 онд 2.5 сая тонн болж өссөн байна. Зөвлөлтийн санхүүгийн дэмжлэг, менежмент зогссоны дараа 1990-ээд онуудад үйлдвэрлэлийн хэмжээ багассан. 2003 онд уурхай бүрэн хэмжээгээр хувьчлагдсан ба Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэгдсэн юм. Уурхайн 70%-ыг гадаадын (Орос) компани эзэмшдэг. Уурхай дахин хэдэн арван жилийн турш ажиллахаар тооцоологдсон ба одоогоор 374 сая тонн нөөцтэй гэж тооцоологдоод байна (2012 оны 1-р сард нэг томоохон нэмэлт орд газар олдсон нь батлагдсан ба тооцоологдоод байсан нөөцийг хоёр дахин нэмэгдүүлсэн юм.) Ойрын жилүүдэд хүчин чадал жилд 0.6 сая тонноор нэмэгдсэн байна.¹¹ Сүүлийн үед шинэ орд газруудын зураглал хийгдсэн ба компани хоёр дахь уурхайн амаа нээхээр төлөвлөж байна.

Лиценз эзэмшигч компани нь Шарын гол JSC юм. Нүүрсний боловсруулалтыг боловсронгуй болгох тусгай компани Шарын гол Энерго ХХК байгуулагдсан. Эдгээр хоёр компани нь нэг нэгнээсээ ихээхэн хамааралтай ба нэг нэгнийхээ хувьцааны хэсэг хувийг харилцан эзэмшдэг юм.

Уг уурхай нь Дарханд суурилсан компаниуд болох НАКО ба Шарын гол Энержи ХХК-ын хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэлд зориулан 2011 онд нүүрс борлуулсан юм. (Хүснэгт 8 **Error! Reference source not found.**) Үүний дараагаар Шарын голын уурхай нь үнээ нэмэх шаардлагатай болсон ба дээрх хоёр компани хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэлдээ зориулан нүүрс худалдан авахаа зогсоосон юм.

Хүснэгт 8. Шарын гол JSC-ны үйлдвэрлэсэн түүхий нүүрсний хэрэглээ

2011 онд хийгдсэн нийт үйлдвэрлэл	370,000 тонн
НАКО ба Шарын гол Энержи ХХК	22%
Дархан ба Эрдэнэтийн цахилгаан станцууд	58%
Дархан Цемент ба Төмрийн үйлдвэр	15%
Жижиг айл өрхүүд/жижиглэн худалдаа	5%

Нүүрсний өндөр үнээс болоод Улаанбаатар хотод борлуулж байгаа тохиолдолд компаниуд өөрсдийн бүтээгдэхүүнүүдээ татаасын хөтөлбөрт хамруулдаг ба одоо үед

¹¹ <http://sharyngol.com/background>

хагас коксжсон нүүрс үйлдвэрлэхдээ Шарын голын нүүрсийг хэрэглэх нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй биш байгаа юм. Шарын гол JSC нь өргөтгөлөө дууссаны дараагаар нүүрсийг экспортод гаргах зорилгоор ойрын ирээдүйд нүүрс угаах байгууламж барихаар төлөвлөж байгаа юм. Үүний дараагаар тэд өөрсдөө хагас коксжсон нүүрс үйлдвэрлэж эхэлж болзошгүй юм. Шарын голын уурхайн аль ч нүүрсийг уурхайн зүгээс савладаггүй. Үүнийг бөөнөөр нь задгай байдлаар борлуулдаг.

Хүснэгт 9. Шарын гол JSC Нүүрсний үнэ (2012 оны 1-р сар)

Цахилгаан станцууд (тогтмол)	26,275 төг
Үйлдвэрүүд (үүнд хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчид багтна)	50,500 ¹² төг
Бусад жижиг хэрэглэгчид	50,000 төг

Уг компанийн үзэж байгаагаар нэг томоохон асуудал бол хагас коксжсон нүүрсний төрөөс тогтоодог ба энэ нь ашиг олох боломжийг хязгаарладаг явдал юм. Хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэлийн илүү өргөжүүлэхийн тулд нийт үйлдвэрлэлийн сүлжээг дахин шинэчлэх шаардлагатай ба үүнд үнэ ч гэсэн багтах юм. Хэрэв үнийн асуудлыг өөрчилж чадвал Шарын голын уурхай нь ирээдүйд зөвхөн хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэлд зориулсан нүүрс нийлүүлэх юм. Одоогоор Эрдэнэт ба Дарханы бүсийн түүхий нүүрсний хэрэгцээ нь уурхайн үйлдвэрлэж буй нүүрсийг тэр чигээр нь ашиглахаар хэмжээнд аль хэдийн хүрээд байгаа билээ.

3.6. Алагтолгой/Элдэв

Алагтолгойн орд нь Дорноговь аймагт Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 330 км-ын алсад Чойроос зүүн урд зүгт 40 км-ын зайд мөн хамгийн ойрын төмөр замын өртөө болох Олон овоотын өртөөнөөс 21 км-ийн зайд оршдог. Нөөцийг нилээд хэдэн жилийн өмнө 51 сая тонн гэж тооцоолсон юм. Одоогийн нөөц нь 50 сая тонноос бага байх ёстой боловч сүүлийн үеийн баримт байхгүй юм.

Ордын хайгуулын лицензийг хэд хэдэн компани эзэмшдэг ба үүнд Даланжаргалан сумын Элдэвийн ил уурхайг ажиллуулдаг Монголын Алт Корпораци(МАК) багтана. Тэдний нүүрс нь 6,000-7,000 ккал/кг илчлэгтэй учир сайн чанарын нүүрс гэж тооцогддог. МАК хагас коксжсон нүүрсний үйлдвэр барьж байгуулсан ба үүнийг жилийн 75,000 тонны хүчин чадалтай болгохоор өргөтгөл хийж байна. Энэ нүүрсийг Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт хэрэгжиж буй боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрт зориулан нийлүүлдэг юм.

Уг уурхай жилд 500,000 тонн нүүрс үйлдвэрлэдэг ба дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлдэг. Уурхайн гол үйлчлүүлэгчид нь Эрдэнэтийн уул уурхайн корпораци, Хөтөлийн Цемент, шохойн үйлдвэр, Дарханы цахилгаан станц, Улаанбаатар төмөр зам ба Дарханы төрөмлөгийн үйлдвэр зэрэг юм.

Элдэвийн уурхайн нүүрс нь газар дээрээ нэг тонн -31,000 төгрөгөөр (НӨТ-гүй) борлуулагддаг. Олон-Овоотын төмөр замын өртөөн дээр үнэ 33,000¹³ төгрөг байдаг. Улаанбаатарт айл өрхүүдэд нийлүүлэгддэг сайн чанарын түүхий нүүрсний үнэ нь нэг тонныг нь 90,000 төгрөгөөр борлуулагдаж байгаа Налайхын нүүрснээс илүү өндөр байгаа юм.. Мөн Элдэв/Алагтолгойн уурхайгаас Улаанбаатарт нийлүүлдэг түүхий нүүрсний хэмжээ нь хязгаарлагдмал юм.

¹²Шарын гол JSC нь 2011 онд НАКО-д 924.38 тонн нүүрс нийлүүлсэн ба үүнээс 132.26 тонныг 33,000 төг (НӨТ орохгүйгээр), мөн үлдсэн хэсгийг үнэ нэмсэнээс болоод 50,050 төг (НӨТ оруулан) худалдаалсан байна. Шарын гол энергийн хувьд нийт 496.22 тонныг худалдаалсан ба үүнээс 18.18 тонныг 33,000 төг үлдсэнийг 50,050 төгрөгөөр худалдаалсан юм.

¹³МАК-ын нийлүүлж буй үнийн түвшин, 2012 оны 2-р сарын 2

4. Боловсруулсан түлш

Улаанбаатар хотын ойр орчмын газар нутаг дахь боловсруулсан түлшний үйлдвэрлэл ба түгээлт нь зөвхөн сүүлийн жилүүдэд хийгдэж эхэлсэн юм. Судалгааны үеэр Засгийн газрын туршилтын хөтөлбөрөөс гадуур цөөхөн тооны боловсруулсан түлш борлуулагдаж байлаа. Хамгийн гол хэрэглэгдэж байгаа түлш нь үртсэн шахмал түлш, хагас коксжсон нүүрсэн шахмал түлш ба хагас коксжсон түлш юм. Засгийн газрын туршилтын хөтөлбөрийн хүрээнд эдгээр түлшнүүдийн түгээлтийн систем нь үйлдвэрлэгчдээс тохирсон үнээр худалдан авч, Улаанбаатар хотын Сонсголон, Амгалан, Эрдэнэтолгой, Энхжин зэрэг дөрвөн газруудад байршилтай найман агуулах уруу тээвэрлэснээр эхэлдэг. Нийслэлийн агаарын чанарын алба нь (НАЧА) эдгээр түлшийг бүртгэж, агуулахад хүлээж авахыг хариуцдаг. Орон нутгийн нэг компани боловсруулсан түлшийг дээрх найман агуулахаас Баянгол дүүргийн долоон хорооны 14 борлуулах цэг рүү тээвэрлэх ажлыг гүйцэтгэхээр ЦАС-тай гэрээ байгуулсан юм. Тийм ч учраас жижиглэнгээр борлуулагчдад хүргэх ажлыг энэ компани хариуцаж байна гэсэн үг юм. Жижиглэнгийн худалдааг тухайн газрын борлуулах цэгүүд хариуцдаг. Борлуулах цэгүүдийн үйл ажиллагаа ба хэрэглэгчид боловсруулсан түлшийг хүлээж авах талаар дэлгэрэнгүй мэдээллийг 5-р бүлгийн Баянгол дүүргийн олон нийтийн зөвлөлдөөний хэсэгт дурьдсан болно. Энэ бүлэг нь үйлдвэрлэгчдээс хэрэглэгчид хүртэлх нийлүүлэлтийн сүлжээг голлон авч үзсэн юм. (Схем 3.)

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн дагуу нийслэлийн Засаг дарга түүхий нүүрс хязгаарлах бүс тогтоох зорилгоор 351 тоот захирамж ба А-116/361 тоот тушаалыг баталсан юм. Хотын даргын шийдвэр ба түүний дараа батлагдсан захирамжийн дагуу Баянгол дүүргийн нийт долоон хорооны ойролцоогоор 11,000 айл өрхийг нүүрс түлэхийг хориглосон ба Засгийн газрын их хэмжээний татаасын үр дүнд хямдруулсан үнээр нийлүүлэгдэж буй боловсруулсан түлшийг тодорхой хэмжээнд хэрэглэж байна.

4.1. Үртсэн шахмал түлш

4.1.1. Үйлдвэрлэгч байгууллагуудын дүгнэлт

Үртсэн шахмал түлш нийлүүлэхээр НАЧА нь нийт долоон үйлдвэрүүдтэй гэрээлсэн юм. Эдгээр үйлдвэрүүд нь Сэлэнгэ ба Булган аймгуудын мод бэлтгэдэг газруудад байрлаж байгаа тул эдгээр газруудад их хэмжээний үртэс гардаг. Үйлдвэрүүдийг Хүснэгт 10. Үртсэн түлш нийлүүлж буй аж ахуйн нэгжүүд 10-д жагсаан харуулав.

Хүснэгт 10. Үртсэн түлш нийлүүлж буй аж ахуйн нэгжүүд

Компани	Байршил
ТАРА ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Хайрхан Буянт	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Хүслэн Өлзий ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
Голден блейз ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон
“Үртсэн шахмалтүлшнийүйлдвэр” НӨҮГ	Булган аймаг, Хялганат тосгон
Теноте ХХК	Булган аймаг, Хялганат тосгон
Өлзий Төв ХХК	Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон

Энэхүү үйлдвэрүүдийг сонгон шалгаруулахдаа нэг сард 100 тонн хүртэл бүтээгдэхүүн гаргах боломж гэсэн шалгуурыг авч үзсэн болно. Үйлдвэрлэгч нь тонн бүрийг 120,000 төгрөгөөр хүлээн авдаг. Энэ үнэнд үйлдвэрлэгчдээс Улаанбаатар хот дахь агуулах руу тээвэрлэх тээврийн зардал багтдаг. ЦАС нь 2011-2012 –д Баянгол дүүрэгт үртсэн шахмал түлш нийлүүлэхэд зориулан 450,000,000 төгрөгийн төсөв хуваарилсан юм. Хүснэгт 11-т харуулсан мэдээллээс үзвэл бодит үйлдвэрлэл гэрээлсэн хэмжээнээс ихээхэн доогуур байгаа юм. 2011 оны 12-р сарын 31-ний мэдээллээр тухайн өдөр хүртэл үйлдвэрлэх шаардлагатай хэмжээний 35%- ийг (7,434 тонноос 2,646 тонн) нийлүүлсэн байна. 2011 оны үйлдвэрлэлийн хэмжээнээс үзэхэд 2012 онд зорилтот хэмжээндээ хүрэхгүй мэт харагдаж байна. (Хүснэгт 12)

Хүснэгт 11. Үртсэн шахмал түлшний нийлүүлэлт 2011 оны байдлаар

Байгууллага	6-р сар		7-р сар		8-р сар		9-р сар		10-р сар		11-р сар		12-р сар	
	ТОНН		ТОНН		ТОНН		ТОНН		ТОНН		ТОНН		ТОНН	
	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт
ТАРА ХХК	90	132	90	62	90	130	90	129	70	59,3	70		70	
Хайрхан Буянт ХХК	180	180	180	122	180	124	180	130	144	60	144	60	144	0
Хүслэн Өлзий ХХК	90	61,7	90	64,8	90	131	90	66	60	69,8	56	60	56	0
“Үртэс шахмал түлшний үйлдвэр” НӨҮГ	500	42,2	500	168	500	126	500	254	500	146	500		500	
Теноте ХХК	120	0	120	120	120	58	120	0	120	0	120	60	120	
Өлзий ТөвХХК	120	60,2	120	0	120	61,2	120		120		120		120	60

(НАЧА 2011)

Хүснэгт 12. Үртсэн шахмал түлшний үйлдвэрлэлийн 2012 оны төлөвлөгөө

№	Байгууллага	1-р сар		2-р		3-р сар		4-р сар		5-сар	
		Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт
1.	ТАРА ХХК	70		70		70		70		0	
2.	Хайрхан Буянт ХХК	144	60	144		144		144		0	
3.	Хүслэн Өлзий ХХК	56	60	56		56		56		0	
4.	“Үртэс шахмал түлшний үйлдвэр” НӨҮГ	500		500		500		500		0	
5.	Теноте ХХК	120	0	120		120		120		0	
6.	Өлзий ТөвХХК	120		120		120		120		0	

(НАЧА 2011)

Үйлдвэрлэгчид гэрээний хэрэгжилтээ биелүүлж чадахгүй байгаад хэд хэдэн шалтгаан байна. Эдгээр нь:

- Үйлдвэрийн тоног төхөөрөмж муудсан үүнээс болоод өвлийн хүйтэн улиралд гацаж саатан ажиллагаа нь удааширсан (Хайрхан Буянт ХХК);
- Өвлийн улирлаас шалтгаалан түүхий эдийн олдоц муудсан (бүх компаниуд);

- Өвөл хүйтний улиралд үйлдвэрт ажиллах хүн хүч дутмаг болдог.

Хэдийгээр эдгээр шалтгаан нь хамгийн хүйтэн 12, 1-р саруудад хамаатай боловч бусад саруудад үйлдвэрлэлийн хэмжээ чухам яагаад доогуур байгааг бүрэн тайлбарлахгүй байгаа юм.

2011 оны 6-р сараас 9-р сарын хоорондох хугацаанд үйлдвэрлэл төлөвлөгдсөн хэмжээний 55%-д хүрсэн байв. Үйлдвэрүүд нь зуны саруудад харьцангуй сайн ажилладаг боловч мөн тэр саруудад тоног төхөөрөмжийн хүчин чадал багасдаг гэдгийг ихэнх үйлдвэрүүд хэлж байсан юм. Энэ нь сайн засвар үйлчилгээ үгүйгээс болж байгаа эсвэл бусад хүчин зүйлээс шалтгаалж байгаа эсэх нь тодорхойгүй байгаа юм.

Өмнө нь модны үйлвэрүүд түүхий эдээ үнэ төлбөргүй нийлүүлдэг байсан. Гэвч сүүлийн үед Түнхэл тосгон дахь модны үйлдвэрүүд 1 тонныг 5000-8300 төгрөгөөр нийлүүлдэг болсон байна. Түүхий эдийн энэ нэмэлт зардал нь цаашид үртсэн түлшний үнийн өсөлтөд нөлөөлж болзошгүй юм.

4.1.2. Үйлдвэрүүдийн байршил

4.1.2.1. Сэлэнгэ аймаг, Түнхэл тосгон

Түнхэл тосгон нь (Зураг 2.) хувийн модны үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулдаг мод бэлтгэлийн томоохон тосгон юм. Энэхүү тосгонд үртсэн түлш боловсруулагч дөрвөн компани бий. Үртсэн шахмал түлш ба бэлтгэсэн модыг Улаанбаатар руу ачааны машин эсвэл галт тэргээр тээвэрлэдэг. Түнхэлд үйл ажиллагаа явуулж байгаа шахмал түлш үйлдвэрлэгчид нь:

- Өлзий Төв ХХК
- Хүслэн Өлзий ХХК
- Хайрхан Буянт ХХК
- ТАРА ХХК

Түнхэл тосгон дахь хамгийн том үйлдвэр нь Хайрхан Буянт юм. Энэ компани нь 2011 оны 6-р сараас 9-р хүртэлх хугацаанд сар бүр 180 тонн, 10-р сараас 4-р сар хүртэл 144 тонн шахмал түлш нийлүүлэхээр төлөвлөсөн. Гэвч одоогийн байдлаар энэ хэмжээндээ хүрээгүй байна. 2011-2012 оны өвөл нийт 1728 тонн түлш нийлүүлэгдэх ёстой байв. Гэрээний эхний 4 сарын турш 616 тонн (86%) түлш нийлүүлэгдсэн боловч 10-р сараас 12-р сарын хугацаанд үйлдвэрлэлийн хэмжээ сарын 60 тонноор хязгаарлагдаж байсан юм. Энэ нь төлөвлөгдсөн хэмжээнээс 84 тонноор бага байгаа юм.

Зураг 2. Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь үйлдвэрүүдийн байршил



(Google Earth)

4.1.2.2. Булган аймгийн Хялганат тосгон

Хялганат тосгон дахь шахмал түлшний 2 үйлдвэр байна. (Зураг **Error! Reference source not found.3.**)

- Теноте ХХК
- “Үртэс шахмал түлшний үйлдвэр” НӨҮГ

Үртэс шахмал түлшний үйлдвэр нь улсын хамгийн том үйлдвэрүүдийн нэгд тооцогддог. Ас Улаанбаатараас хол оршдог учир зарим тохиолдолд боловсруулсан бүтээгдэхүүний тээвэрлэхэд хүндрэл гарах нь бий.

Зураг 3. Булган аймгийн Хялганат тосгон дахь үйлдвэрүүдийн байршил



(Google Earth)

Үртсэн шахмал түлшний үйлдвэр нь нийт 5500 тонныг нийлүүлэх буюу сарын 500тонны үйлдвэрлэх гэрээ байгуулсан юм. Гэвч энэ хүчин чадалдаа хүрээгүй байгаа юм. 2011 оны 6-р сараас 10-р сарын хугацаанд тэрээр нийт гэрээлсэн хэмжээнээс 736 тонн үртсэн шахмал түлш нийлүүлсэн юм.


4.1.3. Засгийн газрын татаас

Эдгээр долоон үйлдвэрлэгч байгуулагуудтай гэрээлсэн үртсэн шахмал түлшний нийт хэмжээ нь 10,500 тонн юм. Гэрээний дагуу Засгийн газар Баянгол дүүргийн долоон хороонд борлуулагдаж буй тонн бүрт 40,000 төгрөгний татаас олгодог. Энэ нь нийт 420,000,000 төгрөгний (Хүснэгт 13.) татаас болж байгаа юм.

Хүснэгт 13. 2011-2012 оны хооронд Засгийн газрын үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ

№.	Түлш	Түлшний хэмжээ (тн)	Засгийн газрын хөнгөлөлт (ТӨГ/тн)	Засгийн газраас хөнгөлөлт үзүүлж буй нийт хэмжээ (ТӨГ)
	Үртсэн шахмал түлш	10.500	40.000	420,000.000

Схем 3. Түлшний нийлүүлтийн сүлжээ



4.2. Боловсруулсан нүүрсэн түлш

Боловсруулсан нүүрсэн түлшний нийлүүлтийн сүлжээний нүүрсний уурхайгаас жижиглэнгийн борлуулагчид хүртэлх зураглалыг дээрх Схем 3-д харуулав.

4.2.1. ҮЙЛДВЭРЛЭГЧИД

4.2.1.1. Үндэслэл

Өнөөдөр нийт гурван компани нь (Хүснэгт 14) Боловсруулсан нүүрсэн түлш үйлдвэрлэж байна. 2-р Цахилгаан станц 2012 онд хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэж эхлэхээр төлөвлөж байгаа ба шаардлагатай тоног төхөөрөмж, машин техникийг суурилуулж эхлээд байгаа юм.

Хүснэгт 14. Боловсруулсан нүүрсэн түлш үйлдвэрлэгчид

Компанийн нэр	Байршил	Нийлүүлж буй түлшний төрөл
Шарын гол энерго ХХК	Дархан хот	Хагас коксжсон нүүрсэн шахмал түлш
НАКО түлш ХК	Дархан хот	Хагас коксжсон нүүрсэн шахмал түлш
Монголын алт "МАК" ХХК	Даланжаргалан, Дорноговь	Хагас коксжсон нүүрс
2-р Цахилгаан станц	Улаанбаатар	Хагас коксжсон нүүрсэн шахмал түлш

(Эх сурвалж: НАЧА 2011)

2011 оны 6-р сараас эхлэн Засгийн газар боловсруулсан түлшний хэрэглээг дэмжих зорилгоор Баянгол дүүргийн байнгын оршин суугчидад түүхий нүүрсний хязгааралт хийх хөтөлбөрт ойролцоогоор 3.1 тэрбум төгрөгний татаас олгох төлөвлөгөөтэй байлаа. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах Үндэсний шийдвэрийн дагуу Засгийн газар нь хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний нэг тонн тутамд 60,000 төгрөг, үртсэн шахмал түлшний нэг тонн тутамд 40,000 төгрөгний татаас олгож байна.

Хүснэгт 15. Боловсруулсан түлшний үйлдвэрлэлд зориулсан Засгийн газрын нийт татаасны хэмжээ

Түлшний төрөл	Түлшний хэмжээ (тонн)	Засгийн газрын татаас (төг/тонн)(мянган төгрөгөөр)	Засгийн газрын олгож буй нийт татаасын хэмжээ (төг)(мянган төгрөгөөр)
Боловсруулсан нүүрсэн түлш	44.5	60.0	2,670,000.0
Үртсэн шахмал түлш	10.5	40.0	420,000.0
НИЙТ	55.0		3,090,000.0

(Эх сурвалж: УБЦАС II)

Хүснэгт 16 нь боловсруулсан түлшний сар тутмын нийлүүлтийн төлөвлөгөөг харуулж байна. Хагас коксжсон нүүрсний төлөвлөгдсөн нийлүүлэлт нь 2011 оны 6-р сараас 12-р сарын хугацаанд 22,250 тонн байсан ба мөн 2012 оны 1-р сараас 5-р сар хүртэлх хугацаанд адил байв.

Хүснэгт 16. 2011 онд нийлүүлэгдэхээр төлөвлөгдсөн боловсруулсан түлшний нийт хэмжээ


Түлшний төрөл	2011							НИЙТ
	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
Хагас коксжсон нүүрсэн түлшний нийлүүлэлт (тонн)	1,200	3,000	3,000	3,200	2,700	5,000	4,150	22,250
Үртсэн шахмал түлшний нийлүүлэлт(тонн)	1,100	1,100	1,100	1,100	1,050	1,010	1,010	7,470
НИЙТ	2,300	4,100	4,100	4,300	3,750	6,010	5,160	29,720
Түлшний төрөл	2012							НИЙТ
	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	
Хагас коксжсон нүүрсэн түлшний нийлүүлэлт (тонн)	3,650	3,650	4,150	5,300	5,500	00	00	22,250
Үртсэн шахмал түлшний нийлүүлэлт(тонн)	1,010	1,010	1,010	00	00	00	00	3,030
НИЙТ	4,660	4,660	5,160	5,300	5,500	00	00	25,280

(Эх сурвалж: НАЧА 2011)

График 2 нь 2011 ба 2012 онуудад боловсруулсан түлш үйлдвэрлэж буй байгууллагуудыг харьцуулсан байна. Үүнээс үзэхэд Засгийн газар үртсэн түлшээс илүү хагас коксжсон шахмал түлш нийлүүлэхээр төлөвлөж байсан нь харагдаж байна. Төлөвлөгөөнд нүүрсэн суурьтай хагас коксон түлшний нийлүүлэлт нь ойролцоогоор 80% ба үлдсэн хэсэг буюу 20% нь үртсэн шахмал түлш юм.

Монголын алт компани (МАК) 2011 оны 11-р сараас эхлэн хагас коксжсон нүүрс нийлүүлж эхлэхээр гэрээ байгуулсан. Энэ компанийн гэрээлсэн нийлүүлэлтийн хэмжээ нь нийт ханган нийлүүлэлтийн 41% юм. Дараагийн хамгийн том гэрээт хэмжээ нь Шарын гол энерго компаниас нийлүүлэгдэх ба энэ нь ойролцоогоор 34% юм. “НАКО түлш”-ний эзлэх хувь нь 25% юм. 2-р Цахилгаан станц нь судалгаанд хамрагдаагүй.

График 2. Боловсруулсан түлш ба боловсруулсан нүүрсэн түлшний үйлдвэрлэлийн эзлэх хувь




(Эх сурвалж: НХХ 2011)

4.2.2. Хагас кокжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэгчид

4.2.2.1. Үндэслэл (Шахмал түлш үйлдвэрлэх талаар товч мэдээлэл)

Доорхи зураг нь шахмал түлш үйлдвэрлэх үндсэн үйлдвэрийн шат дамжлагыг харуулж байна. Эхний шатанд нүүрсийг шатаан нунтагладаг ба үүний дараагаар барьцалдуулах материал нэмж хийдэг.

Зураг 4. Шахмал түлш хийх үйлдвэрийн шат дамжлага



(Эх сурвалж: НЕДО- Шинэ эрчим хүч, аж үйлдвэрийн технологийн хөгжлийн байгууллага, 2006)


Энэ зуурмагийг шахмал түлш болгохдоо шахмал түлш үйлдвэрлэх өндөр даралттай машин техник ашиглан шахаж, хэвэнд оруулдаг. Энэхүү үйлдвэрлэлийн процесс өндөр температурт явагддаггүй боловч шахмал түлш үйлдвэрлэгч хуурай, өндөр даралтын машинаар

оролцдог. (NEDO 2006). Энэ процесс нь энгийн урсгалаар явагддаг бөгөөд энэ нь аюулгүй ба нарийн техник технологи шаарддаггүй. Шахмал түлш үйлдвэрлэх өндөр даралтын процесс нь нүүрс хэлтэрхийнүүд ба барьцалдуулагч материалыг хоорондоо хүчтэй барьцалдаж, наалдахад нөлөөлснөөр энэ процессийн үр дүнд шаталтын үед салдаггүй бат бөх шахмал түлш үйлдвэрлэгддэг. (НЕДО 2006).

4.2.2.2. Шарын гол энерго ХХК

Шарын гол энерго ХХК нь Дархан хотын аж үйлдвэрийн бүсэд, Улаанбаатар хотоос баруун хойд зүгт ойролцоогоор 230 км-т оршдог. (Зураг 5.) Уг хотын аж үйлдвэрийн бүс нь анхлан Монгол улсын хойд хэсгийн үйлдвэрлэлийн бүс хэмээн төсөөлөгдөж байв. Тийм ч учраас боловсруулсан түлшний үйлдвэр нь түүнийг эргэн тойрны суурьшмал газруудаас тусгаарладаг нилээд олон үйлдвэр ба төмөр замаар хүрээлэгдсэн байдаг.

Шарын гол энерго ХХК нь 2005 онд байгуулагдсан. Үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө тэрээр нүүрсэн шахмал түлшний технологийн талаар нилээд олон дэлгэрэнгүй судалгаа хийсэн ба Монголын олон төрлийн түүхий нүүрсний чанарт дүн шинжилгээ хийсэн юм. Компани нүүрсний сорьцуудыг Герман дахь Аахен ба Фрайберг дэх лабораториуд Хятадын Шанхсидахь Тайюаны нүүрсний лаборатори зэрэг хэд хэдэн олон улсын лаборатори руу чанарын туршилт хийлгэхээр илгээсэн юм. Лабораторийн туршилтын үр дүнг хүлээж авсны дараагаар хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний үйлдвэрлэлд зориулан Шарын голын уурхайн нүүрсийг сонгосон юм. Шаардлагатай эдийн засгийн тайлан ба ТЭЗҮ –г Шарын голын уурхайн нүүрсний чанар ба үнэнд тулгуурлан хийгдсэн юм. Шарын голын уурхай нь ойролцоогоор Дархан хотын зүүн хойд зүгт 50км-ын алсад оршдог.



Зураг 5. Шарын гол энерго

Шарын гол энерго ХХК нь хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгч байгууламж худалдан авахаар Шанкси дахь Тайюуаны Хүнд аж үйлдвэрийн групптэй 2008 онд гэрээ байгуулсан юм. Захиалсан тоног төхөөрөмжийн хүчин чадал нь 50,000 тонн түүхий нүүрсийг ойролцоогоор 25,000 тонн цэвэрлэсэн хагас коксжсон нүүрс болгож боловсруулах юм. Уг хагас коксжсон нүүрсэн дэх нэмэлт материалуудаас болоод компани 25,000 тонн суурь бүтээгдэхүүнээс ойролцоогоор 27,000 тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлш гарган авдаг. Хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний бодит үйлдвэрлэл 2011 онд эхлэхээр төлөвлөсөн.

Өнөөгийн байдлаар тус компани нь хагас коксжсон нүүрс ба хагас коксжсон нүүрс, үртэсний холимогоос бүрдсэн хоёр төрлийн түлш зэрэг 3 төрлийн цэвэр нүүрсэн боловсруулсан түлш үйлдвэрлэж байгаа юм. Уг компани Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгонд үртсэн шахмал түлшний үйлдвэр байгуулахаар төлөвлөж байгаа юм. Компаниас ирүүлсэн мэдээллээс үзэхэд хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэр одоогийн хүчин чадлаараа нь тасралтгүй ажиллахад ойролцоогоор 1 сард 600 тонн үйлдвэрлэх юм. Үртсэн шахмал түлшний хүчин чадал нь нэг сард ойролцоогоор 200 тонн байна. Хагас коксжсон нүүрс ба үртсэн түлшний холимог түлш үйлдвэрлэх нэг сарын хүчин чадал нь 200 тонноос бага байна. Компанийн инженерүүд хэлэхдээ хагас коксжсон нүүрс ба үртэсний чанар нь цэвэр үртсэн шахмал түлшнээс сайн юм. Үртсэн шахмал түлшний үнэ нь нэг тонн нь 120,000 төгрөг юм. Засгийн газар холимог хагас коксжсон нүүрс/ үртсэн түлшний үнийн түвшнийг цаашид шийдвэрлэх шаардлагатай юм.

Уг компани нь 2011 оны 6-р сараас эхлэн 2012 оны 5-р сар хүртэл 15,000 тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлш нийлүүлэхээр 2011 онд Монгол Улсын Засгийн газартай гэрээ байгуулсан юм. Гэрээний дагуу ЦАС-гаас тус компанид урьдчилгаа төлбөр болгож 450 сая төгрөг (энэ нь 3000 тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний үнэтэй тэнцэнэ) шилжүүлсэн байна.

Шарын гол энерго ХХК –ийн нийт үйлдвэрлэл нь нийт боловсруулсан нүүрсэн түлшний нийлүүлэлтийн 34% -ийг эзэлдэг(**График 2**-ийг харна уу). Гэрээний хуваарийн дагуу нийт 15,000 тонны үйлдвэрлэл хийгдэхээр төлөвлөгдсөн ба үүнээс 9,400 тонн нь 2011 онд үлдсэн 5,600 тонныг 2012 үйлдвэрлэх юм.(Хүснэгт 13)

Бодит байдал дээр 2011 оны 11-р сард зөвхөн 531 тонн нийлүүлэгдсэн байв. Хүснэгт 6-д 2011 оны 6-р сараас 12-р сар хүртэл нийлүүлэгдсэн боловсруулсан түлшний гэрээлсэн болон бодит хэмжээн дэх ялгааг харуулж байна. Шарын гол энерго ХХК –ийн хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний нийлүүлэлт үйлдвэрлэлийн хугацааны турш ихээхэн хэлбэлзсэн боловч төлөвлөсөн үйлдвэрлэлийн хэмжээндээ огт хүрээгүй юм.

Хүснэгт 17. Шарын гол энерго ХХК –ийн 2011 ба 2012 онуудын сар тутмын үйлдвэрлэл (Тонноор)

Он: 2011	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт
Гэрээлсэн хэмжээ	1,200.0	1,800	1,800	1,800	1,500	800	500	9,400.0
Бодит хэмжээ	70.5	00	93	248	120	00	00	531.5
Үлдсэн хэмжээ	1,129.5	1,800	1,800	1,552	1,380	800	500	8,868.5
Он: 2012	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	Нийт
Гэрээлсэн хэмжээ	500	500	1,000	1800	1,800	00	00	5,600
Нийлүүлсэн хэмжээ	00	00	00	00	00	00	00	00
Үлдсэн хэмжээ	500	500	1,000	1,800	1,800	00	00	5,600

(Эх сурвалж: НАЧА 2011)

Компанийн одоо хэрэглэж байгаа хагас коксжсон нүүрс боловсруулагч зуух/бойлер төстэй тоног төрөөрөмж нэмж худалдан авч өнөөгийн хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа юм. Гэвч шахмал түлшний үйлдвэрлэлийн хүчин чадлаа хоёр дахин нэмэгдүүлэхийн тулд компани шахмал түлш хийдэг машин техникээ өргөтгөх шаардлагатай ба үүнийг хамгийн ярвигтай хэсэг гэж бодож байгаа юм.

4.2.2.3. НАКО түлш ХХК

Налайхын эргэн тойронд орших түүхий нүүрс үйлдвэрлэгч 13 жижиг компани нэгдэн “НАКО түлш” ХК-ийг 2007 онд байгуулсан юм. Компанийн үйлдвэр нь Дарханд Шарын гол энерго ХХК –ийн үйлдвэртэй ойролцоо байрладаг. Компани нь 2008 онд хөрөнгийн биржид бүртгэгдсэн ба хамгийн багадаа нийт хувьцааны 30% -ийг төрийнх болгосон юм. (Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагын дагуу). Тэдний үйлдвэрлэлийн байгууламжууд 2010 гэхэд баригдаж дууссан байв. НАКО 100,000 тонн түүхий нүүрсийг 50,000 тонн хагас коксжсон нүүрс болгох хүчин чадалтай ба үүний дүнд ойролцоогоор 35,000 тонн шахмал түлш үйлдвэрлэх боломжтой. Мөн түүнчлэн компани хий ба газрын тос боловсруулдаг боловч энэ салбарт хараахан ашигтай ажиллаж эхлээгүй байгаа юм.

Эхэн үед “НАКО түлш” нь боловсруулсан түлшинд зориулан олон өөр уурхай нүүрсийг боловсруулахаар төлөвлөж байсан. Гэвч өөр өөр уурхайнуудын нүүрсний харилцан адилгүй чанараас шалтгаалан үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тогтмол чанарыг нь жигд хангах боломжгүй зүйл болсон юм. Тиймээс тус компани Шарын голын уурхайн түүхий нүүрсийг цорын ганц эх сурвалжаа болгон сонгон авсан юм. Гэвч Шарын голын уурхайн түүхий нүүрсний нийлүүлэлт нь байнгын үйлдвэрлэл явуулах хэмжээнд хүрэхгүй байгаа ба энэ НАКО-ийн үйлдвэрлэлийн хамгийн том асуудал болоод байна.

“НАКО түлш” нь 2011 оны 6-р сараас эхлэн 2012 оны 5-р сар хүртэл 11,000 тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлшийг Улаанбаатарт нийлүүлэхээр ЦАС ба НАЧА –тай гурван талт гэрээ байгуулсан ба урьдчилгаа төлбөр болгож Засгийн газраас 186 сая төгрөг хүлээн авсан юм. “НАКО түлш” нь нийт нүүрсэн суурьтай цэвэр түлшний үйлдвэрлэлийн ойролцоогоор 25 %-ийг үйлдвэрлэх юм. Гэрээний хуваарийн дагуу 2011 онд 6,850 тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлш, 2012 онд 4,150 тонн үйлдвэрлэх төлөвлөгөөтэй.

Хүснэгт 18. “НАКО түлш”-ний 2011 ба 2012 онууд дахь хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний сар тутмын нийлүүлэлт

Он: 2011	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт
Гэрээлсэн хэмжээ	00	1,200	1,200	1,400	1,200	1,200	650	6,850
Бодит хэмжээ	00	00	00	00	00	55	55	110
Үлдсэн хэмжээ	00	1,200	1,200	1,400	1,200	1,145	595	6,740
Он: 2012	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	Нийт
Гэрээлсэн хэмжээ	650	650	650	1,000	1,200	00	00	4,150
Нийлүүлсэн хэмжээ	00	00	00	00	00	00	00	00
Үлдсэн хэмжээ	650	650	650	1,000	1,200	00	00	4,150

(Эх сурвалж: НАЧА 2011)

Компанийн менежерийн хэлсэнчлэн 2010 онд 20 өдрийн дотор эхний 1,000 тонн түүхий нүүрсээ хагас коксжсон түлш болгосон байна. 2011 онд дахин 1,000 тонн түүхий нүүрсийг боловсруулжээ. Гэвч компани зөвхөн 55 тонн хагас коксжсон шахмал түлш нийлүүлсэн ба (Хүснэгт 20) ба 55 тонн хагас коксжсон нүүрсийг НАЧА-д нийлүүлсэн нь 2011 онд нийт гэрээлсэн хэмжээний 1.5% болж байгаа юм.

Нэг гол асуудал нь урьд дурьдсанчлан хагас коксжсон түлшийг шахмал бус хэлбэрээр Засгийн газраас хүлээж авахгүй байгаа явдалтай холбоотой юм. “НАКО түлш” нь энэхүү хагас коксжсон нүүрс нь НАЧА-гийн стандартуудад нийцэхгүй байгаа тул НАЧА нь МАК-ийн энэ төрлийн нүүрсийг хүлээж авахгүй байгаа гэж мэдээлж байсан юм. Энэ асуудлыг ЦАС шийдвэрлэх ёстой юм. Компанийн менежер хэлэхдээ “НАКО түлш” нь Баянгол дүүргийн ойролцоогоор 100 айл өрхөд хагас коксжсон нүүрсний чанарын хэд хэдэн судалгааг хийсэн байна. 68 айл өрхөөс 80% нь сэтгэл хангалуун байсан ба 10% түлшийг хэрэглэж болохуйц гэж мэдээлжээ. Тэд үр дүнгээ ЦАС ба НАЧА-тай хуваалцсан байна.

“НАКО түлш” гадагш экспортлох зорилгоор хагас коксжсон нүүрсийг үйлдвэрлэж эхэлжээ. Ялангуяа Засгийн газрын туршилтын хөтөлбөрийг Дархан ба Эрдэнэт рүү шилжүүлвэл Монгол Улсын хувьд энэ нь мөн маш их боломжтой гэж үзэж байгаа юм.



Зураг 6. НАКО түлш”-ний үйлдвэр ба шахмал түлш

компани нь хагас хүчин чадлаараа ажиллаж байна. Хөргөлтийн хувьд усан сан

ашигладаг боловч өвлийн улиралд хөлддөг байна. Үүнээс гадна хатаалтын шатанд хүндрэлүүд байгаа гэж мэдэгдсэн.

4.2.2.4. 2-р Цахилгаан станц

Энэхүү компани нь төрийн мэдлийнх ба Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаагаа явуулдаг. Тэд хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний үйлдвэрлэлийн шинэ систем нэвтрүүлж байгаа юм. Энэ шинэчлэл нь Засгийн газрын гэрээнд тулгуурласан ба машин техник, бусад байгууламжууд нь одоогийн цахилгаан станцын дэргэд баригдсан юм. Төслийн зохицуулагчийн хэлснээр хагас коксжсон нүүрс үйлдвэрлэхийн тулд 2 бойлерийг бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх ажил одоо явж байгаа ба шахмал түлш хийхийн тулд нэг нэмэлт үйлдвэр байгуулж байна.

Компани мөн шингэн шилний үйлдвэр барьж байгаа ба шингэн шилийг шахмал түлшийг барьцалдуулан холбох материал болгон ашиглах юм. Шингэн шилний түүхий эдийг имплртоор худалдан авах төлөвлөтэй.(Хамгийн ойрын зах зээл нь ОХУ эсвэл Хятад улс юм).

Тус компани нь бүх нүүрсээ Багануурын нүүрсний уурхайгаас нэг тонныг нь 23,000 төгрөгөөр худалдан авдаг. Энэ үнийг Улаанбаатар хотыг цахилгаан болон дулаанаар хангадаг цахилгаан станцуудад нүүрс борлуулах үнийг тогтоодог Засгийн газрын шийдвэрээр тогтоодог юм. Гэвч 2-р Цахилгаан станц нь өөр зорилгоор буюу хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэхээр нэмэлт нүүрс худалдаж авч байгаа ба цахилгаан, дулаанд ашиглах бус үүнийг боловсруулсан түлш болгож ЦАС-аар дамжуулан гэр хорооллын айл өрхүүдэд борлуулах төвлөгөөтэй байна. Тийм ч учраас уг компани нь давуу талтай байгаа.

Одоогийн байдлаар 2-р Цахилгаан станцын хийсэн зарим туршилтаас үзэхэд хагас коксжсон нүүрсний шатамхай чанар нь 14 % доогуур байгаа ба компанийн инженерүүд энэ асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа юм. Хагас коксжсон нүүрсийг үйлдвэрлэхэд оросын технологи ашиглагдаж байгаа юм. Тийм ч учраас компани туршилт хийлгэхээр түүхий нүүрсийг ОХУ уруу илгээж байгаа юм.

Үйлдвэрлэлийн байгууламжууд нь одоогоор барилгын шатандаа явж байна. 2012 оны 1-р сард эхний зуух/бойлэр бэлэн болох ба 2-р сараас 5-р хүртэл туршилт хийгдэх юм. Үйлдвэрлэлийг 2012 оны сүүлийн хагаст эхлүүлэхээр төлөвлөж байна. Бүрэн хүчин чадлаараа энэ үйлдвэр нь жилдээ 210,000 тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх ба энэ нь Улаанбаатар хотод шаардлагатай түлшний 35-40% юм. (ойролцоогоор 500,000 тонн). Агуулахад хүргүүлэхтэй холбоотойгоор тэд түгээлтийн сүлжээгээ хэрхэн зохион байгуулах талаар хараахан эцсийн шийдвэрт хүрээгүй байгаа боловч хотын захиргааны агуулахад хүргэхээр төлөвлөж байгаа юм.

4.2.3. Нэмэлт материалууд

Шахмал түлш хийхэд олон төрлийн нэмэлт материал шаардагддаг төрөл бүрийн техник ашиглагддаг. 2-р Цахилгаан станц нь I дэх нүүрсэнд хоёр гол орц бүтээгдэхүүнийг нэмж хийдэг . Эхнийх нь үнс. Үнсний орцын хэмжээ нь 10-12%. Харин шингэн шил нь барьцалдуулагч материалаар ордог байна.

2-р Цахилгаан станц нь шатамхай чанарыг хамгийн багадаа 14% -д барихыг зорьж байгаа ба ингэснээр шахмал түлш амархан асаж, тогтвортой дулаан ялгардуулдаг байна. Өөр нэгэн гол орц бүтээгдэхүүн бол барьцалдуулагч материал юм. 2-р Цахилгаан станц үүнд шингэн шил ашиглахаар төлөвлөсөн хэвээр байгаа юм. Шингэн шилийг мөн тухайн газарт үйлдвэрлэх шаардлагатай юм.

Шарын гол энерго ХХК нь шахмал түлш хийхдээ буудайн цардуулыг барьцалдуулагч материал болгон ашигладаг байна. Компанийн өгсөн мэдээллээс үзэхэд барьцалдуулагч материал нь нийт шахмал түлшний үйлдвэрлэлийн зардлын ойролцоогоор 20-25%-ыг эзэлдэг байна. Компани одоогоор түүхий эдтэй холбоотой зардлыг багасгахыг зорин ажиллаж байна. Буудайн цардуулыг Хятадаас худалдан авдаг. Тийм ч учраас импортын татвар төлөгддөг ба энэ нь буудайн цардуулын хувьд ойролцоогоор нэг тонн 100,000 төгрөг юм.


НАКО нь шахмал түлш хийхдээ Хятадын импортын цавуу ашиглаж байна. Тэд цавууны химийн найрлагын мөн гэрийн халаалтын системд ашиглахад аюулгүй эсэх талаар тодорхой мэдээлэлгүй байсан юм. Энэ цавууны орц найрлага юу болох мөн гэрийн халаалтын системд ашиглахад тохиромжтой эсэхийг тодруулах зорилгоор цаашид судалгаа хийх нь зүйтэй юм.

4.2.4. Зөвхөн хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчид

4.2.4.1. Үйлдвэрлэлийн процесс

Үйлдвэрлэгч компаниуд бүгд хагас коксжсон нүүрсээр шахмал түлш үйлдвэрлэдэггүй ба зөвхөн хагас коксжсон нүүрс байдлаар нь үйлдвэрлэгчид байна. Хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэлийн процесс дараах байдлаар явагддаг.

Түүхий нүүрсийг эргэлддэг машинд хатаадаг (10% эсвэл түүнээс бага хэмжээний гадаргын ус, 5-50мм хэлтэрхийний хэмжээ). Хатаагч машинаас гадагшилсан хий нь хийг агаарт цацахаас өмнө тоосонцрыг зайлуулах зорилгоор олон тооны эрчлүүрээр дамжин өнгөрдөг.



Зураг 7. Хагас коксжсон нүүрс боловсруулах механизм


(Эх сурвалж: NEDO, 2006)

Зураг 7-д хагас коксжуулсан нүүрс боловсруулах үйл явцыг харуулсан процесийг харуулсан хөндлөн зүсэлт юм. Энэхүү хагас коксжуулах системийн дэгдэмхийгийн хувь нь ойролцоогоор 20 байна. Түүхий нүүрсийг системийн үндсэн хэсэгт боловсруулах юм. Улмаар хагас коксжсон нүүрс нь эхний болон 2 дахь шатны циклонд газнаас ялгагдан ангилагдана.

4.2.4.2. Монголын алт корпорацн (МАК)

МАК нь Дорноговь аймгийн Даланжаргалан суманд хагас коксжсон нүүрс боловсруулдаг үйлдвэртэй ба уг үйлдвэр нь жилд 75,000 тонн үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Тэрхүү үйлдвэр нь Улаанбаатар хотоос зүүн өмнөд зүгт ойролцоогоор 330 км-ийн зайнд байдаг. (Зураг 8.) Компанийн хүлээгдэж буй бодит үйлдвэрлэлийн хэмжээ нь жилийн 60,000 тонн юм. Одоог хүртэл 2,000 тонн үйлдвэрлэгдсэн байна. МАК-ын технологи нь Шарын гол энерго компанийхтай төстэй юм. Гол ялгаа нь Шарын гол энерго зөвхөн нэг зуух/бойлэр суурилуулсан байхад МАК 3 зуух/бойлэр худалдан авсан юм. МАК нь Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас (ЕСБХБ) энэхүү үйлдвэрлэлийн төслөө эхлүүлэх зорилгоор зээл авсан. Компани түүхий нүүрсээ Дорноговь аймаг дахь Алаг толгой ордын Элдэвийн уурхайгаас худалдан авдаг.

Зураг 8. МАК-ийн хагас коксжсон нүүрсний үйлдвэрийн байршил



(Эх сурвалж: МАК 2011)

МАК нь 2011 оны 11-р сараас 2012 оны 5-р сар хүртэлх хугацаанд 18,500 тонн хагас коксжсон нүүрс нийлүүлэхээр ЦАС ба НАЧА-тай гурван талт гэрээ байгуулсан юм. (Хүснэгт 19.). Хэдийгээр компани 2011 оны 11-р сараас эхлэн хагас коксжсон нүүрс нийлүүлж эхэлсэн боловч төлөвлөгдсөн үйлдвэрлэл нь Улаанбаатар хотод зориулсан гэрээлсэн боловсруулсан нүүрсэн түлшний хамгийн өндөр хувийг илтгэж байгаа юм. НАКО түлш ба Шарын гол энерго –той харьцуулахад МАК-ын хэмжээ нь тэднийг хоёр нугалснаас ч их юм.

Хүснэгт 19-өөс харагдаж байгаачлан МАК –ийн сар тутмын нийлүүлэлтийн гэрээлсэн 2,500 – 3,000 тонны хооронд хэлбэлздэг. 2011 оны 12-р сард компани 6,000 тонныг нийлүүлсэн байх ёстой байсан боловч бодит байдал дээр 2,000 тонныг нийлүүлсэн ба энэ 33.3% л болж байгаа юм.

Хүснэгт 19. МАК-ийн 2011 & 2012 оны сар тутмын нийлүүлэлтийн гэрээлсэн хэмжээ

Он: 2011	2011		2012					Нийт
	11-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3- сар	4-р сар	5-р сар	
Гэрээлсэн хэмжээ	3,000	3,000	2,500	2,500	2,500	2,500	2,500	18,500
Бодит хэмжээ	1,000	1,000	00	-	-	-	-	2,000
Үлдсэн хэмжээ	2,000	2,000	2,500	2,500	2,500	2,500	2,500	16,500

(Эх сурвалж: НАЧА 2011)

Компани нь хагас коксжсон түлшээ Засгийн газарт нэг тонныг нь 150,000 төгрөгөөр борлуулж байгаа бөгөөд энэ нь шахмал түлш үйлдвэрлэгчдэд төлдөгтэй ижил үнэ юм. МАК-ийн тайлбарлаж байгаагаар тэдний хагас коксжсон нүүрсэн түлш нь шахмал түлшээс илүү дулаан ялгаруулдаг юм байна

Тус компани нь хагас коксжсон нүүрс үйлдвэрлэхдээ зарим бэрхшээлтэй тулгараад байгаа юм. МАК-ийн төлөөлөгч дурьдсанаар коксжуулан процессдоо давсны өндөр агууламж бүхий цэвэршүүлээгүй ус хэрэглэдэг байна. Энэ нь одоогоор Баянгол дүүрэгт нийлүүлэгдэж буй хагас коксжсон нүүрстэй холбоотой асуудлуудад хүргэж байгаа юм. Яагаад гэвэл хүмүүсийн дасаж, заншаагүй бага хэмжээний тэсрэлтээс үүдсэн дуу чимээ гаргадаг юм. Хагас коксжсон нүүрс нь асаахад илүү хүндрэлтэй (шатамхай чанарынхаа эзлэх хувиас хамаарна) ба хүчилтөрөгч хангалттай үед л их халуун ялгаруулна (агаарын солилцоо ихээр шаарддаг). Компанийн судалгаанаас үзэхэд өрх гэрүүдийн жирийн янданг ашиглан хагас коксжсон нүүрс түлэхэд агаарын урсгал хангалтгүй байсан байна.

4.2.4.3. Ашиглагдсан түүхий эд

Энэ компани шахмал түлш бус хагас коксжсон түлш үйлдвэрлэдэг тул нэмэлт орц шаардлагагүй юм. Үүнийг МАК-ийн мэргэжилтнүүдтэй уулзаж байх үед баталгаажуулсан юм.

4.2.5. Стандарт ба хууль эрхзүйн шаардлагууд

4.2.5.1. Хагас коксжсон нүүрс

Хагас коксжсон нүүрс боловсруулах талаар Монгол Улсын стандарт бий. Уг стандартыг Стандартчилал, хэмжилзүйн газар 2011 онд баталсан юм. Код нь MNS 5679-1:2011 (Хавсралт 3). Уг стандартын гол техникийн шаардлагууд нь доор заасан байна. (Хүснэгт 19).

Хүснэгт 20. Хагас коксжсон нүүрсний талаарх үндэсний стандарт - MNS 5679-1: 2011

Түлшний нэр	Нийт чийгшил, W%, дээд хэмжээ	Шатамхай чанарын эзлэх хувь, V ^{daf} %, дээд хэмжээ	Үнсний агууламж, A ^{ar} %, дээд хэмжээ	Нийт хүхэр, S _t ^{ad} , дээд хэмжээ	Калори Q ^f _e , (ккал/кг), дээд хэмжээ
Хагас коксжсон нүүрс	20	18	25	0.8	4800

(Эх сурвалж:СХГ 2011)

4.2.5.2. Шахмал түлш

Стандартчилал, хэмжилтзүйн газраас 2011 онд баталсан нүүрсэн суурь бүхий шахмал түлшний талаар засгийн газрын стандарт бий. Стандартын код нь MNS 5679:2011 Шахмал түлш үйлдвэрлэх техникийг эзэмших нь харьцангуй хүнд юм. Шарын гол энерго техникийн асуудлуудын шийдсэн гэж мэдэгдэж байгаа юм. Жишээлбэл шахмал түлшний талаар үндэсний стандартын дагуу хатуу бөх байдлын чанарын индекс нь 85% эсвэл дээш байх ёстой юм. Шарын гол энерго ХХК-ийнх 100% байгаа юм. НАКО түлш шахмалт түлш үйлдвэрлэхдээ одоо ч гэсэн бэрхшээлтэй тулгарсан хэвээр байгаа юм.

Хүснэгт 21. Шахмал түлшний талаарх үндэсний стандарт - MNS 5679: 2011

№	Түлшний нэр	Чийгшил, W%, дээд хэмжээ	Шатамхай чанарын эзлэх хувь, V ^{daf} %, дээд хэмжээ	Үнсний агууламж, A ^{ar} %, дээд хэмжээ	Илчлэг, Q ^R ₆ ,(kcal/kg), доод хэмжээ	Үйрмэгийн хэмжээ, доод хэмжээ	Хатуу бөх байдал %, доод хэмжээ
1	Нүүрсэн шахмал түлш	15	-	40	3800		80
2	Хагас коксжсог шахмал түлш	10	18	40	4500	40мм	85
3	Хагас коксжсон нүүрс	10	18	30	5500	25мм	
4	Үртсэн шахмал түлш	10	-	30	3500		80

(Эх сурвалж: СХГ 2011)

Шахмал түлшний талаарх үндэсний стандартад эрүүл мэндий ямар ч шаардлага багтаагүй юм. Тийм ч учраас компаниуд шахмал түлш хийхдээ янз бүрийн материал нэмж ашиглаж байна. Жишээлбэл НАКО нь найрлага, орц нь тодорхойгүй Хятад цавуу хэрэглэж байна, 2-р цахилгаан станц голдуу хүнд үйлдвэрлэлд ашиглагддаг шингэн шилийг нэмэхээр төлөвлөж байна. Үндэсний стандартад эрүүл мэндийн асуудлуудыг багтаан авч үзэх нь зүйтэй учир нь гэр хорооллыг оршин суугчид, айл өрхүүд гол хэрэглэгчид маань юм.


4.2.5.3. Үртсэн ба хагас коксжсон нүүрсэн холимог шахмал түлш

Хагас коксжсон нүүрс ба хагас коксжсон нүүрсэн түлшний талаарх Монгол Улсын стандарт нь боловсруулсан түлш үйлдвэрлэж буй бүх компаниудад хамаатай юм. Гэвч үртсэн ба хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний талаар үндэсний стандарт хараахан байхгүй байна. Саяхан Шарын гол энерго ХХК нь цэвэр үртсэн шахмал түлшнээс сайн чанарынх хэмээж үзэж холимог боловсруулсан түлш үйлдвэрлэсэн юм.

4.2.6. Савлагаа

Савлагаан тодорхойлсон үндэсний болон бүсийн ямар нэгэн тодорхой стандарт мөн боловсрогдоогүй байна. Тийм ч учраас компаниуд бүтээгдэхүүнийхээ сав боодолд төрөл бүрийн материал ашигладаг. НАЧА –гийн гэрээнд савлагааны материал нь 20 кг ба 40 кг-ийн түлш зөөвөрлөж болохуйц чанартай байх ёстойг заасан байдаг. Мөн түлшний бүтээгдэхүүнийг хэрэглэгчид зөөж болохуйц 20, 25, 40 кг-аар савласан байх ёстойг тодорхойлсон юм. Түүнчлэн боловсруулсан түлш үйлдвэрлэгч компаниудаас савлагаан дээрээ үйлдвэрлэсэн компани ба хаягыг тавьсан байхыг шаарддаг. (Зураг 10)

Шарын Гол энерго ХХК бүтээгдэхүүнийхээ чанарыг хадгалахын тулд хуванцар давхаргатай тусгай материалыг бүтээгдэхүүнийхээ савлагаанд ашигладаг гэж бидэнд мэдэгдсэн юм. (Зураг **Error! Reference source not found.9.**) Энэ материал нь шахмал түлшнүүдийг чийгшилээс хамгаалдаг байна. Уг савлагааны материалыг Хятад улсаас импортлодог байна. Анхлан савлагаандаа цаасан уут ашиглахаар төлөвлөгдөж байсан. Өндөр үнээс шалтгаалан компани үүнийг хэрэглэхийг хүсэхгүй байгаа юм. Шарын гол энерго ХХК нь бүтээгдэхүүнээ 20 кг-ийн уутнуудад савладаг. Улаанбаатар уруу тээвэрлэхээс өмнө бүтээгдэхүүнээ агуулахад хадгалдаг. Агуулахын хэмжээ нь ойролцоогоор 12 м x 18 м буюу 216 м² юм.



Зураг 9. Шарын гол энерго –гийн шахмал түлшний уутны нэмэлт синтетик давхарга



Зураг 10. НАКО-ийн шахмал түлшний уут

НАКО нь ус болон чийглэгийг хялбархан нэвтрүүлэх синтетик материал ашигладаг. (Зураг 10). НАКО савласан хагас коксжсон шахмал түлшээ гадаа ил задгай газар хадгалдаг учир бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй ба (Зураг 11) ялангуяа уг компанийн савлагааны материалд чийглэгээс хамгаалах хуванцар давхарга байдаггүй.

Шарын гол энерго ба “НАКО түлш” хоёулаа түүхий нүүрс ба боловсруулсан хагас коксжсон нүүрсээ гадаа хадгалдаг байна.

4.2.7.Лабораторийн туршилт ба чанарын баталгаа

НАЧА боловсруулсан түлш үйлдвэрлэгчдээс тогтмол лабораторийн туршилтын тайлан шаарддаг. Үйлдвэрлэгчидтэй хийгдсэн хэлэлцүүлгээс харахад гэрээний дагуу компаниуд чанарын мониторингийн тайланг тогтмол хугацаатайгаар хүлээлгэн өгөх шаардлагагүй юм. Гэвч НАЧА үйлдвэрлэгчдээс сар тутмын туршилтын тайлан шаардаж байгаа ба ялангуяа хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэгчдээс үүнийг хүсэж байгаа юм. Үртсэн шахмал түлш үйлдвэрлэгчид зөвхөн жилийн тайлан бэлтгэхэд өгөхөд хангалттай гэж бидэнд мэдээлсэн юм. Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ сорьцыг Улаанбаатар дахь бие даасан лабораторид өгдөг. НАЧА-гаас үзэхэд төрөл бүрийн боловсруулсан түлшний анализ хийхэд 4 лаборатори бэлэн байгаа юм.

Чанарын туршилтын шаардлагатай холбоотойгоор нэгдсэн байдал үгүй байгаа нь харагдаж байгаа юм. Жишээлбэл, Шарын гол энерго ХХК нь 5 элемент турших шаардлагатай ба үүнийг Монголд Стеварт Группын лаборатори л хийдэг. Шарын гол энергогийн үзэж байгаагаар энэ төрлийн туршилт нь зардал өндөртэй ажил юм.

Зураг 11. НАКО түлшийн савлагдсан түлшүүдийг гадаа, ил задгай газар хадгалсан байдал



(Эх сурвалж: НХХ 2011)

НАКО түлш Стеварт Группын лабораторид хагас коксжсон нүүрсний сорьцоо илгээдэггүй харин Дарханы Дулааны цахилгааны станцын лаборатори уруу чанарын шинжилгээнд бүтээгдэхүүнээ тогтмол илгээдэг.

Бие даасан лабораториор хийгдэх сар тутмын чанарын судалгааны сацуу МАК өөрийн чанарын судалгаагаа хийдэг гэж мэдээлсэн. Гэвч тэд ямар туршиж байгаа элементүүд мөн үр дүн нь төслийн багт тодорхойгүй. Учир нь туршилтын талаарх мэдээлэл нь компанийн хувийн мэдээлэл гэж үзэж байгаа юм. МАК мөн Монголын Мянганы Сорилтын Сангийн хөтөлбөрийн хүрээнд түгээгдэж буй Турк зуухнуудад (Мөнгөн брэнд) хагас коксжсон нүүрсийг ашиглаж болох эсэх талаар судалгаа хийснээ мэдэгдсэн. МАК-ын туршилт нь хагас коксжсон нүүрсийг эдгээр зуухнуудад ашиглахад

тохиромжгүй учир нь хэрэв галлах горимын дагуу дээрээсээ доош шатах тул асаахад их хүндрэлтэй гэж үзжээ.

Хэдийгээр НАЧА нь зуухны утааг судалдаг өөрийн лабораторитой боловч энэ нь төрөл бүрийн компаниудын үйлдвэрлэсэн боловсруулсан түлшнүүдийг чанарыг судлахад өргөнөөр ашиглагддаггүй.

Энэ бүхнээс үзэхэд боловсруулсан түлшний шинжилгээ явуулах нэгдсэн журмыг баталж албан ёсны болгох нь чухал бөгөөд ингэснээр бүх үйлдвэрлэгчидын судалгааны дүнг нэгтгэн харьцуулах боломжтой болох юм. Тус журам нь мөн үр дүнд ялгавартай ойлгомжгүй байдал гаргахгүй байх зорилгоор туршилтын хатуу чанд протоколтой байх ёстой. Уг мэдээлэл нь МСС-ын сүүлд хийсэн туршилтаар батлагдаагүй бөгөөд ийм төрлийн туршилт хийх явцад түлшин дэхь дэгдэмхийгийн хэмжээ шаардлагад нийцсэн байх хэрэгтэй юм.

4.3. Эдийн засаг ба үнийн асуудал

Ерөнхийдөө хагас коксжсон нүүрсэн шахмал түлшийг тонныг 150,000 борлуулах нь ашиггүй бизнес гэж үйлдвэрлэгчид үзэж байна. Шахмал түлш үйлдвэрлэх процесс нь ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг ба зохицуулахад ярвигтай асуудал юм. Мөн тэд дэлхий дээр хагас коксжсон нүүрсээс шахмал түлш үйлдвэрлэдэг цөөхөн компани байдаг учраас зөвхөн Монгол Улсад ч бус олон улсын хэмжээнд шинэ үйлдвэрлэл гэж дурьдсан.

2011 онд нилээд олон төрлийн зардал нэмэгдсэн байна. Жишээлбэл 2011 оны 4-р сард Шарын голын уурхай нь түүхий нүүрснийхээ үнийг 55% буюу ойролцоогоор нэг тонныг 33,000-аас 50,500 төгрөг болгож өсгөсөн юм. Түүнчлэн төмөр замын тарриф нь ойрын хугацаанд нэмэгдсэн байна. 2012 оны 1-р сарын эхээр дизель, бензин түлш импортлогч компаниуд гэнэт нэг литр тутамд 250 төгрөгөөгөөр нэмэгдүүлж 1,885 болсон юм.

НАКО-гийн хэлсэнээр тэдний нэг тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэх зардал нь 130,000. Гэвч компанийн ажилтан энэ зардлын тооцооллыг үнэ өсөхөөс өмнө буюу Шарын голын уурхайн түүхий нүүрсний үнэ нэг тонн 33,000 байх үед хийгдсэн гэж мэдээлсэн. Энэ зардлын судалгаанаас үзэхэд боловсруулан нэг тонн хагас коксжсон нүүрс тутмаас 20,000 төгрөгний ашиг олохоор төсөвлөгдсөн байв. 2-р цахилгаан станц нь үйлдвэрлэлээ эхлээгүй байна. Гэвч тэдний зардлын тооцооллоос харахад тэдний ашиг нь ойролцоогоор 3-5 % буюу нэг тонн шахмал түлш үйлдвэрлэхэд 6,000 төгрөг байхаар байна.

Шарын гол энерго ХХК-ын нэг тонн хагас коксжсон шахмалт түлшний үйлдвэрлэлийн зардлын нарийвчилсан задаргааг харуулж байна. Зардлын задаргаа нь компани 2012 оны 1-р сард өгсөн уг зардлын судалгаанд дизель түлшний үнэ, түүхий нүүрс, төмөр замын тариф зэрэг бүх зардлын нэмэгдэл багтсан. Түүнчлэн энэхүү зардлын тооцоолол нь МАК-ын хагас коксжсон нүүрсний үнэнд суурилан хийгдсэн гэж мэдээлсэн. 500 тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэхэд компанийн сарын зарлага нь ойролцоогоор 107.0 сая байдаг байна. Нэг тонн хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний үйлдвэрлэлийн нийт зардал нь ойролцоогоор 213,900 буюу нэг тонныг ЦАС-д борлуулах гэрээний үнээс (150,000 төгрөг) даруй 45% өндөр байгаа юм.

МАК ба 2-р цахилгаан станцийн төлөөлөгчдөөс цаашдын судалгаанд ашиглаж болохуйц хангалттай бүрэн дүүрэн мэдээлэл авч чадсангүй.

Хүснэгт 22. Шарын гол энерго ХХК-ийн сар тутмын зардлын анализ

№	Зардлын төрөл	Хэмжигдэхүүн	Хагас коксжсон нүүрс	Тайлбар
1	Шахмал түлшний үйлдвэрлэл (сараар)	тонн	500	
2	Гол түүхий эдийн үнэ			Коксын гаралт 90%
	a. хагас коксжсон нүүрсийн гаралт	тонн	450	Сар тутам
	b. нэг тонн хагас коксжсон нүүрсийн үнэ	Мянган төгрөг	81.5	МАК-с кокс авах
	c. Нийт хагас коксжсон нүүрсийн үнэ	Мянган төгрөг	36,675.0	
3	Цалин	Мянган төгрөг	14,800.0	Удирдлагын 10, үйлдвэрийн 30 ажиллагсад
4	Нийгмийн даатгал	Мянган төгрөг	1,970.0	
5	Хөдөлмөрийн аюулгүй байдлын нийт зардал	Мянган төгрөг	810.0	Нийт ажиллагсдын 40%
6	Ажиллагсдын хоолны зардал	Мянган төгрөг	3,005.0	Өдөрт 3500 төг
7	Түлш ба тээврийн зардал	Мянган төгрөг	300.0	
8	Цахилгаан	Мянган төгрөг	1,500.0	
9	Ус	Мянган төгрөг	800.0	
10	Тээврийн зардал (Дарханы үйлдвэр)	Мянган төгрөг	1,575.0	Сард долоон вагон кокс авах
11	Хэсгүүд ба материалын зардал	Мянган төгрөг	300.0	
12	Капиталын элэгдэл, даатгалын зардал	Мянган төгрөг	5,200.0	Коксын үйлдвэр барих ба тоног төхөөрөмж
13	Хүүгийн төлбөр	Мянган төгрөг	1,500.0	
14	Захиргааны зардал	Мянган төгрөг	1,100.0	Нийт зардлын 50%
15	Буудайн цардуул	Мянган төгрөг	21,000.0	1 тонны үнэ 42,000 төг
16	Холбогч	Мянган төгрөг	2,500.0	1 тонны үнэ 5,000
17	Савлагаа	Мянган төгрөг	5,500.0	20 кг савлахад
18	Нүүрс	Мянган төгрөг	2,000.0	Хагас коксжсон түлшийг хатаахад
19	Түлш тээвэрлэлт	Мянган төгрөг	5,040.0	1 вагон 630,000
20	Түлш ачилт	Мянган төгрөг	1,360.0	
	500 тонныг үйлдвэрлэх нийт үнэ	Мянган төгрөг	106,935.0	
	1 тонн шахмал түлшний дундаж үнэ	Мянган төгрөг		213.9

(Эх сурвалж: Шарын гол энерго 2012)

4.4. Байгаль орчны нөлөөлөл ба мониторинг

Ерөнхийдөө хагас коксжсон нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэгчид нь байгаль орчны нөлөөлөл байдлын нарийвчилсан үнэлгээг байгаль орчны бие даасан компаниудаар хийлгэсэн байдаг. Хэдийгээр “НАКО түлш” ХК ба Шарын гол энерго ХХК нь аль аль нь байгаль орчны мониторингийн төлөвлөгөөтэй боловч байгаль орчны мониторингийн тогтмол үйл ажиллагаа хийгддэггүй. Дархан-Уул аймгийн байгаль орчны байцаагчид, ажилчид нь эдгээр үйлдвэрүүдэд мониторинг хийх зорилгоор 2011 онд хоёр удаа ажилласан. Түүнчлэн НАКО түлшийн ажилтан өөрсдийн үйлдвэрлэлийн газартаа мод, ургамал тарихаар төлөвлөж байгаагаа дурьдсан юм.

Технологийн талаарх байгаль орчны асуудал: МАК ба Шарын гол энерго ХХК хоёул хагас коксжсон нүүрс үйлдвэрлэдэг тоног төхөөрөмж, машин техникээ Хятадын Шанхси мужаас захиалсан байна. “НАКО түлш” ХК-ний нүүрс боловсруулагч технологи нь арай хуучны хувилбар бөгөөд мөн ижил мужаас захиалж авсан байна. Шарын гол энерго ХХК-ын төлөөлөгчийн хэлж байгаагаар энэ хуучивтар технологи нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй байж болзошгүй ба жишээлбэл “НАКО түлш”ХК-ын тоног төхөөрөмж нь нүүрс боловсруулах үйлдвэрээсээ ялгарч буй хийг цэвэрлэгч үе шатгүй юм байна.

Шарын гол энерго ХХК нь хагас коксжсон нүүрс үйлдвэрлэхдээ хий болон давирхай салгахын тулд электро статик технологи ашигладаг ба НАКО түлш нь хагас коксжсон нүүрсээс давирхайг салгахын тулд ус хөвүүлэх аргыг ашиглаж байна. Эхэнд дурьдсан электро статик технологи нь сүүлийн үед шинээр гарч ирсан технологи ба байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө багатай юм.

Хадгалалт: Шарын гол энерго ба НАКО түлшний аль аль нь Дархан хотын үйлдвэрлэлийн бүсэд оршдог. Эдгээр компаниуд нь түүхий нүүрс болон хагас коксжсон нүүрсээ гадаа ил задгай газар хадгалж байсан. Овоолгоос үүссэн тоос нь байгаль орчин болон талбайд ажиллаж байгаа хүмүүс болон эдгээр үйлдвэрүүдтэй ойр амьдарч байгаа хүмүүст сөрөг нөлөөтэй байж болзошгүй юм. Ил задгай газар хадгалагдаж байгаа түүхий нүүрс ба хагас коксжсон нүүрсний аль альных нь нөлөөллийг нарийвчлан судлах нь зүйтэй юм.



Зураг 12. “НАКО түлш”-ний нүүрс хадгалалтын байдал

Хаягдлын менежмент: Авч үзэх шаардлагатай нэг асуудал нь шахмал түлш түлээд үлдэж байгаа их хэмжээний үнс юм. Үнсийг зайлуулах менежмент ба түүний байгаль орчны нөлөөллийг шийдвэрлэх хэрэгтэй. Хагас коксжсон нүүрсэн шахмал түлш нь хагас коксжсон нүүрснээс 50% - 60% их хэмжээний үнс ялгаруулдаг болохыг онцолсон юм.

Зураг 13. НАКО түлшний шахмал түлш үйлдвэрлэхдээ хэрэглэдэг цавуу



(Эх сурвалж: НХХ 2011)

4.5. Саад бэрхшээл

- Барьцалдуулагч материал нь эрүүл мэнд дэх болзошгүй нөлөөлөл ба үнийн тооцооллын хувьд шахмал түлшний үйлдвэрлэлийн нэгэн чухал элемент юм. Боловсруулсан түлшийг үйлдвэрүүдээс илүүтэйгээр айл өрхүүд ашигладаг учир хүний эрүүл мэнд дэх нөлөөллийг цаашид судлах шаардлагатай гол асуудал юм. Монгол Улсын стандарт нь нэмэлт орцын талаар ямар нэг зүйл тодорхой дурьдаагүй байна. Тиймээс үйлдвэрлэгчид ямар ч материал ашиглах боломжтой юм. Холбогч материал эсвэл цавуу нь ямарч температурт хорт үлдэгдэл ялгаруулахгүй байх шаардлагатай юм.
- НАКО түлш ба Шарын гол энерго хоёул түүхий нүүрсээ Шарын голын уурхайгаас авдаг. Тийм ч учраас тэдний эдийн засгийн үнэлгээ нь Шарын голын уурхайн нүүрсний үнэнд тулгуурласан юм. Шарын голын уурхайн нүүрсний үнэ нь 2009 онд 25,000 төг байсан бөгөөд 2010 онд ойролцоогоор 33,000 төг болж өссөн. Гэвч 2011 онд түүхий нүүрсний үнэ нэг тонн нь 50,500 болж дахин өссөн. Шарын голын уурхай нь хувьчлагдсан ба хөрөнгийн биржид бүртгэгдсэн. Тийм ч учраас компани нь Засгийн газрын оролцоогүйгээр нүүрсний үнээ бие даан тогтоодог. Зөвхөн 2-р цахилгаан станцад төрийн мэдлийн уурхайгаас борлуулдаг нүүрсний үнийг Засгийн газар зохицуулдаг.
- ЦАС-гийн одоо худалдаж авч байгаа үнэ нэг тонн 150,000 төг нь үйлдвэрлэлийн зардлаа нөхөж чаддаггүй юм. Үүнийг шийдвэрлэх шаардлагатай. Гэхдээ энэхүү үнийг төр, хувийн хэвшлийнхэн хамтран тогтоосон.

- Шахмал түлш үйлдвэрлэх нь үйлдвэрлэлийн хамгийн ярвигтай үе шат юм. Тийм ч учраас НАКО түлш саяхан Баянгол дүүргийн оршин суугчдад хагас коксжсон нүүрс нийлүүлэхээр тохирсон юм. Ашиглагдаж байгаа бүх төрлийн түлшний талаар тодорхой бодлого байх шаардлагатай юм.
- Үйлдвэрлэгчдийн хэлж байгаагаар Шарын голын уурхайгаас ачигдаж байгаа нүүрс нь голдуу их хэмжээний хаягдал (чулуу, элс) агуулдаг байна. Ерөнхийдөө Шарын голын уурхайгаас авсан түүхий нүүрсний нэг тонноос ойролцоогоор 60 % нь хагас коксжсон нүүрс хийхэд ашиглагддаг ба 40 % нь хаягдал болон үлддэг байна. Олон улсын туршлагаас харахад түүхий нүүрсний уурхайнууд нь өөрсдийн бүтээгдэхүүнээ олон улсын ангиллын дагуу борлуулдаг ба нүүрсний хэлтэрхий бүр хамгийн доод хэмжээг нь заасан байдаг. Гэвч Монголын уурхайнууд нь түүхий нүүрсний энэ стандарт эсвэл ангиллыг борлуулалтандаа ашигладаггүй.
- Түгээлтийн сүлжээн дэх нэмэлт зардлууд нь Улаанбаатарт тээвэрлэлт үгүйгээс шалтгаалж байгаа юм. Шахмал түлш үйлдвэрлэгчдийн мэдэгдснээр түгээгч компани нь зөвхөн 3 машинтай ба нүүрсээ төв агуулахаас шууд борлуулагчид руу тээвэрлэх бололцоогүй байгаа юм. НАКО түлш МАК –д тээвэрлэх шаардлагатай нүүрс байгаа тохиолдолд тэдний захиалгыг нэгт тавьдаг гэж хэлж байсан.
- Төмөр замын хагас коксжсон нүүрс тээвэрлэх тариф нь үнэтэй. Эдгээр компаниудын боловсруулсан нүүрс илгээж байгаа гол зорилго нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах учраас Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо төмөр замын удирдлагуудтай энэ асуудлыг хэлэлцэхээр уулзаж шийдсэн байна.

4.6. Агуулахууд

4.6.1. Үндэслэл

Эхэн үед Улаанбаатар хотын захиргаа боловсруулсан түлшийг хадгалах агуулахуудын зохицуулалтыг хариуцаж байв. Хотын захиргаа 2011 онд 10 боловсруулсан түлш үйлдвэрлэгчидтэй тохиролцсон сар тутмын хуваарийн дагуу боловсруулсан түлш тогтмол хүлээж авах зорилгоор агуулах түрээслэхэд хотын төсвөөс 20 сая төгрөгийг хуваарилсан байна. Гэвч 2011 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дор ЦАС байгуулагдсанаар энэ үүргийг санд бүрнээр шилжүүлэн өгсөн юм.

НАЧА нь үйлдвэрлэгчдийн Улаанбаатар хотын агуулахууд руу тээвэрлэж буй бүх боловсруулсан түлшийг бүртгэдэг. Тэд нэг сард үйлдвэрлэгдсэн хэмжээг харгалзан агуулахаа түрээслэдэг. Хэдийгээр гэрээлсэн хэмжээ нь тодорхой боловч НАЧА үйлдвэрлэгчидтэй тогтмол холбогддог юм. Ийм маягаар НАЧА ачигдан ирэх хэмжээг урьдчилан мэддэг ба агуулахуудыг бэлддэг юм.

Гэрээний дагуу бүх үйлдвэрлэгчид түлшуу агуулахууд руу тээвэрлэх ёстой юм. Гэвч, бүтээгдэхүүн Улаанбаатарт төмөр замаар тээвэрлэгдэн ирж, тэндээс тээвэрлэгч компани хариуцаж авах нь нийтлэг үзэгдэл болоод байна. НАЧА –гийн үзэж байгаагаар хэрэв үйлдвэрлэгчлээс ирж буй нийлүүлэлт нь хэрэгцээг хангахааргүй бол түлшийг агуулахаас түгээгддэг байна. Үндсэндээ НАЧА-гийн стратеги нь боловсруулсан түлш заавал агуулахаар дамжин өнгөрөх шаардлагагүй ба тээвэрлэгч компаниуд нь хороодод боловсруулсан түлшийн шууд түгээх боломжтой юм.

Боловсруулсан түлшний бүх үйлдвэрлэгчид нь хөдөө оршдог учир түлшний бүтээгдэхүүнүүдийг төмөр замаар тээвэрлэдэг. НАЧА-гийн нэг ажилтан 2011 оны зун нийлүүлэлт сайн байсан учир агуулахууд хурдан дүүрч, нэмэлт агуулах шаардлагатай болсныг дурьдсан юм.

НАЧА хоосон агуулах түрээслэдэггүй. Энэ нь хадгалагдах шаардлагатай боловсруулсан түлшний дагуу агуулахаа түрээслэдэг. Амгаланд нийт 1,120 м² (Хүснэгт 23. **Error! Reference source not found.**) талбай бүхий 4 агуулах түрээслэсэн ба нэмэлт байр түрээслэх боломжтой юм. Агуулахууд нь хувийн болон төрийн өмчин хослосон компани болох Улаанбаатар төмөр зам компанийн өмч ба юм. Түрээслэх тариф нь бусад агуулахуудаас бага зэрэг доогуур юм. (Хүснэгт 24.)

Хүснэгт 23. Агуулахуудын байршил ба түрээслэгдсэн талбай

№	Агуулахын нэр	Агуулахын түрээслэсэн талбай	Байршил	Хотын төв хүртэлх зай
1.	Амгалан 1	250м ²	Улаанбаатарын зүүн хэсэгт	15 км
2.	Амгалан 2	250м ²		
3.	Амгалан 3	310м ²		
4.	Амгалан 4	310м ²		
5.	Сонсголон 1	570м ²	Улаанбаатарын баруун хэсэгт	10 км
6.	Сонсголон 2	410м ²	Улаанбаатарын баруун хэсэгт	7 – 9 км
7.	Энхжин	500м ²		
8.	Эрдэнэтолгой	360м ²	Улаанбаатарын зүүн хойд хэсэгт	10 км

(Эх сурвалж: НАЧА 2011)

Хүснэгт 24. Түрээслэсэн талбай, үнэ, хугацаа ба нийт зардлын анализ


№	Агуулахын нэр	Түрээслэсэн талбай (м ²)	Түрээсийн төлбөр (төг/м ²)	Эхлэх хугацаа (2011 он)	Хугацаа (сарууд)	Нийт түрээсийн төлбөр (төг)
1	Амгалан 1	250	2,000	5-р сар	8	4,000,000
2	Амгалан 2	250	2,000			4,000,000
3	Амгалан 3	310	2,000			4,960,000
4	Амгалан 4	310	2,000			4,960,000
5	Сонсголон 1	570	3,000	7-р сар	6	10,260,000
6	Сонсголон 2	410	3,000	9-р сар	4	4,920,000
7	Энхжин	500	2,500			5,000,000
8	Эрдэнэтолгой	360	2,500	7-р сар	6	5,400,000
НИЙТ		2,960				43,500,000

(Эх сурвалж: НАЧА 2011)


Сонсголонд НАЧА нь нийт 980 м² бүхий агуулах түрээслэсэн. Эдгээр агуулахууд нь Интер десишн, Бөөний агуулах хэмээх хоёр компанийн өмч юм. Бөөний агуулах нь ойролцоогоор 570 м² ба Интер десишн нь ойролцоогоор 410 м² юм.

Эрдэнэтолгой ба Энхжинд 360 м² ба 500 м² агуулах тус тус түрээслэсэн байна. Хэрэв шаардлагатай бол нэмэлт агуулах түрээсэлдэг. (Зураг 14.)

Зураг 14. Агуулахуудын байршил



(Эх сурвалж: Google earth 2011)



Энэхүү графикт агуулахуудын багтаамжыг хороодоор харуулсан байна. Одоогийн нийт талбай нь 2,960 м².

График 3. Агуулахуудын багтаамж (хороодоор)

4.6.1.1. Агуулах уруу тээвэрлэлт хийх ажиллагаа

Төмөр замаар агуулахад авчирч дараа нь 5-10 тонн-ын даацтай хүнд даацын тэргээр боловсруулсан түлшийг ачааны машинаар Баянгол дүүргийн долоон хороод уруу зөөвөрлөдөг. Гэвч ЦАС болон НАЧА – тай байгуулсан гэрээнд боловсруулсан түлшийг үйлдвэрлэгдэгдээс агуулах уруу зөөвөрлөхөөр тусгасан. Гэтэл өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа вэ гэвэл нийлүүлэгч компаниуд түлшийг төмөр замаас шууд борлуулагч уруу зөөвөрлөдөг байна.

4.6.1.2. Хууль эрх зүйн шаардлагууд

Ерөнхийдөө агуулахыг сонгох үндэсний болон бүсийн жишиг стандарт гэж байхгүй. НАЧА нь төмөр замд байрлах агуулахуудыг түрээсэлж байгаа учир нь түлш үйлдвэрлэгчидийн гол тээврийн хэрэгсэл төмөр зам болдогтой холбоотой. НАЧА-ийн албаны хүний үзэж байгаагаар бол агуулахын дээвэр маш сайн чанартай байх хэрэгтэй бөгөөд ингэснээр түлш нар салхи болон чийгнээс үүдэн чанараа алдах магадлал буурах юм байна. Үүнээс гадна агуулах харуул хамгаалалтаар сайн байх ёстой юм байна.


4.6.1.3. Тээвэрлэлт

Үйлдвэрлэгчээс агуулах уруу бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтсон тодорхой стандарт байхгүй. Жишээлбэл, тээвэрлэх хэлбэр (юугаар тээвэрлэх), ачааны даац зэргийг тодорхой заасан зүйл байхгүй. Нийлүүлэгчдийн ажигласнаар шахмал түлшийг Баянгол дүүргийн хороод дээр байрлах агуулахаас зөөвөрлөх явцад бүтээгдэхүүний сав баглаа боодол задарч гэмтэх, мөн бүтээгдэхүүн өөрөө хагарч бутарснаас болоод тухайн бүтээгдэхүүн эцсийн хэрэглэгчдэдээ очихдоо гологдож байна.

4.6.1.4. Эдийн засгийн болон үнийн асуудал

Ерөнхийдөө, агуулах түрээслэх үнэ нэг метр квадрат талбайд 2,000–аас 3,000 төгрөг байна (20-р хүснэгт). 2011 оны 12 сарын байдлаар ЦАС нийтдээ Улаанбаатарт агуулах түрээслэхэд 43.5 сая төгрөг зарцуулсан байна. 22- зурагт агуулахын талбайн ашиглалтыг хувьчлан харууллаа.

График 4. ЦАС-ын агуулах ашиглалтын зарцуулалт (хувиар, хороогоор)



Амгалангийн агуулах: Амгалан хороо нь хотын төвөөс зүүн зүгт 14 километрт оршдог. НАЧА нь 2011 оны 5-р сараас эхлэн Амгаланд агуулах түрээсэлж эхэлсэн. 2011 оны 12-р сарын байдлаар, ЦАС нь нийтдээ Амгаланд 4 агуулах (1,120 метр квадрат) түрээслэхэд 17.92 сая төгрөг төлсөн. Амгаланд агуулах түрээслэх ханшийг бусад газруудтай харьцуулахад харьцангуй хямд бөгөөд нэг метр квадратын үнэ нь 2,000 төгрөг болж байна. Амгалангийн агуулахууд нь төмөр замтай холбогдсон болно.

Сонсголонгийн агуулах: Сонсголонгийн агуулах нь Улаанбаатараас баруун зүгт байрлах бөгөөд хоорондын зай нь дунджаар 10-12 километр. Сонсголонгийн агуулахыг түрээслэх нь хамгийн үнэтэй бөгөөд нэг метр квадрат нь дунджаар 3,000 төгрөгийн үнэтэй болж байна. Сонсголонд анх 2011 оны долоон сард агуулах түрээсэлж эхэлсэн бөгөөд дараагийн түрээс нь мөн оны 9 сард байсан. 2011 онд ЦАС Сонсголонд хоёр агуулах түрээслэхэд нийт 15.2 сая төгрөг зарцуулсан байна.

Энхжин агуулах: Энэ агуулах нь Улаанбаатар хотоос баруун зүгт ойролцоогоор 7-9 километрт байршдаг. 2011 оны 9-р сард ЦАС 500 метр квадрат талбай бүхий агуулахыг дөрвөн сарын турш түрээслэхэд нийт 5.0 сая төгрөг зарцуулсан байна. Түрээсийн үнэ нэг метр квадрат талбайд 2,500 төгрөг ноогдож байна.

Эрдэнэтолгой агуулах: Хотын төвөөс зүүн урд зүгт 10 км зайд Эрдэнэтолгой агуулах оршдог. Түрээсийн агуулахын үнэ нэг квадрат метр талбайд 2,500 төгрөг. Түрээсэлж эхэлсэн өдөр нь 2011 оны 7-р сар болно. 2011 оны 12-р сарын байдлаар ЦАС түрээсийн төлбөрт нийт 5,4 сая төгрөг зарцуулсан болно.

4.6.1.5. Байгаль орчны нөлөө болон холбогдох үнэлгээ

Ерөнхийдөө агуулах ашигласнаас үүдэн ямарваа нэгэн байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөө байхгүй. Агуулахын тухай авч үзэхийн бол дараах асуудлуудыг байгаль орчинд үзүүлэх муу нөлөөг бууруулах үүднээс авч хэлэлцэх хэрэгтэй.

- Агуулахуудын эргэн тойронд нутгийн оршин суугчдийн амьдардаг байр болон сууц байдаг. Иймээс тээвэрлэлтээс үүсэх унаа тэргийн шуугиан аль болох бага байх хэрэгтэй.
- Боловсруулсан түлш тээвэрлэж байгаа ачааны машинууд нь тоосжилтийг их хэмжээгээр оршин суугчдын эргэн тойронд бий болгоно. Иймээс ачааны машины хурдыг тодорхой зааж өгөх хэрэгтэй.
- Түлш нь их хэмжээгээр агуулахад хадгалагдана. Иймээс хүрээлэн буй орчинд нь сөрөг нөлөө үзүүлэхгүйн тулд тэдгээр бүтээгдэхүүнүүдийг далд хадгалах хэрэгтэй.

4.6.1.6. Бэрхшээл

- Хэдийгээр 2011 оны 7-9 сарын хооронд 10,000 тонн боловсруулсан бүтээгдэхүүнтэй болох гэрээ хийгдсэн ба төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн бол тэдгээр бүтээгдэхүүнийг агуулах хангалттай тооны агуулах байхгүй байх байсан.
- Агуулахын дээвэр ч юмуу агуулахыг ямар материалаар барьж болох, мөн түүнчлэн агуулахын доторх агаарын чийгшилт, тоосжилт, чимээ шуугиан

зэрэгтэй холбоотойгоор тогтсон тодорхой стандарт байхгүй байгаа нь агуулахад байгаа түлшний чанарыг муутгах нөхцөл болж болно.

- Бүтээгдэхүүний талаар хангалттай бөгөөд хүрэлцээтэй мэдээллээр агуулахын ажилчдыг хангах хэрэгтэй. Боловсруулсан бүтээгдэхүүн нь хурдан шатах зориулалттайгаар үйлдвэрлэгддэг тул тухайн бүтээгдэхүүнийг шатамтгай бүтээгдэхүүн хэмээн үзэх шаардлагатай. Иймээс, агуулахын ажилтан нар нь галын болон үер усны үед тухайн бүтээгдэхүүнүүдтэй хэрхэн харьцах талаар мэдэж байх шаардлагатай.
- Нийлүүлэгч компаниуд нь агуулахуудыг хэрэгцээтэй үед нээлттэй байдаггүй хэмээн дургүйцдэг. Энэ байдлаас болж нийлүүлэгч компаниуд нь хотод уртасгасан цагаар ажилладгаас тэдний үйл ажиллагааны зардал нэмэгддэг.

4.6.1.7. Нөхцөл байдлыг сайжруулах арга зам

- Боловсруулсан бүтээгдэхүүнийг зөв хадгалахын тулд агуулахын аюулгүй байдал, агуулах үйл ажиллагааны шаардлагуудыг авч үзэх шаардлагатай. Түлшийг их хэмжээгээр хадгалах үндэсний тогтсон стандартыг боловсруулах шаардлагатай.
- Агуулахуудад түлшийг ачиж буулган зөөвөрлөхөд зориулагдсан тусгай зориулалтын машин тоног төхөөрөмжүүдтэй байх шаардлагатай
- Агуулахаас бүтээгдэхүүнийг зөөвөрлөх явцыг болиулах хэрэгтэй эсэх талаар судлах. Учир нь Засгийн газар агуулах түрээслэхэд маш их хэмжээний хөрөнгө зарцуулж байхад үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ жижиглэнгий борлуулагчдад шууд дамжуулан борлуулахын оронд төмөр замаас бүтээгдэхүүнээ эдгээр агуулахад хүргэхийн тулд их хэмжээний зардал гаргаж байна. Компаниуд нь хоёр ажил хийж цаг хугацаа алдан мөн үйл ажиллагааны зардлаа нэмэгдүүлж байгаа юм.

4.7. Хороод руу тээвэрлэх

4.7.1. Үндэслэл

Баянгол дүүргийн 7-р хорооны 14 борлуулах цэгт боловсруулсан бүтээгдэхүүнийг тээвэрлэн хүргэх тэндэрийн бичиг баримтыг Засгийн газар боловсруулан тендэрийг зарласан байна. Тендэрийн материалыг шалгаруулсны үр дүнд тендэрт Био Монголия Рич ХХК сонгогдсон. Энэ компани нь түгээлтэнд бие даан ганцаар зонхилох үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд тухайн компанитай хамтарсан болон давхар гэрээлэгч байхгүй болно.

4.7.2. Био Монголия Рич ХХК

Био Монголия Рич ХХК нь 6 сарын туршид долоон хороод дээр байрлах 14 борлуулах цэгт 16,850 тонн боловсруулсан бүтээгдэхүүнийг Амгалан, Сонсголон, Энхжин, Эрдэнэтолгойд байрлах 8 агуулахаас хүргэх гэрээг Засгийн газартай байгуулаад байгаа бөгөөд хүргэлтийн ажил 2011 оны 9-р сарын 27-нд эхлэсэн. Компанийн үзэж байгаагаар тэд гэрээг гүйцэтгэхийн тулд нийт 20 ажилтан, 8 хүнд машин ашиглаж байна. Гэрээнд зааснаар тухайн компани өдөр бүр 129 тонн түлшийг тээвэрлэх юм.

4.7.3. Эдийн засгийн болон үнэ тарифтай холбогдон гарах асуудал

Гэрээний нэг үндсэн заалт бол ЦАС гэрээлэгч компанийн бодит гүйцэтгэл дээр үндэслэн сар бүр холбогдон гарах төлбөрийг барагдуулдаг. ЦАС нь одоогоор агуулахаас хороо хүртэл зөөвөрлөгдсөн 19,670 тонн түлшинтэй холбогдон гарсан төлбөрийг барагдуулаад байгаа бөгөөд төлбөрийг төлөхөд агуулахын хол ойрын зайг харгалзан үзээгүй. Гэрээний нийт төлбөрийн дүн 367,4 сая төгрөг болно.

Компани нь энэхүү бизнесээс олох ашгийн хувийг 10% байна гэж тооцоолсон.

Гэвч, компанийн менежрийн тооцоолж байгаагаар бол түлшний үнэ өссөн болон бусад зарим хүчин зүйлээс шалтгаалаад компанид үлдэх ашиг алга болсон. 2011 оны 12-р сарын байдлаар хэдийгээр 6,500 тонн боловсруулсан түлш зөөвөрлөгдсөн байх ёстой боловч зөвхөн 3,400 тонн нь зөөвөрлөгдчихөөд байгаа юм байна.

2011 онд тухайн компанийн ажилчид амралтын өдрүүдээр ажилласан болон сул зогссон тул компанийн зардал өссөн. Түлш тээвэрлэлт хойшлох болон сул зогсолт үүсч байгаагаас шалтгаалан үйл ажиллагааны зардал болон хүнд машин тоног төхөөрөмжийн түлш шатахууны зардал өсч байна.

Учир нь төрөөс эдгээр компаниудад зах зээлийн үлэмж дауу талыг зохиомлоор ажиллаж үүсгэн өгч байгаа билээв Тиймээс компаниуд нь өөрсдийн эдийн засгийн тооцоогоо сайжруулж аливаа эрсдэлийг зөв тодорхойлон менежментээ сайжруулах зайлшгүй шаардлага байна.

4.7.4. Хууль эрх зүйн шаардлага, стандартууд

Бүтээгдэхүүний чанарыг хамгаалах зорилгоор бүтээгдэхүүнийг түгээх болон зөөвөрлөх үед баримтлах тогтсон тодорхой үндэсний болон бүсийн стандарт эдүгээ байхгүй байна.

4.7.5. Байгаль орчны нөлөө болон түүний үнэлгээ

Боловсруулсан бүтээгдэхүүнийг жижиглэнгийн борлуулагчид эсвэл борлуулалтын цэгүүд уруу зөөвөрлөхтэй холбогдон байгаль орчинд үзүүлэх муу нөлөө байхгүй. Эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөлийг бууруулахын тулд ажилчдыг тээвэрлэж байх үеийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагатай. Эдгээр ажилчид нь түлшийг агуулахаас машинд ачих болон ачсан бүтээгдэхүүнийг борлуулалтын цэг эсвэл жижиглэнгийн борлуулагчидад хүргэдэг. Түлшийг ачиж буулгах үед гарах тоосжилт нь эдгээр ажилчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлж болно.

4.8. Системийн тогтвортой байдал

Энэхүү төлөвлөгөөнд системийн хувьд бүхэлд нь үүсч болох эрсдлийг тусгах нь зүйтэй. Дараах хоёр системийн тогтвортой байдалд нөлөөлж болох тохиолдол байна:

1-р хувилбар: Хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэгчид нь бүтээгдэхүүний үнээ өсгөхийг хүсч байгаа нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардал өндөр болон бусад техникийн асуудлуудтай холбоотой.

Энэхүү хувилбар нь одоогоор тулгарч болох хамгийн ойрхон хувилбар юм. Үйлдвэрлэлийн зардлын нэмэгдлийг тэнцвэржүүлэн барих тодорхой стратеги хэрэгтэй. Учир нь бүтээгдэхүүнийг түгээх үйл ажиллагааны зардлыг ЦАС хариуцах юм.

2-р хувилбар: Хагас коксжсон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь дараа жилийн байдлаар гэрээнд заасан бүтээгдэхүүнийг нийлүүлнэ

Засгийн газар энэхүү хөтөлбөрийг Улаанбаатарын бусад дүүргүүдэд мөн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Гэхдээ өнөөгийн байдлаар боловсруулсан түлшний хангамж Баянгол дүүрэгт хангалттай биш байна. Боловсруулсан түлшний хангамж хүрэлцээгүй байх эрсдлийг бууруулахын тулд өөрөөр бол боловсруулсан түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн ямар өдөөгч хүчин зүйлийг авч хэрэгжүүлэх болон ямар сонголт хийх талаар судалж үзэх хэрэгтэй.

4.8.1. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ЯВЦАД ТУЛГАРЧ БОЛОХ ХЯЗГААРЛАЛТУУД

Хэдийгээр уулзалт ярилцлагын үеэр компаниуд өөрсдийн бизнесийн онцлогийн талаарх баримт бичиг, үйлдвэрлэлийн онцлогийн талаарх мэдээллээ хуваалцахаа мэдэгдсэн боловч зарим компаниуд мэдээллээ хангалттай хуваалцахгүй байгаагаас үүдэн цаашдын судалгаанд хүндрэл тулгарч байна.

5. Олон нийттэй хийсэн зөвлөлдөх уулзалт

5.1. Танилцуулга

Олон нийтийн зөвлөлдөөнийг ямар зорилго нь үйлчлүүлэгчдийн байр сууринаас өнөөгийн түлш түгээлтийн арга замыг үнэлэх болон боловсруулсан түлшний хүртээмжийг үнэлэх зэрэг болно. Олон нийттэй зөвлөлдсөний үр дүнд түгээлтийн үр дүнг сайжруулахыг зорьсон. Энэхүү ажлын зорилго нь олон ялангуяа хэрэглэгчид боловсруулсан түлш, түгээлтийн талаар ямар үзэл бодолтой байгааг олж мэдэхэд чиглэсэн. Түүнчлэн энэ хэсэгт дурьдагдах зарим нэгэн асуудлууд тодорхой хэтрүүлэг эсвэл нийтлэг шинж чанаргүй байх магадлалтай.

Зөвлөлдөөний явцад түлш түгээх үйл ажиллагаа Баянгол дүүрэгт эхлээд байсан бөгөөд энэ нь энэ дүүргийг олон нийтийн зөвлөлдөөнд сонгох шалтгаан болсон юм.

Хороо бүрт хоёр жижиглэнгийн борлуулах цэг байдаг. Баянгол дүүрэгт энэ цэг 14 болоод байна. Жижиглэнгийн борлуулагчид нь бүтээгдэхүүнийг урьдаар бэлтгэн тараагдсан ваучераар гэр хорооллын иргэдэд борлуулдаг. Ваучерийг хороон засаг дарга болон тухайн хорооны хэсгийн төлөөлөгчдөөр дамжуулан иргэдэд тараана. Өвлийн улиралд нэг өрх 2,5-аас 3 тонн нүүрс хэрэглэнэ гэж тооцоологдсон. Олон нийтийн зөвлөлдөөн нь хэрэглэгчдэд үндсэлсэн бөгөөд өөрөөр бол өнөөгийн боловсруулсан түлш түгээлтийн үр өгөөж, үр ашигтай байдлын талаар ойлголт олж авахад тулгуурласан. Ингэхийн тулд дараах төрлийн сонирхогчдын бүлгийн хүмүүсийг тусгай бүлгийн хэлэлцүүлэгт урьж уулзан ярилцсан.

5.1.1. Орон нутгийн ажлын хугацаа болон зорилго

- Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 10-р болон 23-р хороод дээр очиж уулзаж боловсруулсан бүтээгдэхүүн хэрэглэгчидтэй тусгай хамтын оролцооны арга эсвэл хагас зохион байгуулалттай ярилцлага ашиглан уулзаж тусгай бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах. Ингэснээр түлш түгээх системийн үр өгөөжтэй байдал болон боловсруулсан бүтээгдэхүүний хүртээмж буюу олдоцийн талаар мэдээлэл авах байлаа.

5.1.2. Зорилтот бүлгүүд:

Гурван гол бүлэг ярилцлаганд оролцсон. Үүнд:

- Боловсруулсан бүтээгдэхүүн хэрэглэгчид болон 10 болон 23-р дүүргийн оршин суугчид;
- Тэдгээр хороодын төрийн удирдлагууд;
- Боловсруулсан бүтээгдэхүүнийг гэр хорооллын оршин суугчдад борлуулах жижиглэнгийн борлуулагчид;

5.1.3. Гэр хорооллын оршин суугчид

Нийслэл хотод агаарын бохирдлыг бууруулах холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, Улаанбаатар хотын удирдлагаас гэр хорооллын дүүргүүдийн хувьд түүхий нүүрс

хэрэглэх хязгаарласан бүсийг зааж өгсөн тогтоол шийдвэр гаргасан. Энэ нь тогтоол шийдвэрийн үр дүнд нийслэлийг Баянгол дүүргийн долоон хороонд (эдгээр хороонд нийт 11,000 оршин суугчид амьдардаг) түүхий нүүрс хэрэглэх асуудлыг хориглосон. Иймээс Баянгол дүүргийн хоёр хорооны төлөөлөгчдийг урин зорилтот бүлгийн ярилцлаганд оролцуулсан.

5.1.4. Орон нутгийн удирдлагууд

Хороон засаг дарга, хэсгийн төлөөлөгчид зэрэг орон нутгийн удирдлагууд нь түгээлтийн системд онцгой үүрэгтэй. Боловсруулсан бүтээгдэхүүн худалдан авах ваучер нь Хороон дарга болон Хэсгийн төлөөлөгчдийн тусламжтайгаар түгээгдэнэ. Хороон дарга нь боловсруулсан бүтээгдэхүүний талаарх мэдээллийг бусдад түгээнэ. Эдгээр мэдээлэлд агаарын бохирдлыг үүсгэж байгаа эх үүсвэр, агаарын бохирдлоос үүдэн иргэдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх байдал, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн хэрэглэх талаар гэр хороололд оршин суугчдад зориулсан сургалт зохион байгуулах талаар зэрэг мэдээлэл багтана. Иймээс нэг талаасаа хороон дарга болон хэсгийн төлөөлөгчид нь боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрэглэх дүүрэгт амьдрагсад болохынхоо хувьд хэрэглэгчдийн байр сууринаас, нөгөө талаасаа орон нутгийн удирдлагуудын байр сууринаас гэсэн хоёр үзүүлэлтээр боловсруулсан ба бүтээгдэхүүний олдоц хүртээмж, тухайн бүтээгдэхүүний үр өгөөжтэй байдлыг судлахад туслалцаа үзүүлэн уулзалт ярилцлаганд оролцсон.

5.1.5. Жижиглэнгийн борлуулагчид

Жижиглэнгийн борлуулагчдыг сонгохдоо тэдний агуулахын багтаамж дээр шалгуурлан Засгийн газар шалгаруулсан. Ихэвчлэн орон нутгийн борлуулагчид жижиглэнгийн борлуулагчдын үүргийг гүйцэтгэсэн. Жижиглэнгийн борлуулагчид нь гэр хорооллын иргэдтэй байнгын харилцаа холбоотой байдаг ба түгээлтийн арга замын үр өгөөжийн талаар анхан шатны мэдээллээр хангагдсан байсан учраас тэд маш чухал үүрэгтэй тал болж чадсан. Тэд мөн өөрсдөө түлшиндээ халаалтын зориулалтаар боловсруулсан түлшийг ашиглагчид юм. Тиймээс тэд мөн асуулт ярилцлаганд жижиглэнгийн борлуулагчид, нөгөө талаас хэрэглэгчийн байр сууринаас оролцсон.

5.1.6. Хашаанд амьдардаг айлуудтай хийсэн уулзалт ярилцлага

Оролцооны аргыг ашиглан гэрт амьдардаг хүмүүстэй тусгай бүлгийн уулзалт ярилцлагыг явуулсан. Урилгыг хороон засаг дарга нар уулзалт эхлэхээс нэг өдрийн өмнө тараасан. Н хэлбэрээр (Хавсралт 10) олон нийтийн зөвлөх мэргэжилтэн гэрт амьдардаг хүмүүстэй уулзаж ярилцсан. Н хэлбэр гэдэг нь тодорхой хөтөлбөр төсөлд үнэлэлт дүгнэлт өгөхөд ашигладаг үр дүнтэй аргуудын нэг юм. Иймээс энэ аргыг ашиглан боловсруулсан бүтээгдэхүүн ашиглаж байгаа болон тэдгээр бүтээгдэхүүн түгээлтийн үр өгөөжтэй байдлын талаар санаа бодлоо хуваалцаж чадах хэрэглэгчидтэй уулзаж ярилцсан. Уулзалт ярилцлагын гол асуулт нь “Таны бодлоор боловсруулсан бүтээгдэхүүний түгээлт хир үр өгөөжтэй болон үр ашигтай вэ” бөгөөд энэ асуултын хариуг гэрт амьдран суугчдаас авсан.

5.1.7. Олон талуудаас хагас зохион байгуулан авсан уулзалт ярилцлага

Энэхүү уулзалт ярилцлага нь хамгийн хямд зардалтайгаас гадна мэдээллийг хувь хүмүүс болон жижиг бүлгүүдээс хурдан түргэн хугацаанд цуглуулах боломжтой арга юм. Энэ арга нь тухайн бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа болон бүтээгдэхүүний

түгээхэд оролцож байгаа гээд нилээд хэд хэдэн төрлийн талууд нэгэн зэрэг цугларч уулзалт ярилцлаганд оролцож байгаа үед ашиглахад тун тохиромжтой.

5.2. Гол ажиглалт, үр дүн

5.2.1. Ерөнхий мэдээлэл

Олон нийтийн зөвлөлдөөнд нийт 49 хүн оролцсоноос 41 нь хашаа байшинд амьдардаг, 4 нь орон нутгийн удирдлагууд, 4 нь жижиглэнгийн борлуулагчид байна (Хавсралт 12-т зөвлөлдөөнд оролцсон хүмүүсийн нэрсийг жагсаан харуулсан). Н хэлбэрийн уулзалт ярилцлаганд биечлэн оролцогсдын 23 нь эмэгтэй, 18 нь эрэгтэй. Тэдгээрийн 7,3% нь өрх толгойлсон эмэгтэйчүүд, 2,4% нь хүүхдээ ганцаар өсгөж байгаа эцэг, 4,8% нь тахир дутуу хүмүүс байна. Мөн 36,5% нь ажилгүйчүүд байсан бол 39% нь тэтгэвэрт гарсан хүмүүс, 12% нь төрийн албан хаагчид, 7,3% нь хувийн хэвшилд ажиллагсад байв. Ярилцлаганд оролцогсдын дундаж нас 48,

Олон нийтийн зөвлөлдөөнд оролцсон 41 хашаа байшинд амьдран суугчдаас 33 хүн нь Нхэлбэрийн ярилцлаганд оролцсон бөгөөд нэг найман өрхийн хүнтэй тус тусад нь уулзаж ярилцсан. Тэдгээр найман өрхийн дундаж орлого 455,000 төгрөг, сарын. Гэвч ярилцлаганд оролцогсдын 50%-ийнх нь сарын орлого амьжиргааны дундаж түвшнөөс (Улаанбаатар дахь амьжиргааны дундаж түвшин) доогуур байсан ба энэхүү амьжиргааны дундаж түвшин нь сарын 118,100 төгрөг нэг хүнд ноогддог байна. Эдгээр өрхүүдийн нэг сард нэг хүнд оогдуулан олох орлогын дүн нь 52,000-аас 85,000 төгрөг байна. Энэхүү орлого нь ихэвчлэн тэтгэврийн мөнгө болон хүний хөгжлийн 21,000 төгрөгөөс (нэг сард, нэр хүнд) тус тус бүрдэнэ.

5.2.2. Хэрэглэгчид

Нийслэл хотод агаарын бохирдлыг бууруулах холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэр хороололд түүхий нүүрс хэрэглэхгүй байх өрхүүдийг хороо хороогоор заагласан тогтоолыг хотын дарга гаргасан. Энэ нь Баянгол дүүргийн нийт 11,000 өрх бүхий долоон хорооны оршин суугчдыг түүхий түлш түлэхгүй байхаар заасан, Эдгээр долоон хорооноос 2 хороог нь дараах шалтгааны улмаас олон нийтийн зөвлөлдөөнд оролцуулахаар сонгосон.

Баянгол дүүргийн 10-р хороо

Бусад хороодтой харьцуулахад 10-р хорооны иргэдийн дунд гэрт амьдрагсдын тоо хамгийн өндөр байгаа юм. Тэдний амьдарч байгаа талбай харьцангуй бага.

Зураг 15. 10-р хорооны байрлал



(Google Earth)

Энэ хороонд өрх толгойлсон эмэгтэйчүүд, хагас өнчин болон хөдөлмөрийн чадваргүй оршин суугчдын тоо асар их. Энэ хороо нь Улаанбаатарт хамгийн их хүн амтай хороо болж байгаа юм. Оршин суугчдын 83% нь ойролцоогоор гэрт амьдардаг бөгөөд тэдний тал хувь нь одоо боловсруулсан түлш ашиглаж байгаа. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр, хороодууд нь боловсруулсан түлшний хангамжийн дутагдалтай байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 23-Р ХОРОО

Тус хороонд 1,477 өрх, 5,660 оршин суугчтай. Газар нутгийг хамрах хэмжээ нь дундаж. Гэхдээ өндөрлөг газар байршдаг (Зураг 16). Тус хороонд оршин суугчдын тоо сүүлийн үед нэмэгдсэнээс болоод хороог дахин шинэчилсэн. Хорооны дэд бүтэц маш муу, хорооны нийгмийн халамж оршин суугч бүрийн хэрэгцээ шаардлагыг хангаж чаддаггүй. 10-р хороотой нэгэн адил 23-р хорооны боловсруулсан бүтээгдэхүүний хүрэлцээ муу.

Зураг 16. 23-р хорооны байршил



Олон нийттэй уулзах уулзалт гэр хорооллын оршин суугчдын дунд хоёр удаа болсон. Уулзалтын урилгыг уулзалт болохоос нэг өдрийн өмнө хороодын засаг дарга нараар дамжуулан тараасан. Олон нийтийн зөвлөх мэргэжилтэн уулзалт ярилцлагыг уулзалт ярилцлагын Н хэлбэрийг ашиглан явуулсан (Хавсралт 10). Хэлэлцүүлэгийн гол асуулт

нь “Боловсруулсан бүтээгдэхүүнийг түгээх систем таны бодлоор хир үр өгөөжтэй, үр ашигтай вэ”. Хэлэлцүүлэгт оролцогчид нь түгээлтийн системийн сайн болон муу талуудыг хоёуланг нь тодорхойлсон бөгөөд тухайн системийн үр өгөөж болон үр ашгийг нийт 10 онооноос 6,8 оноогоор хагас коксжсон нүүрсний хувьд үнэлсэн байна. Харин энэ үзүүлэлт үртсэн шахмал түлшний хувьд 10 онооноос 1,6 байна. Н хэлбэрийн судалгааны дэлгэрэнгүй үр дүнгийн талаар 89-өөс 92-аар хуудсанд харуулан тайлбарласан.

Өнөөгийн байдлаар тэдгээр хороодын гэрт амьдран суугчид нь хагас коксжсон нүүрс, үртсэн шахмал түлш түлж байна. Нэрийг нууцлан судалгаанд оролцогсод нь хариулахдаа боловсруулсан үртсэн шахмал түлшинд хэд хэдэн давуу тал байгааг дурьдсан. Үүнд, эдгээр бүтээгдэхүүнүүдээс онцгой эвгүй үнэр ялгардаггүй, мөн эдгээр түлшийг хэрэглэснээр нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад нилээд хувь нэмэр оруулж байна хэмээн үзсэн. Хүмүүс үртсэн шахмал түлшийг хэрэглэхийг илүүд үзэж байгаа нь тухайн бүтээгдэхүүний шатамхай чанар, хангалттай хэмжээний дулаан ялгаруулдаг, түлш шатаж дууссан дараах үнс нурам бага зэрэгтэй нь холбоотой. Боловсруулсан бүтээгдэхүүний үнэнд Засгийн газраас татаас өгч байгаа нь өрхүүдийг дахин ямар нэгэн өрхийн нэмэгдэл зардал гаргахгүй байдлаар шийдэж байна.

Хагас коксжсон нүүрсэн бүтээгдэхүүний хувьд судалгаанд оролцогсдын 83% хувь нь бүтээгдэхүүний чанарт сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлсэн. Тэдний үзэж байгаагаар энэхүү бүтээгдэхүүний хувьд дараах төрлийн асуудлууд тулгарч байгаа юм байна:

- Энэ бүтээгдэхүүн нь хэрэглэхэд хялбар бус бөгөөд хурдан түргэн асдаггүй байна;
- Гал ассаны дараагаар гэр халтал нилээд хугацаа шаардаж байна;
- Галлах үед маш их чимээ гаргадаг;
- Оч гаргадаг тул галын аюултай байж мэдэх,
- Шатаж дууссаныхаа дараа үнс нурам их үлдээдэг
- Үнс нь хог хаягдал их тул өргөхөд хүнд;
- дулаан тархалт муутай бөгөөд үртсэн шахмал түлштэй харьцуулахад гэрийн доторх агаарыг бохирдуулдаг; мөн энэ бүтээгдэхүүн нь хэрэглэх бүх шатандаа хүний хөдөлмөрийг байнга шаардсан;

Гэвч хүмүүсийн хамгийн их санааг зовоож байгаа үзүүлэлт бол бүтээгдэхүүний хангамж, хүртээмжийн асуудал юм. Иргэд цаг үргэлж түлшний хомсдолтой байдаг байна. Тэдний ойлгож байгаагаар тухайн бүтээгдэхүүнийг хэрхэн олж авах иргэд тодорхой ойлголт байхгүй. Ялангуяа түгээлтийн маш олон сувгийг харгалзан үзэх юм бол тэд бүтээгдэхүүнээ яаж олж авах ойлголт маш муу байгаа юм байна. Тэдний үзэж байгаа хамгийн том асуудал бол жижиглэнгийн борлуулагчдын гар дээр борлуулахаар бэлэн байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээ хангалттай биш байгаатай холбоотой.

5.2.3. Жижиглэн борлуулах цэг

Хүмүүс боловсруулсан бүтээгдэхүүнийг жижиглэнгийн борлуулах цэг дээрээс худалдан авч байна. Тэдний бүтээгдэхүүнийг худалдан авах хэмжээ нь жижиглэнгийн борлуулагчдын цэг дээрээс бүтээгдэхүүнийн худалдан авах боломж, өрхийн худалдан авах чадвар болон зөөвөрлөх хүчин чадлаас шалтгаалдаг. Нэг машин түлээ худалдан авах чадвартай хүмүүс нь бүтээгдэхүүнийг их хэмжээгээр буюу 20 шуудай түлээг нэг дор худалдан авч чадна. Зарим хүмүүс нь машин түрээслэн 3-аас 4 шуудай боловсруулсан түлшийг худалдан авдаг. Зарим хүмүүс нь худалдан авсан түлшээ зөөвөрлөхдөө чарга болон усны тэргээ ашигладаг. Энэ тохиолдолд хүмүүсийн худалдан авах хэмжээ гурваас дөрвөн шуудайнаас хэтрэхгүй байна.

Зарим оршин суугчид жижиглэнгийн худалдааны цэгүүдийн байршилын талаар гомдол

гаргаж байна. Тэдний хэлж байгаагаар бол зарим жижиглэнгийн худалдааны цэг нь өндөрлөг газарт байрлаж байгаагаас хүмүүст түлшээ тээвэрлэх болон тухайн цэгт хүрч очиход хүндрэл гарч байгаа юм байна.

5.2.4. Үнэ

Олон нийтийн зөвлөлдөөнд оролцогсдын 66% нь боловсруулсан бүтээгдэхүүний үнэ боломжийн гэж үзэж байна. 16,6% нь тухайн бүтээгдэхүүний үнийг түүхий нүүрс худалдан авахтай харьцуулахад өндөр байна гэж үзэж байна. 16,6% нь бүтээгдэхүүний талаар ямарваа нэг ойлголт байхгүйгээс тухайн асуултанд хариулж чадахгүй байна гэжээ. Үнийн хувьд боловсруулсан бүтээгдэхүүнийг түүхий нүүрстэй харьцуулахад үнэтэй байна гэж үзсэн нь хүмүүсийн хагас коксжсон шахмал түлшний дулаан хадгалалт болон дулааны тархалт муу байдгаас эцэст нь тэд их хэмжээгээр тухайн түлшийг хэрэглэх шаардлагатай болж байгаатай холбон тайлбарлаж байна. Мөн түүнчлэн тэдний үзэж байгаагаар жижиглэн худалдааны цэг бий болсоноос тэдэнд худалдан авсан бүтээгдэхүүн түлшээ зөөвөрлөх асуудалтай тулгарч байгаа юм байна. Жижиглэн борлуулах газраас түлшээ гэр үрүүгээ зөөж байгаа нь тэдний хувьд нэмэгдэл зардал болдог. Эдгээр хүчин зүйлсээс болоод эцэст нь туршилтаар борлуулагдсан боловсруулсан бүтээгдэхүүний үнэ нь түүхий нүүрсний үнэтэй харьцуулахад үнэхээрийн өндөр байна хэмээн дүгнэхэд хүргэж байна.

ВАУЧЕР

Бүх өрхөд хоёр тонн хагас коксжуулсан түлшний үнэ 180,000 төгрөг; үртсэн шахмал түлшний үнэ 80,000 төгрөг нийтдээ 260,000 төгрөг бүхий ваучерийг Засгийн газрын татаас олгосон. Олон нийтээр хэлэлцүүлсэний үндсэн дээр эдгээр ваучерийг хороон Засаг дарга нар тараасан бөгөөд гэрт амьдардаг хүмүүсийн хувьд ямар нэгэн хүндрэл бэрхшээлтэй тулгараагүй байна. Ярилцлаганд оролцсон хүмүүсийн 12,5% нь эдгээр олгогдсон ваучерийн мөнгөн дүн тухайн өрх өвлийн түлшний хэрэгцээгээ бүхэлд нь хангахад хүрэлцээтэй гэж үзсэн байна. 75% нь харин энэ мөнгөн дүн тэдэнд бүхэл өвлийн турш хангалтгүй гэж үзсэн. Ихэнх хүмүүсийн үзэж байгаагаар тэдэнд бүхэл өвлийн турш дахин гурван тонн боловсруулсан түлш хэрэгцээтэй юм байна. 12,5% нь ваучерийн талаарх асуултанд хариулж чадаагүй нь тэдний түүхий нүүрс хэрэглэсэнтэй холбоотой.

5.2.5. Сав баглаа боодол

Ярилцлаганд оролцогчдын тэн хагас нь боловсруулсан бүтээгдэхүүний сав баглаа боодолд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн. Түлшийг тээвэрлэх хэд хэдэн үе шатыг тухайн бүтээгдэхүүн нь дамждагаас шалтгаалан түлшний сав баглаа боодол байнга урагдаж байдаг тул дахин савлах асуудалтай байнга тулгардаг. Энэ байдал нь хэрэглэгчдийн дунд анх савласан бүтээгдэхүүний хэмжээ жин алдагдаж байгаа болов уу гэсэн эргэлзээг төрүүлэхэд хүргэж байна.

5.2.6. Агаарын бохирдол

Хэдийгээр боловсруулсан түлшийг халаалтандаа хэрэглэж байгаа ч агаарын бохирдол шаардлагатай түвшин хүртэл буурахгүй байгаа байх гэсэн айдас хүмүүсийн дунд байна. Энэ зөрчил нь бүх өрх боловсруулсан түлшийг хэрэглэхгүй байгаатай холбоотой гэж тэд үзэж байна.

Хэдийгээр гэрт амьдарч буй оршин суугчид нь түүхий түлш хэрэглэхгүй байхаар хуулийн үндэслэлтэй журамлагдсан боловч боловсруулсан түлшний нийлүүлэлт хэрэгцээг хангахгүй байна. Иймээс тэд түүхий түлш хэрэглэж байна. Ярилцлаганд оролцогчдын 75% нь одоо ч түүхий түлш хэрэглэж байгаа гэж хариулсан. 70% нь харин боловсруулсан бүтээгдэхүүний хангамж хүртээмж хангалттай байсан бол түүхий

нүүрсний оронд боловсруулсан бүтээгдэхүүн хэрэглэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.

Хэлэлцүүлгийн үеэр гэрт амьдарч буй оршин суугчид нь боловсруулсан түлшнээс гадна өөр ямар аргаар агаарын бохирдлыг бууруулах талаар санал бодлоо хуваалцсан.

- Ихэнх хүмүүсийн үзэж байгаагаар Засгийн газар гэрт амьдардаг хүмүүст зориулж эрчим хүчний үнэд хямдрал үзүүлэх эрс шийдвэр гаргаж байгаа нь сайн хэрэг гэж үзэж байна. Гэхдээ боловсруулсан түлш худалдаж авч байгаа өрх л одоогоор зөвхөн эрчим хүчний үнийн хөнгөлөлт авах боломжтой болж байгаа юм. Энэ байдлыг өөрчлөх хэрэгтэй бөгөөд ингэснээр бүх өрхүүд шөнөдөө эрчим хүчний хөнгөлөлт эдлэх боломжтой болно. Шөнө эрчим хүч ашиглах үнийг тэглэснээр иргэд шөнийн турш цахилгаан халаагуураа асаах боломжтой болох ба энэ нь өөрөө агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулна.
- Агаарын бохирдлыг бууруулахын тулд өөр нэг авч болох арга хэмжээ нь эрчим хүчний хэмнэлттэй зуухаар өрхүүдийг хангах асуудал юм. Одоогоор эрчим хүчний хэмнэлттэй зуухаар цөөн тооны хэдхэн дүүргүүдийг хангаад байна.
- Засгийн газар гэр хорооллыг барилгажуулах ажлаа яаравчлах хэрэгтэй. Хэрэв гэр хорооллыг барилгажуулах ажлын зардал өндөр, улсын төсөвт хүндрэл учруулж байвал гэр хорооллыг төвийн халаалт болон усан хангамжийн системд холбох сувгийг тавьж өгч асуудлыг шийдвэрлэж болох юм гэж гэр хорооллын өрхүүд үзэж байна. Ингэснээр өрхүүд өөрсдийн зардлаар байшин барилга барих боломжтой болж байгаа нь өрх гэр бүл, Засгийн газартай хамтран тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэнэ.

5.2.7. Хороо-Орон нутгийн удирдлагууд

Түгээлтийн системд орон нутгийн удирдлагууд болох хороон засаг дарга, хэсгийн төлөөлөгчид чухал үүргийг гүйцэтгэдэг. Боловсруулсан түлшийг худалдан авах ваучерийг хороон засаг дарга, хэсгийн төлөөлөгчид гүйцэтгэдэг. Түүнчлэн хороон засаг дарга нар нь боловсруулсан түлш, агаарын бохирдлын эх үндэс, агаарын бохирдол хүнийн эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийн талаарх мэдээллээр иргэдийг хангах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн хэрэглэх талаарх сургалтыг гэр хорооллын иргэдэд зориулан зохион байгуулах зэрэг асуудлыг хариуцан ажилладаг. Тиймээс иргэдийн дунд явуулсан боловсруулсан түлшний хүртээмж болон түүний үр өгөөжийн талаарх уулзалт ярилцлаганд хороон засаг дарга болон хэсгийн төлөөлөгчид нь нэг талаас өөрсдийн байр сууринаас, нөгөө талаас нэгэнт тэд өөрсдөө тухайн хороо хэсэгт амьдран халаалтандаа түлш ашигладаг тул хэрэглэгчдийн байр сууринаас оролцсон.

Хороон засаг дарга нарын хэлж байгаагаар иргэд Засгийн газраас түүхий нүүрс ашиглахыг хориглосон арга хэмжээнд таатай байна. Ялангуяа, үртсэн шахмал түлшийг түгээж эхлэхэд иргэд маш сэтгэл ханамжтай байсан. Хэсгийн төлөөлөгчид нь ваучер тараах болон ЦАС-ын судалгаанд биечлэн оролцсон. Одоогоор хорооны дарга нар түлш түгээх ажил болон агаарын чанарыг үнэлэх ажилд оролцоогүй. Боловсруулсан түлш хангалттай хэмжээгээр байхгүй байгаа тохиолдолд иргэдийг түүхий түлш ашиглахгүй байхыг шаардах нь хүндрэлтэй юм. Одоо ихэнх өрх түүхий түлш ашиглаж эхлээд байна.

Хагас коксжсон түлшний чанарын талаарх гомдол иргэдээс хороон дарга нарт нилээд их ирээд байна. Иргэд үйлдвэрлэгчид нартай шууд харьцахгүй тул хороон засаг дарга нар нь иргэдээс ирсэн гомдлыг үйлдвэрлэгч нарт дамжуулан мэдээллээд байна.

Хороон засаг дарга нар бүгдээрээ түлшний түгээлт болон хангамж хангалтгүй гэж үзсэн. Хамгийн чухал асуудал жижиглэнгийн борлуулагчид дээр байгаа түлшний

хангамж муу байгаатай холбоотой. Агаарын бохирдлын нягтралшил өндөр байгаа хороодод жижиглэн борлуулах цэг хоёр байгаа нь хангалтгүй. Иймээс, жижиглэн борлуулах цэгийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Зарим өрхүүд жижиглэн борлуулах цэгээс хол амьдарч байгаа тул тэд худалдан авсан түлшээ зөөвөрлөх унаа түрээслэн авч нэмэгдэл зардал гаргаж байгаа юм.

Хорооны засаг дарга нар боловсруулсан түлшний үнийг гэр хорооллын оршин суугчдад боломжийн, худалдан авч болохуйц болсон гэж үзэж байна. Хорооны засаг дарга нар нь ваучерийн хэрэглээг хянахгүй. Жижиглэнгийн борлуулагчид нь өрх бүрийн худалдан авалтын талаарх мэдээллийг боловсруулах бөгөөд энэ талаарх мэдээллийг хадгална.

Хорооны засаг дарга нарын үзэж байгаагаар агаарын бохирдлыг бууруулах нь зөвхөн түлш түгээх ажлаар хязгаарлагдах ёсгүй. Сайжруулсан зуухаар мөн хангаснаар сайжруулсан зуух, боловсруулсан түлшний хосолсон хэрэглээний үр дүнг туршиж үзэх хэрэгтэй гэж үздэг.

5.2.8. Жижиглэнгийн борлуулагчид

Жижиглэнгийн борлуулагчдыг сонгохдоо тэдний агуулахын багтаамж дээр үндэслэсэн. Ихэвчлэн орон нутгийн иргэд жижиглэнгийн борлуулагчдаар ажилладаг. Гэрт оршин суугчидтай шууд харилцдаг, мөн түгээлтийн системийн үр өгөөжийн талаарх мэдээллээр хангагдсан гэдэг утгаараа жижиглэнгийн борлуулагчид нь түгээлтийн гинжин хэлхээнд хамгийн чухал үүргийг гүйцэтгэдэг. Тэд мөн өөрсдөө боловсруулсан түлшийг халаалтандаа хэрэглэдэг.

Одоогийн байдлаар тэд дөрвөн төрлийн боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулж байна. Үүнд: МАК-ын бүтээгдэхүүн болох хагас коксжсон нүүрс, Шарын голын бүтээгдэхүүн болох өндгөн хэлбэртэй хагас коксжсон шахмал нүүрс, Хялганат тосгоноос нийлүүлэгддэг дундаа нүхтэй бөгөөд шар өнгөтэй үртсэн шахмал түлш, Түнхэл тосгоноос нийлүүлэгддэг үзгэн хэлбэртэй үртсэн шахмал түлш орно. Жижиглэнгийн борлуулагчид нь түлшийг тээврийн компаниудаас хүлээн авдаг. Гэвч жижиглэнгийн борлуулагчид нь түлш тэдэнд дээр ирэхээс өмнө түгээлтийн ямар ямар гинжин хэлхээний үе шатуудыг дамждаг талаар ерөөсөө мэддэггүй.

Үртсэн шахмал түлш борлуулагчдын хувьд энэхүү бүтээгдэхүүний эрэлт өндөр байдаг тул тухайн бүтээгдэхүүни жижиглэнгийн борлуулагчдын цэг дээр ирэнгүүтээ зарагддаг байна. Гэтэл, хагас коксжсон нүүрсний эрэлт маш муу. Хагас коксжсон нүүрс нь өөрөө дангаараа асдаггүй тул хүмүүс уг нүүрсийг үртсэн шахмал түлштэй хамтад нь худалдан авдаг. Хэрэв үртсэн шахмал түлш байхгүй бол худалдан авахаар хүлээдэг байна.

Боловсруулсан бүтээгдэхүүнүүдээс хамгийн их эрэлт хэрэгцээтэй нь Түнхэл тосгоноос нийлүүлэгддэг үзгэн хэлбэрийн шахмал түлш юм. Нэгэнт уг түлшний эрэлт их байдаг тул жижиглэнгийн борлуулагчид бүтээгдэхүүний хэрэглээн дээр хязгаарлалт тавин улмаар нэг өрхийн худалдан авалтыг 1-ээс 2 шуудай байхаар тогтоосон байна. МАК-ын бүтээгдэхүүн болох хагас коксжсон нүүрс нь шатах үедээ асар их хэмжээний дуу гаргадаг бөгөөд дотроо чулуе ихтэй байдгаас шатаасны дараа хаягдал ихтэй байдаг байна. Иймээс хүмүүс энэ түлшийг ашиглах дургүй юм байна. Үнийн хувьд боловсруулсан бүтээгдэхүүн нь түүхий түлшийг бодоход хямд байдаг. Жижиглэнгийн борлуулагчдын үзэж байгаагаар боловсруулсан түлшний үнэ асуудал биш юм байна. Зөвхөн боловсруулсан түлшний хангамж, түүний хүртээмжтэй байдал нь асуудлыг үүсгээд байна.

Бүтээгдэхүүний сав баглааны хувьд авч үзэхийн бол хүмүүс үртсэн шахмал түлшийг түүний сав баглаа боодол, жин хэмжээг үл харгалзан худалдан авдаг. Хагас коксжсон нүүрсний хувьд бол хүмүүс 20 килограммаар савлагдсаныг нь худалдан авах

сонирхолтой. Харин хэдэн шуудайг худалдан авах вэ гэдэг нь тухайн хэрэглэгчийн өөрсдийнх нь хэрэглээнээс шалтгаалдаг. Тэдний хэрэглээ нь ихэвчлэн тэдний түлшээ зөөвөрлөх болон санхүүгийн чадвар чадамжаас шалтгаалдаг байна.

Жижиглэнгийн борлуулагчдын ярьж байгаагаар хэрэглэгчид нь боловсруулсан түлшний хэрэглээндээ сэтгэл ханамжтай байгаа бөгөөд хэрэглэгчид боловсруулсан түлш түүхий түлштэй харьцуулахад эвгүй үнэр, утаа гаргалтаараа бага гэж үзэж байна. Сөрөг тал нь харин түлшний дараа үлдэх үнс нурамын асуудал юм. Ерөнхийдөө зарим өрх өнөөг хүртэл түүхий түлшний хэрэглээг хязгаарласан ч бай, хэрэглээний ваучераа хүлээн авсан ч бай түүнийг үл харгалзан түүхий түлш хэрэглэсээр байгаа нь агаарын бохирдолт нүдэнд харагдахаар буурч чадаагүй гэж жижиглэнгийн борлуулагчид, хэрэглэгчид үзэж байна. Энэ нь буцаад боловсруулсан түлшний байнгын бөгөөд хүрэлцээтэй нийлүүлэлт муу байгаатай холбоотой.

Боловсруулсан түлшний хүрэлцээтэй хангалт байхгүйгээс жижиглэнгийн борлуулагчид хэрэглэгчдээс ирэх байнгын гомдолтой нүүр тулж байдаг. Зарим тохиолдолд жижиглэнгийн борлуулагчид зодуулсан хэд хэдэн тохиолдол байна. Жижиглэнгийн борлуулагчид нь өнөөгийн байдлаар үртсэн шахмал түлшийг сард нэг удаа хүлээн авдаг байна. Иймэрхүү байдалтай байгаа бүтээгдэхүүний хомсдол нь хэрэглэгчдийн бухимдлыг төрүүлж улмаар бухимдлаа жижиглэнгийн борлуулагчдад гаргадаг байна. Хүмүүсийн үзэж байгаагаар энэхүү түлшний хомсдол нь тээврийн компаниуд хангалттай хэмжээний түлш тээвэрлэн авчирч чадахгүй байгаатай холбоотой. Гэтэл, нөгөө хэсэг хүмүүс үзэхдээ үртсэн шахмал түлш үйлдвэрлэх түүхий эд материал ховор байдгаас тухайн бүтээгдэхүүнийг хангалттай хэмжээгээр үйлдвэрлэж чаддаггүй бөгөөд урт хугацаанд энэхүү бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой байдал алдагддаг байна.

Гэтэл жижиглэнгийн борлуулагчид нь тухайн хороодын бүх өрхүүд ваучераа хүлээн аваагүй учир нь түлш худалдан авах ёстой өрхүүдийн зөвхөн тэн хагас нь л түлшээ худалдан авч байна гэсэн байна. Жишээлбэл, нэгэн түлш худалдан авагчын тооцоолсноор 3,000 өрхтэй хорооноос зөвхөн 800 өрх нь түлшээ худалдан авч байгаа юм байна.

Бүхэл өвлийн турш 2,5-аас гуравн тонн түлшний ваучераар хангах нь жижиглэнгийн борлуулагчдын үзэж байгаагаар бол хангалтгүй юм байна. Тэдний зарим нь хүмүүсийг хагас коксжсон түлшээр хэрхэн галлах талын сургалтанд хамруулах хэрэгтэй гэж үзэж байна. Учир нь хүмүүс хэдийн их хэмжээний түлшийг нэг удаа галлахдаа хэрэглэх талаар мэдэхгүйгээс болоод нилээд их хэмжээний түлшийг галласны дараа ямар ч үр ашиггүйгээр хаягдал болгон хаядаг байна.

Түүнчлэн жижиглэнгийн борлуулагчид ваучерийн системийг тохиромжтой гэж үзэж байна. Гэвч ваучерийг хэвлэсэн хэлбэр тийм ч үр дүнтэй болж чадаагүй байна. Жижиглэнгийн борлуулагчид нь борлуулалт бүрийн дараа ваучерийн ард тэмдэглэгээ хийх ёстой. Гэтэл ваучерийн ард талд тэмдэглээ хийх зориулалттай хүснэгт нь хэмжээгээрээ маш жижиг тул тухайн борлуулалт бүрийн дараа ваучер дээр хийгдэх энэхүү тэмдэглэгээ нь нилээд их цаг авсан бөгөөд тодорхой сайн тэмдэглэгдэх боломжоор муу хангагдаж байна. 15,000 төгрөгний үнэтэй хагас коксжсон түлш; 20,000 төгрөгний үнэтэй үртсэн шахмал түлшний ваучерууд тус тус маш жижиг хэмжээтэй тул жижиглэнгийн борлуулагчид зохих худалдан авалт бүрийн дараа тэмдэглэгээ хийх боломжгүй тул өөрийн тэмдэглэлийн дэвтэрээ ашигладаг байна. Энэхүү байдал нь хэрэглэгчдийн бухимдалыг их хэмжээгээр төрүүлдэг байна.

Нэр нууцлан жижиглэнгийн борлуулагчдын дунд асуухад, тэдний үзэж байгаагаар тээвэрлэх явцад маш олон шат дамжлагыг дамждаг тул сав баглаа боодол нь байнга урагддагаас гадна сав баглаа боодол нь аль хэдийн задарсан байдалтайгаар

жигиглэнгийн борлуулагчдын гар дээр ирдэг байна. Иймээс жигиглэнгийн борлуулагчид нь дахин савлах асуудалтай тулгардаг. Заримдаа савалгаа бүрэн дүүрэн байдаггүйгээс шалтгаалан хэрэглэгчид тэдгээр дахин савласан бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолгүй байдаг байна.

Боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрхэн хэрэглэх талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг сайжруулах хэрэгтэй гэж жигиглэнгийн борлуулагчид үзэж байна. Ямарваа нэгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсвэл хороогоор дамжуулан энэ талын мэдээллийг хэрэглэгчид аваагүй байгаа гэж тэд үзэж байна. Түүнчлэн хэсгийн төлөөлөгчид нь хэдийгээр энэ талын мэдээллээр хэрэглэгчдийг хангах үйл ажиллагаа явуулах үүрэг авсан болон холбогдох төлбөр тооцоог тэдэнд зориулан хийсэн боловч одоогоор ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байсаар байна. Жигиглэнгийн борлуулагчид нь хэрэглэгчдэд хэрхэн боловсруулсан бүтээгдэхүүн, түүнийг хэрэглэх талаарх мэдээллийг өгдөг. Үүнээс гадна, ямар зуух нь ямар түлшийг ашиглах талаар хэрэглэгчдэд танилцуулах хэрэгтэй. Жишээлбэл, боловсруулсан бүтээгдэхүүнийг бага даралтын зууханд галлахад тохиромжгүй юм.

Жигиглэнгийн борлуулагчдын ярьж байгаагаар тэдэнд түлшний хангамжийн талаар үнэн зөв найдвартай мэдээлэл байдаггүй байна. Жишээлбэл, агуулахад болон үйлдвэрт хичнээн хэмжээний түлшний нөөц боломж байгаа талаарх үнэн зөв мэдээлэл байдаггүй байна. Тэд мэдээлэл дутмаг тухайлбал түлшний хомсдолтой байдлыг хэрхэн зохицуулах талаарх тодорхой мэдээлэлгүйгээр үйлчлүүлэгчидтэй нүүр тулдаг байна. ЦАС болон НАЧА нь түлшний хангамжийн талаарх анхан шатны мэдээллээр хангадаггүй талаар шүүмжилж байна. Түүнчлэн телевизээр нүүрсний хангамж хангалттай байгаа мэтээр буруу ташаа мэдээлэл өгч байна. Үүний үр дүнд, жигиглэнгийн борлуулагчид болон хэрэглэгчдийн дунд үл ойлголцох асуудал гарч байна.

Жигиглэнгийн борлуулагчид нь борлуулсан, боловсруулсан түлшнийхээ нэг тонн тутмаас урамшуулал авдаг. Борлуулалтын орлогоо ЦАС-т тушаахаасаа өмнө тэд өөрсдөө тооцоолон нийт борлуулалтын үнийн дүнгийн нэг тонн тутмаас өөрсдийн урамшуулалдаа суутган авдаг. ЦАС-ын нягтлан бодогч болон НАЧА-ийн түлш түгээгч нар нь жигиглэнгийн борлуулагчидтай нэг дэхь өдөр болгон уулзаж борлуулсан түлшний тооцоо болон жигиглэнгийн борлуулагчид борлуулалтын орлогыг төрийн сан уруу тушаасан зэргийг тулгадаг тул ерөнхийдөө жигиглэнгийн борлуулагчид төлбөрийг долоо хоног бүрийн нэг дэх өдөр барагдуулдаг.

5.3. Бэрхшээлүүд холбогдох санал зөвлөмж

5.3.1. Түлшний түгээлт, хангамж

Олон нийттэй хэлэлцүүлсэн нь түлш түгээлтийн талаарх үйлчлүүлэгчдийн ойлголтын талаар мэдэж авах, үйлчлүүлэгчдийн түлш худалдан авах чадварын талаар судлах зорилготой. Үүний үр дүнд, үйлчлүүлэгчид нь түлшний хүрэлцээ муу байгаад сэтгэл хангалуун биш байгааг олж тогтоосон. Түлш нь хэрэглэгчдийн гар дээр очихоос өмнө түлш түгээлтийн маш олон дамжлагыг дамждагыг хэрэглэгчид мэдэхгүй байсан. Тэд түгээлтийн талаар тодорхой зүйл хэлж чадахгүй байсан бөгөөд тэдний мэдээллээр бол үртсэн шахмал түлш жигиглэнгийн борлуулах цэг дээр ирмэгцээ борлуулагдаж дуусдаг нь үртсэн шахмал түлшний эрэлт өндөр байдагтай холбоотой юм. Түлшний хангамжийн асуудал (тухайлбал, жигиглэнгийн цэгт нийлүүлэгдэж байгаа түлшний хангамж муу) тэдний тулгамдсан асуудал юм.. Мөн жигиглэнгийн борлуулах цэгийн тоог хэрэглэгчидэд хурдан шуурхай үйлчлэхийн тулд нэмэгдүүлэх, хэрэглэгчидэд үйлчлэх цагийг илүү тохиромжтой үеэр болон уян хатан байдлаар тохируулах, ваучерийн системийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Гэхдээ

эдгээр бүх арга хэмжээг боловсруулсан түлшний хангамжийг сайжруулахгүйгээр авах аргагүй юм.

5.3.2. Үнэ

Олон нийтийн уулзалт хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн ихэнх нь боловсруулсан түлшний үнэ түүхий нүүрсний үнэтэй харьцуулахад харьцангуй хямд гэж үзсэн. Гэхдээ зарим хэрэглэгчид хэдийгээр түүхий нүүрсний үнэтэй харьцуулахад боловсруулсан нүүрсний үнэ (ижил хэмжээтэйгээр) харьцангуй хямд ч (20 килограммаар савласан нэг шуудай хагас коксжсон нүүрсний үнэ 20 килограмм түүхий нүүрсний үнээс хямд) эцэст нь дүндээ дүн болж байна. Өвлийн эхэн сард өрх бүр 260,000 төгрөгийн ваучертай болсон. Гэтэл хэлэлцүүлэгийн эцэст тэдгээр өрхүүд нь аль хэдийн ваучеруудаа хэрэглээд дуусчихсан байна. Тэгэхээр өвөл дуустал ядаж гуравдугаар сарыг авна гэвэл өрхүүд гуравдугаар сарыг дуустал түлэх түлшээ нэмж худалдан авах хэрэгтэй болж байна гэсэн үг. Ерөнхийдөө нэг өрх бүтэн өвлийн турш нийтдээ 500,000 төгрөгт багтаан мод болон нүүрс түлээгээ базаадаг байна.

5.3.3. Жижиглэнгийн борлуулах цэгийн байршилт, түүний сонголт

Жижиглэнгийн борлуулах цэгийн байрлалыг хэрхэн сонгосон талаарх мэдээлэл маш муу байна. Уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдын үзэж байгаагаар НАЧА хорооны удирдлагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхой шалгууруудын дагуу борлуулах цэгийн байршилыг тогтоосон байна. Гэвч, хүн ам ихтэй зарим хороодод жижиглэн борлуулах цэгийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Гэхдээ жижиглэн борлуулах цэгийг сонгох үйл явц тодорхой байх хэрэгтэй бөгөөд ингэж чадсанаар жижиглэнгийн борлуулагчдын дунд үл ойлголцох асуудлыг үүсгэхгүй. Жижиглэнгийн борлуулах цэгтэй холбоотойгоор үүссэн бас нэг асуудал бол түүхий түлш хэрэглэхийг хориглосонтой холбоотойгоор өмнө нь энэ түлшийг борлуулж байсан цэгүүдийг түүхий түлш борлуулахыг хориглосон. Урьд нь тэд түүхий нүүрс болон мод түлээ борлуулдаг байсан байна. Гэтэл өмнө үйл ажиллагаагаа явуулж байсан эдгээр түүхий түлш наймаалагчид нь тэдний үйл ажиллагааг хорих гэж байгаа шийдвэрийн талаар тэдэнд урьдчилан мэдэгдээгүй гэж үзэж байгаа юм. Иймээс тэдний олох орлогогүй болсон. Энэ үүсээд байгаа асуудлыг одоо судлан үзэх зорилгогүй учраас дараа жилийн судалгаанд тухайн асуудлыг хөндөн үзэх боломжтой.

5.3.4. Ваучерийн систем

Гэрт амьдран суугчдын хэлж байгаагаар ваучер түгээлтэнд ямар нэгэн асуудал гараагүй. Ваучертай холбогдон гараад байгаа цорын ганц асуудал бол Баянгол дүүргийн долоон хороодын иргэд өөрсдийн ваучераа аль хэдийн хэрэглээд дуусчихсан байхад Засгийн газраас нэмж ваучер олгох шийдвэр одоог хүртэл гаргаагүй. Нэмж олгогдох ваучерийн асуудал аль болох хурдан шийдэгдэхгүй бол хэрэглэгчид түүхий нүүрсээ хэрэглэж эхлэхээс өөр аргагүй юм байна.

Хашаа байшингаа хувьчилж авсан иргэдийн хувьд мөн ваучер түгээлттэй холбоотой асуудал үүссэн. Бусдын эсвэл хамаатныхаа хашаанд түр зуур амь зууж байгаа иргэд энэ асуудлыг хөндөөгүй. Иймээс ваучерын системийн нааштай байдлын талаарх шалгууруудыг дахин авч хэлэлцэх хэрэгтэй. Хэрэв бусдын хашаанд түр амьдран суугчдыг санал асуулгаас хасвал агаарын бохирдлыг бууруулах асуудал шийдэгдэхгүй.

Мөн түүнчлэн ваучерийн загвар өөрөө тийм ч үр дүнтэй биш байна. Өмнө

дурьдсанчлан одоо байгаа ваучерийн ар талд боловсруулсан түлш борлуулагчид нь борлуулалт бүрийн талаар нэг бүрчлэн бүртгэх боломжоор бүрэн хангагддаггүй. Иймээс дараа жил гэхэд ваучерийн шинэчилсэн загварыг гаргаж түлш борлуулагчдын гомдлыг барагдуулах хэрэгтэй.

5.3.5.Түлшний чанар

Хэдийгээр хэрэглэгчидтэй уулзаж ярилцахын гол санаа нь түлш тус бүрээр түлшний чанарын талаар судлах зорилгогүй байсан ч иргэд хагас коксжсон нүүрсний чанарт сэтгэл ханамжгүй байгаа талаараа илэрхийлсэн. Гэхдээ хагас коксжсон бүтээгдэхүүний хомсдол байхгүй байгаа нь энэ бүтээгдэхүүний давуу тал болно. Хэрэглэгчид мөн түлшний чанар өвлийн турш анх ирж байсантайгаа харьцуулахад сайжирсан гэж үзэж байна.Ирэх жил үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн хоорондын харилцааг сайжруулах системтэй болох нь зүйтэй байна. Мөн ЦАС нь үйлдвэрлэгчид боловсруулсан түлш үйлдвэрлэх явцдаа Монголын түлшний стандартыг дагаж мөрдөж байгаа талаар хянах хэрэгтэй. Хэрэглэгчдийн нүүрсний талаар гаргаж байгаа санал хүсэлтийг үйлдвэрлэгчдийн чихэнд байнга хүргэж байх хэрэгтэй. Хэсгийн ахлагч, хорооны дарга нарын бүтээгдэхүүний талаарх ойлголт нь үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдийн харилцааны дунд хаягдаж болох зарим мэдээллийг сэргээнэ. Ялангуяа хэсгийн төлөөлөгчид нь агаарын бохирдлыг бууруулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулсны төлөө урамшуулал хүртдэг тул тэд боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад үүсч байгаа ямарваа нэгэн асуудлыг үнэлж дүгнэх чадвартай байх хэрэгтэй. Агаарын бохирдлыг бууруулах хэсгийн төлөөлөгчдийн олж мэдсэн зүйлсийг үг хэллэгийн хувьд цэгцлэх, хэрэглэгчдийг үйлдвэрлэгчидтэй холбох харилцааг үүсгэх системийг бий болгох тэдний хариуцлагыг албан ёсны болгох, боловсруулсан түлшний ашиг тусыг иргэдийн дунд сурталчлах үйл ажиллагааг явуулах, бүтээгдэхүүний талаарх олон нийтийн мэдлэгийг сайжруулах зэрэгт нь дэмжлэг болгох үүднээс хуульчдыг тэдний үйл ажиллагаанд татан оруулах нь зүйтэй,

5.3.6.Түлшний талаарх олон нийтийн мэдлэг

Олон нийттэй нээлттэй хэлэлцсэний үндсэн дээр олон нийтийн мэдлэгийг сайжруулах компаниг ажлын талаарх тэдний саналын сонссон юм. Ерөнхийдөө, хүмүүс боловсруулсан түлшний талаарх ямарваа мэдлэг мэдээлэлгүй байсан. Ихэнх олон нийтийн мэдлэгийг сайжруулах үйл ажиллагаа нь эрчим хүчний хэмнэлттэй зуухыг хэрхэн хэрэглэхтэй холбоотойгоор явагдсан. Иймээс, иргэдийн боловсруулсан түлшний талаарх мэдлэгийг сайжруулахын тулд дараах төрлийн үйл ажиллагааг явуулах хэрэгтэй:

- Хүмүүс шинэ бүтээгдэхүүнийг хэрэглэж сурахын тулд нилээд их цаг зарцуулсан. Ялангуяа, хагас коксжсон нүүрсийг ашиглаж сурахад. Хэрэв үйлдвэрлэгчид нь бүтээгдэхүүний онцлог, түүнийг хэрхэн галлах талаар иргэдэд тайлбарлаж өгөх нь хэрэглэгчдэд их тус дөхөм болох юм.
- Өрхүүдийн боловсруулсан түлшийг хэрэглэх шалгарсан аргуудаас харуулсан зурагт хуудас, гарын авлага, товхимол ном зэргийг гаргах шаардлагатай. Зарим өрхүүд олон төрлийн боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрэглэх шалгарсан аргуудтай болоод амжсан. Эдгээр төрлийн туршлагауд нь өрх бүл хооронд хуваалцах ёстой.
- Боловсруулсан бүтээгдэхүүний үнийн тооцоог түүхий түлштэй харьцуулан нарийвчлан хийж боловсруулсан бүтээгдэхүүний үр ашгийг олон нийтэд харуулах, сурталчлах хэрэгтэй.
- Боловсруулсан бүтээгдэхүүний эрүүл мэндэд нөлөөлөх давуу талыг сурталчлан харуулах хэрэгтэй.

6. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Ярилцлагын тэмдэглэл, олон нийттэй хийсэн зөвлөлдөөний үр дүн

Орон нутгийн захиргааны төлөөлөгчид

Орон нутгийн захиргаа, Баянгол дүүргийн 10-р хорооны засаг дарга

2011оны 12-р сарын 21; 11:00 – 12:00:

Хорооны засаг дарга Энхжаргалтай хийсэн ярилцлага

1) *Танай хороо болон хэсгийн газар нутгийн хязгаар болон хүн ам түүний нягтшилт, нийгэм эдийн засаг, дэд бүтцийн байдлын онцлог нөхцөл байдлын талаар товч танилцуулна уу? /тоо өрхийн тоо, амьжиргааны түвшин болон ажилгүйдэл ядуурлын түвшин/*

Хороонд зам, эсвэл гудамжны гэрэлтүүлэг гэх мэт дэд бүтэц байхгүй. Нийтийн тээвэр нь хорооны газар нутагт байхгүй. Хорооны гуравны нэг нь хөдөөнөөс шилжин ирсэн оршин суугчдаас бүрддэг. Ялангуяа 10, 11 ба 12-р гудамжнуудад гуу жалган дээр хашаа барьж буй шилжин ирэгсэд амьдардаг. Түүнчлэн гудамжнууд руу орж, гарахад их хүндрэлтэй, их нарийхан болсон. Энэ нь замын ажлыг боломжгүй болгож байгаа юм. Хүн амын нягтшил маш их. Ажилгүйдэл ба ядуурлын түвшин бусд хороодуудтай адил хэмжээнд байна.

2. *Танай хороонд түүхий нүүрс хэрэглэхийг хориглосоныг иргэд хэр хүлээж авч байна вэ?*

Агаарын бохирдлын нөлөөг хүн бүр ойлгож байгаа. Тийм ч учраас түүхий нүүрсний хоригийг эсэргүүцэх хүн байхгүй байна.

3. *Агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийг тогтоон түүхий нүүрс хэрэглэхгүй байх, шахмал түлшийг бодлогоор дэмжин түгээж байгаа энэ процессэд хороо, хэсэг ямар үүрэг рольтой оролцож байна вэ?*

Хорооны удирдлагууд түүхий нүүрс борлуулж буй цэгүүдийг хааж байна.

4) *Хороо хэсгийн хувьд энэ зорилтын хүрээнд зохион байгуулахад хэр боломжийн байна вэ?Та хороондоо агаарын бохирдлыг бууруулах зорилгоор бусад байгууллагуудтай хэрхэн уялдан ажилладаг вэ?*

Хорооны захиргааны төлөөлөгчид үйлдвэрлэлийн талбайд зочилсон. Хорооны удирдлагууд шатах үед гардаг дуу чимээний талаарх гэрийн оршин суугчдын санаа зовнилыг дамжуулсан юм. Мөн хүмүүс хагас коксжсон нүүрсэн шахмал түлш их чулуутай байдаг санаа зовдоогоо хэлсэн юм. Компани хэлэхдээ энэ дуу чимээ нь аюултай биш мөн тэд энэ асуудлыг шийдвэрлэхийг хичээх болно гэсэн юм. Компанийн төлөөлөгчид мөн товч сургалт явуулсан. Цаашид компаниуд илүү олон борлуулагчдыг сургах хэрэгтэй учир нь тэд хэрэглэгчдэд сайн тайлбарлах ёстой. ЦАС мөн гэр хорооллын оршин суугчдад брошур тараасан.

5. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн борлуулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр ончтой зохицуулалт вэ?*

Тэр хэлэхдээ дүүргийн агуулахаас борлуулагчдад боловсруулсан түлшийг хүргэх ажлыг Агаарын чанарын алба гүйцэтгэдэг. Түгээлт өнгөрсөн 10-р сард эхэлсэн ба эхэн үедээ их үр өгөөжтэй байв. Гэвч хэдийгээр хэрэглэгчдийн зүгээс ихээхэн эрэлттэй байсан боловч өнгөрсөн

11-р сарын сүүлээс үртсэн шахмал түлш хомсдсон. Тэд тээвэрлэгч компанид гомдол гаргах бүртээ үйлдвэрлэгчид боловсруулсан түлшийн хангалттай хэмжээнд үйлдвэрлэхгүй байгаа мөн агуулахууд хангалттай хэмжээний үртсэн шахмал түлш үйлдвэрлэхгүй байгааг хэлж байсан юм. Энхжаргал гуай хангалттай түлш (үртсэн шахмал түлш) үйлдвэрлэгдсэн цагт л түгээлтийн систем жинхэнэ утгаараа ажиллана гэж бодож байгаагаа хэлсэн юм.

6. *Нийт айл өрхийн хэдэн хувь одоогоор шахмал түлш хэрэглэж байгаа вэ? Хүмүүс голдуу ямар төрлийн боловсруулсан түлш хэрэглэдэг вэ?*

Тэрээр хорооны бүх айл өрх үртсэн шахмал түлш ба хагас коксжсон түлш зэрэг боловсруулсан түлш хэрэглэж байгааг баталгаажуулсан юм. Хүмүүс үртсэн шахмал түлшийг ялангуяа хүмүүсийн нэрлэдгээр “харандаан шахмалт түлш” хэрэглэхийг илүүд үздэг. Хүмүүс хагас коксжсон түлшинд тийм ч таатай ханддаггүй учир нь их үлдэгдэл гардаг, энэ зуухнаас зайлуулахад хүндрэлтэй ба “харандаан шахмал түлш” байхгүй үед асдаггүй байна.

7. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт , гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

Оршин суугчид голдуу хагас коксжсон түлшний талаар гомдоллодог яагад гэвэл энэ шахмал түлш нь их үлдэгдэл ялгаруулдаг ба үнс болдоггүй юм. Тийм ч учраас хүмүүс МАК-ын үйлдвэрлэсэн хагас коксжсон нүүрсийг хэрэглэх дургүй байдаг.

8. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Боловсруулсан түлшний зарим сайн талууд бий. Жишээлбэл хагас коксжсон нүүрс нь түүхий нүүрс шиг муухай үнэр ялгаруулдаггүй.

9) *Иргэд түгээлтийн системийн талаар ямар бодолтой байдаг вэ? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол нөхцөл байдлыг хэрхэн сайжруулбал зүйтэй вэ?*
Үйлдвэрлэгчид үртсэн түлш нийлүүлж байгаа цагт түгээлтэй холбоотой асуудал байхгүй.

10) *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн ианайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Борлуулагчид нь долоо хоногт нэг удаа хагас коксжсон нүүрс , ойролцоогоор сард нэг удаа үртсэн шахмал түлш хүлээж авдаг байна. Одоогийн байдлаар оршин суугчид үртсэн шахмал түлшний хомсдолд ороод байна. Тэрээр түлшний хомсдолын шалтгаан юу болохыг мэдэхгүй байсан.

11) *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Бүх айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэх ваучераа. 3 тонн хангалттай биш. Түгээлт эхэлснээс хойш хүмүүм бараг бүх ваучерээ үртсэн шахмал түлшинд зарцуулсан байна. Яагад гэвэл тэр үед хагас коксжсон нүүрс нийлүүлэгдээгүй байсан юм. Ваучерийн систем дажгүй ажиллаж байгаа. Гэвч хорооны захиргаа зөвхөн тодорхой хороонд бүртгэлтэй байнгын оршин суугчдад ваучер олгож хашаа түрээслэн амьдарч байгаа хүмүүст олгохгүй байгаа юм. Түүнчлэн хашааг түрээслэн олноороо оршин суугчид ваучер авах эрхгүй юм. Зөвхөн өөрийн байшингаа түрээслэхээр барьсан хашааны эзэмшигч ваучер авах эрхтэй ба тэрээр амьдардаг айлууддаа тараах боломжтой. Энэ их утгагүй зүйл.

12. *Тухайн өрхийг ваучерээр олгогдох түлшнээсээ ямар хэмжээтэйг нь худалдан авсан эсвэл огт хэрэглэхгүй байгааг хянах боломж байгаа юу? Ваучерийн ач холбогдол юу вэ?*

Хорооны захиргаанаас худалдаж авч байгаа эсвэл хэрэглэж байгаа түлшинд хяналт

тавьдаггүй. Хорооны захиргаа бүртгэгдсэн айл өрх бүрт 3 тонн боловсруулсан түлшний ваучер тарааж байгаа юм. Борлуулагчид хэрэглэгчдийн худалдаж авсан түлшний хэмжээг тэмдэглэдэг. Тэд голдуу энэ тэмдэглэл дээрээ тулгуурлан өрх бүр хэр хэмжээтэйг худалдан авсан, хэр зэрэг үлдсэнийг зэрэг түгээлтийг хянадаг.

13. *Түлш борлуулан үнийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Танай хорооны айл өрхүүдэд үнийн хувьд хэр тохиромжтой байна вэ?*

Түлшний үнэ боломжийн. Түлшний үнэ нь гэр хорооллын оршин суугчид голдуу авах байсан түүхий нүүрсний үнээс хамаагүй бага.

14) *Түүхий нүүрс хэрэглэж байгаа айл өрхүүд байгаа юу? Байгаа бол яагаад тэд түүхий нүүрс хэрэглэж байгаа вэ?/хязгаарлалтын бүсэд байдаг хэрнээ/ Энэ талаар хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа юу?*

Тогтмол нийлүүлэлт байхгүй байсан болохоор хүмүүс түүхий нүүрс ашиглаж эхлээд байна. Хорооны захиргаа хүмүүсийг түүхий нүүрс түлэхийг нь хориглож чадахгүй яагаад гэвэл оронд хэрэглэх зүйл байхгүй. Хүмүүс түүхий нүүрсийг шөнийн цагаар тээвэрлэж байна. Тийм ч учраас хянахад хэцүү юм.

15. *Түүхий нүүрсний хориг нь агаарын чанарт хэрхэн нөлөөлж байна вэ? Та түүхий нүүрсний хоригийн талаар юу гэж бодож байна вэ? Энэ хоригын оронд өөр юу хийгдэж болох вэ?*

Агаарын чанар сайжирсан. Гэвч хэрэв боловсруулсан түлш тогтмол нийлүүлэгдэхгүй бол хүмүүс буцаад түүхий нүүрс ашиглаж эхэлнэ.

16) *Иргэд шахмал түлш үйлдвэрлэж байгаагын давуу тал нь юу вэ? Боловсруулсан түлш түлэхэд хэр их хаягдал ялгардаг вэ? Шахмал түлш илүү их үнс ялгаруулдаг уу? Гадаах болон дотоод орчинд мэдээгдэхүйц өөрчлөлт ажиглагдсан уу? Утаа, тоос, эвгүй үнэр,тортог зэрэг боловсруулсан түлш ашигласнаар багассан уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа юу?*

Хүмүүс боловсруулсан түлш хэрэглэх дуртай учир нь түүхий нүүрстэй харьцуулахад гэр доторхыг бага бохирдуулж, муухай үнэр бага ялгаруулдаг зэрэг давуу талуудтай.

17) *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц,хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Хагас коксжсон шахмал түлш нь хана ба нам даралтын зуухнуудыг халаахад ашиглагдах боломжгүй. Үйлдвэрлэгчид хана ба нам даралтын зуухыг халаахад тохиромжтой шахмалт түлш үйлдвэрлэх боломж бололцоог хайхад хүчин чармайлтаа зарцуулах хэрэгтэй.

18) *Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын бохирдлыг бууруулах ба боловсруулсан түлшний талаар олон нийтийн мэдээллийг сайжруулах материал хүлээн авдаг уу? Ухуулга сурталчилгааны үйл ажиллагаануудын чанарын талаар юу гэж бодож байна вэ? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчдад хүргэх ёстой гол санаа юу вэ?*

Гэр хорооллын оршин суугчдын дунд илүү сайн ухуулга сурталчилгаа хэрэгтэй байгааг хэлсэн.Ялангуяа үйлдвэрлэгчид түлшийг хэрхэн түлэх талаар сургалт явуулах нь зүйтэй.

19) *Таны бодлоор хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Хүмүүс телевизээр мэдээлэл их авдаг. Тийм ч учраас тв нь мэдээлэл тараах хамгийн сайн арга юм.

Орон нутгийн захиргаа, Баянгол дүүргийн 23-р хорооны засаг дарга

2011оны 12-р сарын 22; 11:00 – 12:00:

Хорооны засаг дарга Нацагдоржтой хийсэн ярилцлага

1) *Танай хороо болон хэсгийн газар нутгийн хязгаар болон хүн ам түүний нягтшилт, нийгэм эдийн засаг, дэд бүтцийн байдлын онцлог нөхцөл байдлын талаар товч*

танилцуулна уу? /тоо өрхийн тоо, амьжиргааны түвшин болон ажилгүйдэл ядуурлын түвшин/

23-р хороо нь 11-р хорооны шинээр байгуулагдсан хэсэг юм. 11-р хорооны хүн ам их болж байсан учир хороог хоёр болгож хуваахаар шийдвэрлэсэн юм. Энэ хороонд 1500 айл өрх бий. Хороо нь голдуу дов толгодтой газар оршдог учир зөв зохистой дэд бүтэц байдаггүй. Хорооны газар нутагт сургууль, цэцэрлэг байдаггүй. Хороо зөвхөн гэрийн оршин суугчдаас бүрддэг. Ядуурал ба ажилгүйдлийн түвшин Баянгол дүүргийн бусад хороодтой адилхан.

2) *Танай хороонд түүхий нүүрс хэрэглэхийг хориглосоныг иргэд хэр хүлээж авч байна вэ?*

Хүмүүс засгийн газрын шийдвэрийг их эерэгээр хүлээж авсан. Гэвч боловсруулсан түлшний нийлүүлэлт тогтмол биш ба түлшний хэмжээ хангалтгүй юм. Тийм ч учраас хүмүүс илүү сайн, тогтмол нийлүүлэлтийг үйлдвэрлэгчдээс хүсэж байна.

3. *Агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийг тогтоон түүхий нүүрс хэрэглэхгүй байх, шахмал түлшийг бодлогоор дэмжин түгээж байгаа энэ процессэд хороо, хэсэг ямар үүрэг рольтой оролцож байна вэ?*

Хороо гэрин оршин суугчдад ваучер тарааж байна. Хорооны удирдлагууд хүмүүст түүхий нүүрс хэрэглэхгүй байхыг сануулж байгаа боловч түлш хангалтгүй байгаагаас болоод хүмүүс түүхий нүүрс хэрэглэхээс өөр аргагүй байгаа юм. Гэвч Нацагдорж гуай хэлэхдээ Чингэлтэй дүүргийн хөрш нэгэн хорооны түлш түгээх цэгүүд “харандаан шахмал түлш” –ийг хоёр дахин их үнээрх борлуулж байна. Тэрээр Агаарын чанарын алба ба цагдаагийн газруудад үүний талаар мэдэгдсэн байна. Хорооны иргэд нь түлшний хомсдолоос болоод хэцүүдэж байхад хориг тавиагүй бүсэд түлш зарагдаж байгаа нь шударга бус юм гэдгийг дурьдаж байсан.

4) *Хороо хэсгийн хувьд энэ зорилтын хүрээнд зохион байгуулахад хэр боломжийн байна вэ?Та хороондоо агаарын бохирдлыг бууруулах зорилгоор бусад байгууллагуудтай хэрхэн уялдан ажилладаг вэ?*

Тэрээр одоо бүх зүйл үйлдвэрлэгчдээс шалтгаалж байна гэж бодож байгаагаа хэлсэн. Хэрэв үйлдвэрлэгчид хүмүүст хангалттай түлш нийлүүлвэл зөвхөн боловсруулсан түлш хэрэглэхэд бэлэн байгаа юм.

5. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн борлуулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр онвчтой зохицуулалт вэ?*

Одоогоор шахмал түлш ба хагас коксжсон түлш борлуулах хоёр цэг байгаа.Түлшний хомсдолоос болоод хүмүүс борлуулах цэгүүд дэх борлуулагчдыг сүрдүүлж, зарим тохиолдолд цохиж, зодуулсан байна. Хорооны захиргаа нь Агаарын чанарын албанд борлуулах цэгийнхээ тоог нэмэх талаар санал тавьсан боловч эдгээр хоёр цэг нь хангалттай гэсэн хариулт авсан байна. Тэрээр нийлүүлэлт хангалтгүй учир энэ бас зөв байж болохыг нэмж хэлсэн юм. Тээвэрлэлтийн компаниуд нь машин тэрэг амралтын өдрүүдээр ажиллах боломжгүй байдаг шалтгаанаас болоод амралтын өдрүүдээр тээвэрлэлт хийдэггүй. Гэр хороолол дахь ихэнх хүмүүс түлшээ амралтын өдрөр авахыг илүүд үздэг.

6. *Нийт айл өрхийн хэдэн хувь одоогоор шахмал түлш хэрэглэж байгаа вэ? Хүмүүс голдуу ямар төрлийн боловсруулсан түлш хэрэглэдэг вэ?*

Түүхий нүүрсний хориг хэрэгжиж эхэлснээс хойш бүх айл өрх боловсруулсан түлш хэрэглэж эхэлсэн. Гэвч түлшний (“харандаан шахмал түлш”) хомсдолоос болоод 2000тонноос зөвхөн 500-600 борлуулагдсан. Хүмүүс “харандаан түлшинд” илүү дуртай.

7. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт , гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

“Харандаан түлшний” чанар маш сайн. Амархан асдаг ба жижиг хаягдал үлдээдэггүй. МАК-ын хагас коксжсон нүүрс нь нилээн их дуу чимээ гаргадаг байна.

8. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Боловсруулсан түлш ашиглахад хүндрэлтэй биш. Хүмүүс хагас коксжсон нүүрс шатаахад гардаг дуу чимээний талаар зовниж байгаагаа хэлсэн. Түүнчлэн хагас коксжсон нүүрс нь их хэмжээний жижиг хаягдал үлдээдэг. Гэхдээ хүмүүс голдуу боловсруулсан түлшний нийлүүлэлт ба чанарын талаар гомдоллодог.

9) *Иргэд түгээлтийн системийн талаар ямар бодолтой байдаг вэ? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол нөхцөл байдлыг хэрхэн сайжруулбал зүйтэй вэ?*
Хүмүүс борлуулагчдд тогмтол түлш түгээж байгаа цагт түгээлтийн системийн талаар санаа зовохгүй байсан юм.

10) *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн танайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Нацагдоржын үзэж байгаагаар хоёр борлуулах цэг байгаад асуудалгүй гэж үзэж байгаа юм. Хамгийн том асуудал нь түлшний хомсдол юм. Түлшний хомсдолын шалтгаан нь үйлдвэрүүд хангалттай хэмжээний түлш үйлдвэрлэж чадахгүй байгаа юм.

11) *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Ваучер тараахтай холбоотой ямар нэгэн асуудал байхгүй гэж хэлсэн. Гэвч 2.5-3 тонн хязгаарлалт нь дэндүү бага тоо юм. Тэрээр 2.5-3 тонн түлшний тооцоолол нь дэндүү буруу гэдгийг дурьдсан. Тооцооллыг гэр хорооллын оршин суугчид ба хорооны удирдлагууд өөрөр хэлбэл орон нутгийн төлөөлөгчдийн оролцоотойгоор хийх шаарлагатай байсан юм. Зөвхөн хэмжээ бус дулаан ялгаруулалт, чанар зэргийг нийт 2.5 тонны хязгаарын тооцоолол хийхэд авч үзэх шаардлагатай байсан юм.Түүнчлэн энэ түлш зөвхөн гэр зууханд зориулсан учир нам даралтын зуухтай айл өрхүүд боловсруулсан түлш үйлдвэрлэж чадахгүй байгаа юм.

12. *Тухайн өрхийг ваучерээр олгогдох түлшнээсээ ямар хэмжээтэйг нь худалдан авсан эсвэл огт хэрэглэхгүй байгааг хянах боломж байгаа юу? Ваучерийн ач холбогдол юу вэ?*

Хорооны захиргаа ваучерийг хянах талаар ямар нэгэн зүйл хийдэггүй. Борлуулагчдад айл өрхүүд ба тэдгээрийн түлшний хэрэглээний талаар жагсаалт бий. Нийт 2.5-3 тонны худалдан авах эрхтэй ваучерийг нэг удаа олгосон байна.

13. *Түлш борлуулан үнийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Танай хорооны айл өрхүүдэд үнийн хувьд хэр тохиромжтой байна вэ?*

Түлшний үнэ зүгээр. Гэр хорооллын оршин суугчдаас түлшний үнэтэй холбоотой ганцхан гомдол гарсан. Хүмүүс боловсруулсан түлш ба түүхий нүүрсний үнийг хялбархан харьцуулж чаддаг ба энэ үнэ боломжийн гэж хэлж байсан.

14) *Түүхий нүүрс хэрэглэж байгаа айл өрхүүд байгаа юу? Байгаа бол яагаад тэд түүхий нүүрс хэрэглэж байгаа вэ?/хязгаарлалтын бүсэд байдаг хэрнээ/ Энэ талаар хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа юу?*

Түүхий нүүрс хэрэглэж байгаа зарим айл өрхүүд бий. Энэ нь боловсруулсан нүүрсний нийлүүлэлт тогтмол бус ба хүмүүс түлшний хомсдолд ордогтой холбоотой юм. Хорооны захиргаа хүмүүсийн түүхий нүүрс түлэхийг хориглох эрх байхгүй учир нь одоогоор борлуулах цэгүүдэд түлш байхгүй ба энэ хүйтний улиралд хүмүүс халаалтын зорилгоор ямар нэгэ юм түлэх хэрэгтэй болдог.

15. *Түүхий нүүрсний хориг нь агаарын чанарт хэрхэн нөлөөлж байна вэ? Та түүхий нүүрсний хоригийн талаар юу гэж бодож байна вэ? Энэ хоригын оронд өөр юу хийгдэж болох вэ?*

12-р сар хүртэл агаарын чанар өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад илүү сайн байсан. Гэвч хүйтний улирал гэнэт эхэлсэн мөн боловсруулсан түлшний хомсдолоос болоод айл өрхүүд түүхий нүүрс ихээр хэрэглэж эхэлсэн байна. Тийм ч учраас одоогийн байдлаар агаарын чанар нь өмнө байсантай адил байна.

16. *Иргэд шахмал түлш үйлдвэрлэж байгаагын давуу тал нь юу вэ? Боловсруулсан түлш түлэхэд хэр их хаягдал ялгардаг вэ? Шахмал түлш илүү их үнс ялгаруулдаг уу? Гадаах болон дотоод орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдсан уу? Утаа, тоос, эвгүй үнэр, тортог зэрэг боловсруулсан түлш ашигласнаар багассан уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа юу?*

Мэдээжийн хэрэг хүмүүс боловсруулсан түлшний давуу талуудыг ойлгож байгаа. Жишээлбэл хагас коксжсон нүүрс нь муухай үнэр гаргадаггүй. Гэвч хагас коксжсон шахмал түлш нь ихээхэн жижиг хаягдал үлдээдэг, үнс болдоггүй. Тийм ч учраас уг хаягдлыг зуухнаас авч хаяхад хэцүү мөн хаягдлын хэмжээ түлэхээс өмнө хагас коксжсон нүүрсний хэмжээтэй тэнцүү байдаг. Түүнчлэн хагас коксжсон шахмал түлш нь шатсныхаа дараа хатуу үнс болон хувирдаг их хэмжээний үлдэгдэл бий болгодог байна.

17. *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц, хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Түлшний үйлдвэрлэлийг их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатайг санал болгосон. Боловсруулсан түлшний зэрэгцээ засгийн газар гэр хороололд орон сууц барих зэрэг тохиоохон хөгжлийн бодлогуудыг авч үзэх нь зүйтэй. Үүнийг гэр хорооллын оршин суугчдаас газрыг нь худалдан авч оронд нь орон сууцаар хангах байдлаар хэрэгжүүлэх боломжтой. Ийм маягаар, иймэрхүү бодлогууд агаарын бохирдлын асуудалд аль аль талд хожил авчирсан шийдэл болох юм. Түүнчлэн “Сайн хөрш” хэмээн Солонгосын нэгэн ТББ 23-р хорооны гэр хорооллын оршин суугчдад дулааныг хадгалагч/эрчим хүчинд хэмнэлттэй хэрэгсэл түгээсэн юм. Энэ нь дулаанаа 6 цаг хүртэл барих боломжтой ба хүсүүсийн сэтгэгдэл их өндөр байв. Илүү сайн үр дүнд хүрэхийн тулд боловсруулсан түлшний зэрэгцээ энэ төрлийн шинэ хэрэгслүүдийг түгээх нь зүйтэй юм.

18. *Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын бохирдлыг бууруулах ба боловсруулсан түлшний талаар олон нийтийн мэдээллийг сайжруулах материал хүлээн авдаг уу? Ухуулга сурталчилгааны үйл ажиллагаануудын чанарын талаар юу гэж бодож байна вэ? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчдад хүргэх ёстой гол санаа юу вэ?*

Боловсруулсан түлшний сурталчилгаа хангалттай байгаагүй гэж бодож байгаагаа хэлсэн. Гол санаа нь боловсруулсан түлшийн үнэ, чанарыг түүхий нүүрстэй харьцуулан харуулах байх нь зүйтэй.

19. *Таны бодлоор хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Телевиз ялангуяа Үндэсний телевиз нь олон нийтийн ухуулга сурталчилгаа явуулахад тохиромжтой учир нь хүмүүс оройн мэдээг их үздэг.

Орон нутгийн захиргаа, Баянгол дүүргийн 10-р хорооны хэсгийн ахлагч

2011 оны 12-р сарын 20; 11:00 – 12:00:

8-р хэсгийн дарга Өлзийхишиг ба

10-р хорооны ИТХ-ын дарга Туяатай хийсэн ярилцлага

1) *Танай хороо болон хэсгийн газар нутгийн хязгаар болон хүн ам түүний нягтшилт, нийгэм эдийн засаг, дэд бүтцийн байдлын онцлог нөхцөл байдлын талаар товч танилцуулна уу? /тоо өрхийн тоо, амьжиргааны түвшин болон ажилгүйдэл ядуурлын түвшин/*

Баянгол дүүргийн 10-р хороо нь 2800 өрхтэй, 6000 гаруй хүн амтай. Хүн амын нягтшил ихтэй. Гэр хороолол ихтэй юм. 8-р хэсгийн хувьд 245 өрхийн 1010 хүн амтай. Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэдэг ба хорооныхоо хамгийн алслагдсан хол хэсэгт ордог. 8-р хэсэг нь газарзүйн байдлын хувьд уулын өндөрлөг хэсэгт байрлах ба гуу жалга ихтэй, зам муутай нийтийн тээврийн үйлчилгээгүй, нийгмийн үйлчилгээнээс хол хэсэг юм.

2. *Танай хороонд түүхий нүүрс хэрэглэхийг хориглосныг иргэд хэр хүлээж авч байна вэ?*

Манай хороо хэсэгт түүхийн нүүрсийг хориглосон Засгийн газрын шийдвэрийг иргэд маш эерэгээр хүлээн авсан. Иргэд анх удаа нийлүүлсэн харандаан түлш /үртсэн шахмал түлш/-ийг маш сайнаар хүлээн авч хэрэглэсэн боловч одоогоор түлшний хангамж муу байгаа учраас иргэд маш их бухимдалтай байгаа.

3. *Агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийг тогтоон түүхий нүүрс хэрэглэхгүй байх, шахмал түлшийг бодлогоор дэмжин түгээж байгаа энэ процессэд хороо, хэсэг ямар үүрэг рольтой оролцож байна вэ?*

Шахмал түлш нийлүүлэх бодлогоор дэмжих ажилд хэсгийн ахлагч нар өрхүүдэд баучер тарааж ажилласан. Мөн Цэвэр агаарын сангаас шаардсан 16 төрлийн судалгааг хэсэг хэсгээр нь гаргаж өгсөн. Одоогоор бол хэсгийн ахлагчийн оролцоо үүрэг роль байхгүй байгаа. Шахмал түлш цаанаасаа ирж борлуулах цэгээр дамжаад борлуулагддаг учраас хэсгийн ахлагчийн оролцох шаардлага байхгүй.

4) *Хороо хэсгийн хувьд энэ зорилтын хүрээнд зохион байгуулахад хэр боломжийн байна вэ?Та хороондоо агаарын бохирдлыг бууруулах зорилгоор бусад байгууллагуудтай хэрхэн уялдан ажилладаг вэ?*

Хорооны хувьд шахмал түлшийг сурталчилдаг, бусад байгууллагуудтай /үйлдвэрлэгч, түгээгч, тээвэрлэлт/ ямар нэгэн холбоо байхгүй. Цэвэр агаарын сантай анх баучер тараах, судалгаа хийхэд л холбогдож ажилласан. Нэг л удаа МАК- компани хэсгийн ахлагчийг оролцуулж үйлдвэр дээрээ аваачсан нь их үр дүнтэй болсон. Анхан шатны мэдлэг олж авсан.

5. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн болруулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр онвчтой зохицуулалт вэ?*

Боловсруулсан түлшийг нийлүүлэх ажил энэ жилийн хувьд хожуу нийлүүлж эхлэсэн. Мөн зохион байгуулалтын асуудлаар хангалтгүй байсан гэж үзэж байна. Үртсэн шахмал түлш коксжсон шахмал түлш 2-ыг хамтад нь нийлүүлэх байтал эхлээд үртсэн шахмал түлш дангаар нийлүүлж дуусаад одоо зөвхөн коксжсон түлш дангаар нийлүүлж байгаа нь хуваарилалтын хувьд зохимжгүй ба коксжсон түлшийг дангаар хэрэглэх боломжгүй юм.

Түгээлтийн хувьд түгээлтийн 2-хон цэг байгаа нь иргэдэд хүндрэл учруулж байна. Ачаалал ихтэй очер дараалал их үүсэж байна.

МАК-ийн түлш үйлдвэрлэдэг үйлдвэрээс ирж байгаа түлш тээвэрлэлтийн явцад их нунтаг болж ирдэг байсан. Одоогоор жижгээр савлах болсон нь арай дээрдэж байгаа.

6. *Нийт айл өрхийн хэдэн хувь одоогоор шахмал түлш хэрэглэж байгаа вэ? Хүмүүс голдуу ямар төрлийн боловсруулсан түлш хэрэглэдэг вэ?*

Манай хэсгийн нийт айл өрхүүд 100 хувь боловсруулсан түлш хэрэглэж үзсэн байгаа. Гэхдээ одоогоор хэрэглэж байгаа айл өрх бол ховорхон байна. зарим нь ердийн нүүрстэй хольж хэрэглэж зарим нь огт хэрэглэж чадахгүй байгаа. Яагаад гэвэл 1-рт иргэдэд таалагдаад байгаа үртсэн шахмал түлш тасарсан учраас, 2-рт коксжуулсан түлш борлохгүй байна. худалдаж авсан ч шаардлага хангахгүй асахгүй байгаа учраас иргэд ердийн нүүрсээ худалдан авахаас өөр аргагүй болоод байна.

7. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт , гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

Манай хэсэгт 3 төрлийн боловсруулсан түлш нийлүүлэгчдээс ирсэн. Аль компанийг нь мэдэхгүй байна.

Үртсэн шахмал түлш нь хэрэглэгчид сэтгэл хамажтай, дулаан ялгаруулалт маш сайн түлш юм. Коксжсон нүүрс нь нам даралтын пийшинтэй айлд түлж таарахгүй, асалт удаантай, дуу чимээ ихтэй. Байнга ойр ойрхон түлж байхгүй бол дулаан хадгалалт муутай,
8. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Түүхий нүүрстэй харьцуулахад утаа үнэр багатайгаараа шахмал түлш ялгаатай ба чанарын хувьд түүхий нүүрсийн гүцэхгүй байгаа гэж үзэж байгаа. Иргэдэд боловсруулсан түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд олон байгаа. жишээ нь түгээх цэгээс бага хэмжээгээр /нэг удаадаа 2-3 шуудайгаар/ авахад унаа машин хөлслөхөд илүү зардал нэмэгдэж байна. Мөн хүн бүл цөөтэй өвгөд хөгшид хэрэглэж чадахгүй байна. Мөн түүхий нүүрс шиг хэрэглэж хэвшээгүй учраас аргыг нь олж асааж чадахгүй байна. Коксжсон түлшний хувьд хэрэглэхэд маш хүндрэлтэй байна. Ямар хэмжээгээр хийсэн тэр хэмжээгээр хаягдал үнс ялгарах ба маш хүнд жинтэй үнс ихтэй, өргөж зөөхөд бэрхшээлтэй, дуу чимээ ихтэй, хог хаягдлын хэмжээг ихээр нэмэгдүүлж байна.

9) *Иргэд түгээлтийн системийн талаар ямар бодолтой байдаг вэ? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол нөхцөл байдлыг хэрхэн сайжруулбал зүйтэй вэ?*
Түгээлтийн 2 цэг байгаа ба ачаалал нь харилцан адилгүй байна. Замын ойр цэгт түлш маш хурдан борлодог юм. Түлш түгээх цэгт түлш ирэнгүүт хүмүүс очерлож аваад хэрүүл маргаан болоод л түлш дуусчихдаг. Гадна хүйтэн орчинд даарсан хүмүүст ч борлуулж байгаа ажилтны хувьд ч хүндрэлтэй байдаг. Ингэхгүйн тулд түлш борлуулах цэгийн тоог гудамж болгоны захад олон болгох хэрэгтэй. Мөн түлш хэзээ ч авсан байнга байдаг бол иргэд бухимдахгүй, асуудал шийдэгдэх юм. Түлш түгээх цэгээс хол айлууд нь машин унаа хөлсөлж байна. Хэдийгээр түлш хөнгөлөлттэй үнээр авсан ч тээврийн зардалд эргээд мөнгө их зарж байна.

10) *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн ианайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Одоогоор Коксжсон түлшний нөөц цэгүүдэд хангалттай байгаа. Үртсэн шахмал түлш тасраад удаж байна. түлшээр хангах асуудал маш муу байна. Бүх төрлийн түлшээрээ хангалттай хангаад өгвөл дээрх бүх асуудал намжих юм. хамгийн гол нь үйлдвэрлэгчдээс ирэх сайн чанарынх нь түлш олгосон баучерийн хэмжээндээ хүрч хангаж чадахгүй байна.

11) *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Боловсруулсан түлшнийг хөнгөлөлттэй үнээр авах баучерийг бүх айл өрхүүд авсан байгаа. нэг өрхөд 2тн коксжсон түлшийг /1тн-ийг 150000 төгрөгөөр авахыг 90000төгрөгөөр/, 1тн үртсэн шахмал түлш /120000төгрөгөөр авах байсаныг 80000 төгрөгөөр/, нийт 3тн түлш хөнгөлөлттэй үнээр худалдан авах эрх олгосон. Гэтэл ихэнхи айл өрхүүд үртсэн шахмал түлшээ түрүүлээд түлээд дуусчихсан. Зарим цөөхөн айл өрхүүд боловсруулсан түлшний бүх эрхээ эдлээд дуусчихсан байгаа ингэхээр энэ баучерээр олгогдсон хэмжээ нь тухайн өрхийн жилийн хэрэгцээг хангаж хүрэлцэхгүй байгаа юм. Тэр эрх нь дуусмагц эргээд нүүрсээ л авч түлэх хандлагатай байна.

12. *Тухайн өрхийг ваучерээр олгогдох түлшнээсээ ямар хэмжээтэйг нь худалдан авсан эсвэл огт хэрэглэхгүй байгааг хянах боломж байгаа юу? Ваучерийн ач холбогдол юу вэ?*

Баучерийн эрхийг нь хянах боломжтой. Үнийн дүн бүхий тасалбар /талон/-тай ба тасалбар бүрийн ард түгээх цэгийн ажилтаны гарын үсэг он сар өдөр, хэмжээтэйгээ байдаг болохоор иргэд ч өөрөө хянаад байх бүрэн боломжтой. Жижиглэнгээр түгээх цэг дээр өрх бүрт хөтлөсөн тэмдэглэл байгаа байх. Үүнтэй холбоотой ямар нэгэн маргаан зөрчил гардаггүй. Харин ваучер

дээр нь тэмдэглэж өгөх, мөнгөө хжраах гээд хүн бүртэй ажиллахад цаг их ордог учраас гадна даарч байгаа иргэд их бухимддаг.

13. *Түлш борлуулсан үнийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Танай хорооны айл өрхүүдэд үнийн хувьд хэр тохиромжтой байна вэ?*

Боловсруулсан түлшний үнийн хувьд иргэдэд боломжийн санал гэж үзэж байгаа. 20кг нүүрсийг 3000төгрөгөөр авдаг бол 20кг боловсруулсан түлш 1700төгрөгөөр авч байгаа учраас 50 орчим хувийн хэмнэлт үүсгэж байна гэсэн үг. Иргэд тогтоосон үнийг сайнаар хүлээж авч байгаа.

14) *Түүхий нүүрс хэрэглэж байгаа айл өрхүүд байгаа юу? Байгаа бол яагаад тэд түүхий нүүрс хэрэглэж байгаа вэ?/хязгаарлалтын бүсэд байдаг хэрнээ/ Энэ талаар хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа юу?*

Боловсруулсан түлш тасарсан учраас иргэд коксжсон түлш дангаар хэрэглэх боломжгүй учраас түүхий нүүрстэй хольж түлэх эсвэл дангаар нь түүхий нүүрс хэрэглэж байгаа. үүнийг үгүйсгэх ямар ч арга бидэнд байхгүй. Иргэдийг нүүрс түлж болохгүй гээд ямар ч нэмэргүй. Тэд даарч хөлдөхгүйн тулд яг одоо -30хэмийн хүтэнд өөр аргагүй нүүрс түлж байгаа. Хороо хэсгийн хувьд үүний эсрэг авах ямар ч гарц байхгүй. Түлшээрээ хангалттай хэмжээнд хангаагүй байж нүүрс хориглох арга байхгүй.

15. *Түүхий нүүрсний хориг нь агаарын чанарт хэрхэн нөлөөлж байна вэ? Та түүхий нүүрсний хоригийн талаар юу гэж бодож байна вэ? Энэ хоригын оронд өөр юу хийгдэж болох вэ?*

түлшээр хангаж чадахгүй байгаа учраас Түүхий нүүрсийг бүрэн хориглож чадахгүй байгаа. зөвхөн түлш гэхгүйгээр утаагүй зуухыг мөн адил өрхүүдэд нийлүүлэлт илүү үр дүнтэй байх. Зуух авах хүсэлтэй айл өрхүүд манай хэсэгт маш олон байгаа. тэд санал хүсэлт байнга гаргаж хорооноос цэвэр агаар санруу санал хүргүүлсэн байгаа хариу ирээгүй байна.

16) *Иргэд шахмал түлш үйлдвэрлэж байгаагын давуу тал нь юу вэ? Боловсруулсан түлш түлэхэд хэр их хаягдал ялгардаг вэ? Шахмал түлш илүү их үнс ялгаруулдаг уу? Гадаах болон дотоод орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдсан уу? Утаа, тоос, звгүү үнэр,тортог зэрэг боловсруулсан түлш ашигласнаар багассан уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа юу?*

Боловсруулсан түлшнээс үүсэн иргэдэд янз бүрийн нөлөөлөл үзүүлж байна.

а/ Үртсэн шахмал түлш /харандаан/ нь хэрэглэгчид 100 сэтгэл хамажтай байгаа түлш юм. Энэ түлш нь утаагүй. Хурдан асдаг, үнс гарахгүй, үнэр тортог байхгүй, цэвэрхэн, сайхан илчтэй дулаан ялгаруулалт сайтай сайн түлш гэж үздэг. Даанч нийлүүлэлт нь зогссон байгаа.Иргэд энэ түлшийг л хэрэглэх сонирхолтой.

б/ Шахмал үртсэн түлш /шар бөөрөнхий/- нь сайн шатдаг хурдан асдаг үнс утаа бага ялгаруулдаг. Гэрийн дотоод орчин хөө тортог бага ялгаруулдаг сайн түлш юм. мөн нийлүүлэлт зогссон байгаа

в/ Коксжсон нүүрс нь нам даралтын пийшинтэй айлд түлж таарахгүй, асалт удаантай, дуу чимээ ихтэй айдастай, заримдаа унтарчихдаг, хаягдал үнс ихтэй, зөөхөд хүнд жинтэй, бүхэл чулуу ихтэй учраас галаа хутгахад гэрийн дотоод орчин үнс тортог их ялгаруулдаг. Байнга ойр ойрхон түлж байхгүй бол дулаан хадгалалт муутай, ажиллагаа ихтэй.гэр орон маш их бохирдож байгаа. Иймд МАК-ийн коксжсон нүүрсийг иргэд хэрэглэх боломжгүй гэж үзэж түүхий нүүрс авч хэрэглэж байгаа. Хороо хэсгийн ахлагчдаас үртсэн түлшээ ахиу хэмжээнд нийлүүлэхийг шаардаж ядаж баучеээр олгогдсон үртсэн шахмал түлшээ авахыг шаарддаг.

16) *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц,хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Иргэдийн хүсэж байгаа чанартай түлшний нийлүүлэлтийг өсгөх л шаардлага байна хэрэв түлшээр хангаж чадахгүй бол ийм зүйл хийгээд хэрэггүй. Нам даралтын зуухтай айлд нь тохирсон түлшийг нь, цахилгаанаар халдаг төхөөрөмжийг нь, зуухыг нь бас нийлүүлэх хэрэгтэй зөвхөн түлш гэж туйлшрах хэрэггүй юм.

16. *Та ямар нэгэн арга хэмжээ авч байхыг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр харсан уу, дуулсан уу? Ухуулгын чанарыг хэрхэн дүгнэж байна вэ? Гол санаа нь юу байх хэрэгтэй вэ?*

Холбогдох газрууд Боловсруулсан түлшний талаарх олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт сурталчилгаа хийгээгүй. Түлшийг яаж асаах, яаж хэрэглэх, яаж хэрэглэвэл илүү үр дүнгээ өгөх, гарсан хаягдлыг яаж ашиглаж болох, сөрөг нөлөө юу байх талаар иргэдэд мэдээлэл өгвөл илүү үр дүнтэй байх. Зарим хүмүүс олон янзаар асааж туршиж үзээд аргыг нь олчихож байхад зарим нь нэг түлж үзээд л учраа олохгүй болохгүй байна гээд орхиж байгаа. Иймд хэрэглээ талаасаа аюулгүй байдал талаасаа мэдээлэл хүргэвэл сайн байна.

Хэсгийн ахлагч нар иргэдэд анх мэдээлэл өгсөн. Хэсгийн ахлагч нарт утааны байцаагч гэдэг нэр өгч сар бүр /нийт долоон сар/ сарын 50000төгрөгөөр урамшуулж байгаа. Биднээс хамааралгүй цаанаасаа зохион байгуулалт хийж байгаа учраас одоогоор бид энэ талаар хийсэн зүйлгүй байна.

17. *Таны бодлоор ухуулга сурталчилгааны хамгийн сайн арга юу вэ?*

ТВ-ийн суваг ашиглаж дээрх чиглэлийн мэдээлэл хүргэвэл сайн байна. Манай захын хэсгийн зарим айл өрхүүдэд зарим суваг гардаггүй юм. Иймд үндэсний ТВ, ТВ5, ТВ9 сувгуудаар нэвтрүүлэг хийх хэрэгтэй. Зуухны талаар их гардаг юм.

Гэр хорооллын оршин суугчид

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага №. 1

Огноо: 2011 оны 12-р сарын 21

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 10-р хороо, 8-р хэсэг..... 102 тоот.....

Нэр, Овог нэр: Өлзийсайхан ЖүрмэдНас: 53 Хүйс: Эмэгтэй

Боловсрол: ДээдАжил эрхлэлтийн байдал: тэтгэвэрт гарсан.....

Өрхийн гишүүдийн тоо: 6... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 2

Өрхийн сарын орлого: 340,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. Нэг хүүхдийнх нь цалин

Өрхийн сарын зарлага: 280,000 – 290,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 50,000 – 60,000

1. *Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ? Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нээ удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?*

Эхэндээ түлж байсан өдөр бүр авах гэж хэцүү, тэгээд пийшинтэй болохоор манай гэрийг бодвол том байшинг халаахгүйн байна лээ. МАК-н болон үртсэг түлш хэрэглэж байсан. Нэг шуудай түлш 2 хонодог байсан, өдөрт 3 удаа түлдэг. Одоо олдохгүй түүхий нүүрс түлдэг. Хойно нэг айл үртсэн түлш 4 000 төг-р зараад байсан тэндээс хэд авсан. Яг адилхан.

2. *Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?*

Наран дэлгүүр (10-1) цэгээс авдаг байсан. Энэ манайхаас хол ойролцоогоор 800-1000м орчим учираас зөөхөд хүндрэлтэй. 2 цэг байх нь хангалтгүй байгаа гэж бодож байна. Нөгөө цэг нь хаана байдгийг мэдэхгүй байгаа. Түлш байнгын тасардаг учраас очиж авахад бэрхшээлтэй учираас түүхий нүүрсээ түлж байна.

3. *Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?*

Борлуулалтын цэгээс гэр хүртлээ тэргээр зөөдөг. Эсвэл хөлсний машин авдаг байсан. Савалгааны хувьд боломжийн санагдсан. Түлш авахаар голдуу би өөрөө тэтгэвэрт байдаг болохоор явдаг байсан.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

3200төг гэдэг нь хямд санагдаагүй, их хэцүү үнэтэй санагдаж байсан. Үйлдвэрээсээ хямд гардаг гэж бодож байна. 3200төг хагас коксон түлш авдаг 30кг-н. 4000төг 30-40кг байсан шиг санагдаж байна.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

2-3тоннжилийн хэрэгцээнд хүрэлцэнэ гэж бодож байна. Боломжийн санагдсан. Ваучер хуваарилалтанд асуудал гараагүй байх. Нийт ваучерийн ихэнх хувь нь байгаа.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Үнс бага гардаг утаа тортог бага гаргадаг давуу тал бол сайхан юм байна лээ. Үнсний хог ерөөсөө асуудал байхгүй цэвэрхэн санагдсан. Илч дулаан сайтай. Гэхдээ тэндээс олдохгүй, зай нь хол болохоор даарч байжаахаар гээд түүхий нүүрсээ түлж байна.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Агаарын бохирдол мэдэгдэж байсан одоо айл бүр түүхий нүүрсээ түлээд нэмэр байхгүй байна.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Энэ түлшийг хэрэглэх ганц хүндрэлтэй тал нь маш их тасардаг нийлүүлэлт муутай. Худалдаж авахад зай нь хол хэцүү байдаг. Хангалтаа сайжруулаачээ гэж л хэлмээр байна. Түүхий нүүрс авахаасаа өмнө их хэмжээгээр авахыг хүссэн ч хаана зарж байгааг мэдэж чадаагүй. Тэгээд түлш борлуулах цэгийг ойртуулмаар байна. Цахилгаанаараа халаадаг болвол утаатай тэмцэж чадах байх, тогний мөнгө хэт их гарж байна.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Одоо ч хэрэглэж байгаа.

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Энэ хавийн бүх айл түлж байна. Манайх тэр түлш олдохгүй байхад даарч байхаар түлэлгүй болохгүй.

11. *Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?*

Энэ түлшний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ганц нэг удаа харсан. Мэдээлэл түгээхдээ цахилгааныг хөнгөлөх, энэ хавийнхан мэдээлэл сайтай байгаа боловч хангалт байхгүй.

12. *Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Мэдэхгүй байна. Ихэнх иргэд мэдэж байгаа.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага №. 2

Огноо: 2011 оны 12-р сарын 22

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 23-р хороо, 7-р хэсэг..... 453 тоот.....

Нэр, Овог нэр: Д.ДашдэлгэрНас: 5-Хүйс: Эрэгтэй

Боловсрол: Дунд Ажил эрхлэлтийн байдал: ажилгүй

Өрхийн гишүүдийн тоо: 5... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 1

Өрхийн сарын орлого: 260,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад.

Өрхийн сарын зарлага: 160,000-ыг хоол, тээвэр унаа, харилцаа холбоонд(гар утас) зарцуулдаг Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 100,000

1. *Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ?Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?*

МАК-н хагас коксон түлш түлдэг. Үртсэн шахмал харандаан түлш байгаа үед нь хэрэглэдэг. Өдөрт 1-2 уутыг байнгын галлагаатай байлгадаг. нэг шуудай коксон түлш нэг хонодог. Янз бүрийн хэмжээтэйгээр худалдан авдаг, боломжтой үедээ 3 шуудай боломжгүй үедээ нэг шуудайгаар нь авдаг.

2. *Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?*

Түлш борлуулах (23-1) цэгээс авдаг байсан. Энэ манайхаас хол ойролцоогоор 50-100м орчим учираас байнгын эндээс авдаг. 2 цэг байгаа нь хангалттай гэж бодож байна. Манайх ойрхон болохоор зөөхөд харьцуулахад асуудалгүй. Нөгөө цэг нь хаана байдгийг мэдэхгүй байгаа. Үртсэн шахмал түлш байнгын тасардаг учраас очиж авахад бэрхшээлтэй. Зодоон хэрүүл уруул үртсэн шахмал түлш ирсэн дохиолдолд тасардаггүй.

3. *Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?*

Борлуулалтын цэгээс гэр хүртлээ тэргээр зөөдөг. Савалгааны хувьд боломжийн санагдсан. Түлш авахаар би өөрөө явдаг. Ойчир маш их байдаг.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

МАК-н коксон түлш – 1400төг 15кг, 1800төг 20кг, 2750төг 30кг; үртсэн шахмал түлш – 2000төг 20кг, 3200төг 40кг тус тус борлуулагддаг. Нэгэн жигд савлагаатай ирэхгүй бол их ойлгомжгүй байдаг. Жигнэж үзэх биш бид нар. Ер нь боломжийн санагдаж байгаа ч илч багатай санагддаг. Хэдэн хувь нь түлшинд зарцуулагддагийг мэдэхгүй байна.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

2-3тоннжилийн хэрэгцээнд хүрэлцэхгүй гэж бодож байна. Ваучер хуваарилалтанд асуудал мх гарж байдаг. Хорооноос тарааж өгсөн. Нийт ваучерийн ихэнх хувь нь байгаа. Мөнгө төгрөгний боломж тааруугаас худалдан авахад асуудал гараад ваучераа ашиглаж чадахгүй байна.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Үнс бага гардаг утаа тортог бага гаргадаг давуу тал бол сайхан юм байна лээ. Коксон түлш бол илч багатай. Энэ түлшнээс болж зуух нь дэлбэрсэн гэж бодож байна. Зориулалтын зуухгүй учраас утаа ялгаруулалт муу. Коксон түлшний үнэр аймар муухай толгой өвддөг. Зуухаа дэлбэлэхээс айж байна. Бага багаар хийдэг.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Агаарын бохирдол мэдэгдэж байгаа зүйл байхгүй байна. Айл бүр түүхий нүүрсээ түлээд нэмэр байхгүй байна. Болж өгвөл тэр нүүрсээ л түлмээр байна.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

МАК-н хагас коксон түлш илч муутай ихээр хийхээр дуу ихтэй болохоор хэцүү байдаг. Арга тулахдаа л энэ түлшийг хэрэглэж байна. Энэ түлшийг хэрэглэх ганц хүндрэлтэй тал нь маш их тасардаг нийлүүлэлт муутай. Хангалтаа сайжруулаачээ гэж л хэлмээр байна. Энэ хагас кокс дангаараа асаахад хэцүү байна. Цахилгаанаараа халаадаг болвол утаатай тэмцэж чадах байх, тогний мөнгө хэт их гарж байна.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Байнга энэ түлшээ хэрэглэж байна. Ойрхон түүхий нүүрс олдохгүй учраас. Уг нь түүхий нүүрсээ хэрэглэх сонирхолтой байгаа. Энэ илч их муутай.

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Энэ хавийн бүх айл түлж байна. Манайх тэр түлш олдохгүй байхад даарч байхаар түлэлгүй болохгүй.

11. *Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?*

Энэ түлшний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонсоогүй. Байнга тэр зуухны талаар сонсож байна. Энэ хавийхан мэдээлэл сайтай байгаа боловч хангалт байхгүй.

12. *Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Мэдэхгүй байна. Ихэнх иргэд мэдэж байгаа.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага № 3

Огноо: 2011 оны 12-р сарын 20

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 10-р хороо, 8-р хэсэг.....6-8...

Нэр, Овог нэр: Б.Цэцэгмаа Нас: .64 Хүйс: Эмэгтэй

Боловсрол: Бүрэн дунд Ажил эрхлэлтийн байдал: тэтгэвэртээ гарсан.....

Өрхийн гишүүдийн тоо: 3... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 1

Өрхийн сарын орлого: 480,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. 117,000 тэтгэвэр, 300,000 охиных нь цалин, хүний хөгжлийн мөнгө-63,000

Өрхийн сарын зарлага: 480,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 50,000 – 60,000 сардаа

1. *Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ? Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?*

Тэр охиныхоо гэрт өнгөрсөн намар нүүж орсон. Тэд өнгөрсөн 9-р сард нэг машин Алагтолгойн түүхий нүүрсийг худалдаж авсан ба одоо ашиглаж байна.Тэд тоосгон байшинд амьдардаг ба өдөрт 3-4 удаа түлдэг. Тэд боловсруулсан түлш хэрэглэж үзээгүй байна.

2. *Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?*

Тэр борлуулах цэг хаана байдгыг мэдэж байсан. Мөн хөршүүд нь хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлш хэрэглэдгийг мэдэж байсан. Үнэндээ нэг борлуулах цэг нь тэдний хашаатай их ойрхон оршдог байна.

3. *Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?*

Боловсруулсан түлш худалдаж авдаггүй.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

Яг тодорхой үнийг мэдэхгүй. Гэвч боловсруулсан түлшний үнэ боломжийн болохыг хөршүүдээсээ сонссон.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

Ваучерын тухай сонссон боловч аваагүй. Учир нь тэрээр өөр дүүрэгт бүртгэлтэй, тийм ч учраас ваучер авах эрхгүй юм. Охин нь ваучер авч болно гэхдээ тэх их завшэй байдаг мөн тэд ваучер олгогдож эхлэхээс өмнө түүхий нүүрс худалдаад авчихсан байсан.Тийм ч учраас ваучер авах гэж асууж сураглаагүй. .

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Хагас коксжсон нүүрс муухай үнэргүй гэдгийг бусад хүмүүсээс сонссон. Үртсэн шахмал түлш дажгүй боловч маш хурдан шатаж дуусдаг ба хангалттай дулаан ялгаруулдаггүй. Түүнчлэн боловсруулсан түлш нь байшинд жишээлбэл ханыг халаахад тохиромжтой биш. Тийм ч учраас байшинд амьдардаг ихэнх хүмүүс одоогоор боловсруулсан түлш хэрэглэхгүй байгаа.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Хүмүүс боловсруулсан түлш хэрэглэж эхэлснээс хойш ажиглагдахуйц өөрчлөлт гараагүй байна.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Боловсруулсан түлш хэрэглэдэггүй учир саад бэрхшээл байхгүй.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Түүхий нүүрс хэрэглэдэг.

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Тэрээр энэ нь зөв бодлого гэж ойлгож байгаа ба засгийн газрын түүхий нүүрсний хоригийн талаарх шийдвэрийн талаар мэдэж байсан.

11. *Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл*

мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?

Тэр тогтмол тв үздэг ба агаарын бохирдлын талаар мэдээлэл их авдаг. Эрчим хүчинд хэмнэлттэй зуухны талаар их сурталчилгаа явагдаж байсан боловч боловсруулсан түлшний талаар их жаахан байсан. Үнэндээ боловсруулсан түлшний талаар сурталчилгаа харж байгаагүй. Тв сувгууд нь Багануурын түүхий нүүрсийг сурталчилахаа болих хэрэгтэй гэж бодож байгаагаа хэлсэн.

12. Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?

Тв хөтөлбөрүүд нь гэрийн оршин суугчдад хүрэх хамгийн сайн арга юм.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага №. 4

Огноо: 2011 оны 12-р сарын 21

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 10-р хороо, 8-р хэсэг..... 12-99.....

Нэр, Овог нэр: Б.ТөгсөөНас: 49Хүйс: Эрэгтэй

Боловсрол: Бүрэн дунд Ажил эрхлэлтийн байдал: ажилгүй.....

Өрхийн гишүүдийн тоо: 4... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ?1

Өрхийн сарын орлого: 284,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. эхнэрийнх нь цалин 200,000, хүний хөгжлийн мөнгө- 84,000

Өрхийн сарын зарлага: 284,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 60,000 сардаа

1. Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ?Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?

Тэд хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлш хэрэглэдэг. Тэрээр хагас коксжсон нүүрсийг МАК компани үйлдвэрлэдгийг мэдэж байсан. Сүүлийн үед “харандаан шахмал түлш” ба үртсэн шахмал түлш борлуулах цэгүүдэд байхгүй байгаа. Тийм ч учраас тэд ихэнхдээ хагас коксжсон нүүрс ашиглаж байна. 20 кг савлагаатай хагас коксжсон нүүрсний нэг уут нь 2-3 өдөр болдог. Тэд борлуулах цэг орох бүртээ хагас коксжсон түлшнээс 5 уутба нэг уут үртсэн шахмал түлш худалдан авдаг.

2. Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?

Тэр хашаанаас нь 500 м-н зайд орших борлуулах цэгээс авдаг. Нийлүүлэлт тогтмол биш. Тийм ч учраас борлуулах цэгтэй ойролцоо оршдог айл өрхүүд нь түлш ирэнгүүт шууд авдаг. Тэдний гэр бүл ихэнхдээ түлшний хомсдолд ордог. Хэдийгээр борлуулах цэгийн байршил нь ойрхон боломж хүртээмж их хүндрэлтэй. Тэр нэг том жалгыг давж борлуулах цэгт хүрдэг ба өвлийн цагт халтиргаа гулгаа их болж түлш ачсан тэргээ түрэх хэцүү болдог байна. Тэрээр борлуулах цэгийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй гэж бодож байсан юм.

3. Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?

Түлшээ зөөхдөө тэрэг ашигладаг. Түлш худалдан авах, зөөвөрлөх зэргийг голдуу тэр гүйцэтгэдэг.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

Тэр нэг уут хагас коксжсон түлшийг 2,800төг, нэг уут “харандаан шахмал түлш”-ийг 3,700 төгрөг ба нэг уут үртсэн шахмал түлшийн 2,900 төгрөгөөр тус тус худалдаг авдаг байна. Үнийг боломжийн гэж боддог. Өрхийн орлогын 20 %-ыг түлш авахад зарцуулдаг. Түүнчлэн борлуулах цэгээс түлшээ зөөхдөө машин хөлсөлдөг. Нэг удаадаа 2,000төлдөг.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

Тэдний үртсэн шахмал түлшний ваучер нь дууссан. Хагас коксжсон нүүрсний ваучерийн хувьд одоогоор 3 үлдээд байгаа (45,000төгрөгөөр нэг сар хэрэглэх ойролцоогоор 16 уутыг) боловч удахгүй дуусна. Ваучерүүд нь нэг тонн үртсэн шахмалт түлш ба 2 тонн хагас коксжсон түлшинд зориулсан олгогдсон юм.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлш нь түүхий нүүрстэй харьцуулахад муухай үнэр ялгаруулдаггүй. Гэрийн дотор үнсний тоос, бохирдол байхгүй. Ашиглахад их амархан. Үртсэн шахмал түлш хэрэглэж эхлэснээс хойш гал түлэхдээ мод ашиглахаа больсон. Энэ нь бас сайн хүчин зүйл ба өрхийн орлогод эерэгээр нөлөөлж байгаа юм.

Гэвч хагас коксжсон шахмал түлш нь үйлдвэрлэгчдээс агуулах хүртэлх мөн эцэст нь айл өрх хүртэлх тээвэрлэлтийн олон шат дамжлагаас болоод бутарч үйрдэг байна. Тийм ч учраас хагас коксжсон нүүрсний жижиг хэсгүүд нь амархан асдаггүй байна.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Цаг агаар их хүйтэн болох хүртэл утаа өмнөх жилүүдтэй харьцуулахад маш бага ялгарсан юм. Гэвч хүйтний улирал эхэслэснээс хойш утаа өмнөхтэй адилхан хэмжээнд хүрээд байна.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Борлуулагчид түлшийг тогтмол нийлүүлж байгаа тохиолдолд боловсруулсан түлш хэрэглэхэд хүндрэлгүй юм. Үртсэн шахмал түлшний үйлдвэрлэлийн их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн одоо хүмүүс шахмал түлш хэрэглэж сураад байгаа учир засгийн газар түүхий нүүрсний хоригоо үргэлжлүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд хүргэх боловсруулсан түлшний нийлүүлэлтийг тогтмол байлгах хэрэгтэй юм.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Тэдний гэр бүл түүхий нүүрс хэрэглэдэггүй. Одоог хүртэл тэдэнд боловсруулсан түлшний хангалттай нөөц байв. Гэвч сүүлийн үед түлшний хомсдолд ороод байна.

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Энэ нь маш зөв шийдвэр гэж бодож байгаа. Гэвч агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд засгийн газар эрс шинэчлэлийн арга хэмжээ авах хэрэгтэй. Жишээлбэл цахилгааны үнэнд татаас олгох хэрэгтэй. Засгийн газрын шийдвэрийн дагуу тэд 23-р хорооны бусад 511 айл өрхтэй хамт цахилгааны хөнгөлөлтийн схемд бүртгүүлсэн. Гэвч тэдэнд компьютерийн системийн алдаанаас болоод хүсэлтээ цахилгаан дамжуулах үйлчилгээнд дамжуулах боломжгүй байгаа гэж хэлсэн байна.

11. *Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та*

юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?

Тэр олон тв сувгаас мэдээлэл хүлээн авдаг. Гэвч олон нийтийн ухуулга сурталчилгаа нь цахилгааны хөнгөлөлтөд хэрхэн хамрагдах, боловсруулсан түлшийг хэрхэн ашиглах жишээлбэл хоёр өөр төрлийн түлшийг хэрхэн нэгтгэх талаар мэдээллүүд багтах ёстой.

12. Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?

Гэр хорооллын оршин суугчдад хөдөлгөөнт мэдээллийн төв нь хамгийн үр дүнтэй арга байх юм.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага № 5

Огноо: 2011 оны 12-р сарын 21

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 10-р хороо, 8-р хэсэг..... 10-7.....

Нэр, Овог нэр: ЦэвэгмидНас: 58 Хүйс: Эмэгтэй

Боловсрол: Бүрэн дунд Ажил эрхлэлтийн байдал: тэтгэвэртээ гарсан.....

Өрхийн гишүүдийн тоо: 4... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 2

Өрхийн сарын орлого: 963,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. 2 хүүхдийнх нь цалин, өөрийнх нь хөгжлийн бэрхшээлийн тэтгэмж, хүний хөгжлийн мөнгө 63,000

Өрхийн сарын зарлага: 700,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 100,000

1. Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ? Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?

Манайх 3 төрлийн боловсруулсан түлш хэрэглэж үзсэн. Аль компани үйлдвэрлэснийг нь сайн мэдэхгүй байна. Одоогоор коксжсон түлш энгийн нүүрстэй холиод түлж байна. Коксжсон нүүр дангаар нь хэрэглэвэл өдөрт 6 удаа галлана. Завсраар нь бас мод түлдэг юм. манайх хүйтний 6 сарын хугацаанд галладаг. Боловсруулсан түлш түгээх цэгтэй ойр учир түлш ирэнгүүт нь очерлож байгаа нэг удаадаа оногдсоныг нь /хүртэхгүй үед бүх айлдаа хуваадаг/ түлшний хүртээмжээс мөн байгаа мөнгөндөө тааруулж авдаг юм.

2. Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?

Манайх түлш түгээх цэгтэй ойрхон учраас энэ талаар асуудал байхгүй. холоос ирж авч байгаа хүмүүс их хэцүү байдаг юм. зарим настай хүмүүс нь манай хүүг гуйгаад 2000 төг өгье дөхүүлээд өгөөч гэж гуйдаг гэсэн. Түлш байнга тасардаг тогтмол ирдэггүй юм. ховор учраас түлш ачсан машин ирэхэд хүмүүс машиныг нь дагаад чарга тэргээ түрээд ирдэг юм. Ирэнгүүт нь 2-3р нь аваад дээр нь гараад дараад суучихдаг юм. тэгээд л зарим нь мөнгөө тушаасан ч хүртэхгүй. Түлш түгээгч нь хүн бүрт хүргэх гээд ингээд л хэрүүл маргаан зодоон үүсдэг юм. түлш түгээх цэгийг олон байлгах хэрэгтэй бас хэзээ ч авсан түлш нь байдаг л бол асуудалгүй. Заримдаа шөнийн цагаар ч түлш ирж буудаг ч хүмүүс мөн л адил дагаж ирээд л бөөн маргаан болдог.

3. Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?

Манайх ойрхон болохоор / цэгээс 300м/ усны тэргээрээ түлшээ зөөгөөд авчихдаг харин маш их очерлож байж авдаг юм. зарим хүмүүс тэргэ чаргагүй нь хэцүү байдаг байх. Түлш ачсан машин ирэхээр би ганцаараа чадахгүй /disabled/ учраас хүүтэйгээ хамт явдаг юм.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

Үртсэн шахмал түлш /харандаан/- нэг уут 40-кг нь 3200 төг, үртсэн шахмал түлш /шахсан шар/-1 уут 2000 төг, коксжсон нь нэг уут нь 2700 төгрөгөөр тус тус худалдаж авдаг гэхдээ үнийн хувьд боломжийн боловч тухайн хэмжээндээ байгаа эсэхийг хэн ч мэдэхгүй. Анх ирэхдээ их дүүрэн ирдэг байснаа одоо ирж байгаа нь багассан юм шиг санагддаг. Хиллэж үзэхгүй шууд л авч байгаа. Нийт өрхийн орлогоосоо сард 11 орчим хувь буюу 100000 төг боловсруулсан түлшинд зарцуулсан байна.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

Манайх одоогоор ваучерээр олгогдсон эрхээ бүгдийн ашиглааж дуусаж байгаа 260000 төгрөгөөр түлш аваад 2,5 сар хэрэглэсэн. хэрэв нүүрс 180000 төгрөгөөр авсан бол өнгөрсөн саруудад түлээд одоо дуусаагүй байх ёстой. Иймд олгосон ваучер нь нэг өрхийн жилийн хэрэгцээг хангаж чадахгүй. Хагас жилд л хүрэлцээтэй юм.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Дулаан ялгаруулалт, хадгалалтын хувьд нүүрсийг гүйцэхгүй. Боловсруулсан түлш үнэргүй байдаг. гэрийн дотоод орчин цэвэрхэн байдаг гэхдээ коксжсон түлш халалт муутай ажиллагаа ихтэй, үнс их ялгардаг. Харин үртсэн түлш л бүх талаараа сайн түлш юм.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Одоогоор манай хажуу хавийн айлууд бүгд л нүүрсээ түлж байгаа. угаар үнэртэж хар утаа гарч байдаг юм. Гэрийнхээ яндангаас гарч байгаа утааг харахаар арай шингэн цэнхэр утаа гардаг юм. орчиндоо утаа багассан байдал мэдрэгдэхгүй байна. оройд бол утаатайгаа л байна.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Үртсэн шахмал түлш хэрэглэхэд маш тохиромжтой, амар хялбар байдаг юм. Үнс ялгарахгүй, утаагүй маш сайн түлш. Харин коксжсон түлш бол их хэцүү ажиллагаа ихтэй ойр ойрхон түлдэг, асалт удаан, үнс ихтэй, дулаан хадгалалт багатай, илчгүй дангаар нь түлэхэд хүндрэлтэй түлш юм. над шиг хөл гар муутай хүн үнсийг нь зөөхөд маш хүнд байна. Үйлдвэрлэгч компаниудаас үртсэн шахмал түлшийг л сайн нийлүүлэхийг хүсэж байна.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Түүхий нүүрс хэрэглэхгүй гээд хөлдөөд үхэлтэй биш хэрэглэж л таарна. Үртсэн шахмал түлшээр ханалттай сайн хангаад өгвөл нүүрс түлэхгүй байж чадна. Гэтэл авах гэхээр байхгүй болохоор ямар ч аргагүй нүүрс түлж байна. коксжсон түлшийг дангаар нь түлэх ямар ч боломжгүй учраас одоо нүүрс хийгээд түүний дараагаар коксжсон түлшээ хийж байгаа./өнгөрсөн жилийн хуримтлагдсан нүүрс байсан одоо аминд орж байна

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Олон янзын түлш гэхгүйгээр зөвхөн үртсэн /харандаан/ түлш нийлүүлээд байвал болно. Мөн утаагүй зуух гээд бусад дүүргүүдэд өгөөд байгаа зуухыг бидэнд өгвөл сайн байна. гэвэл хүмүүс өөрт тохирох бүтээгдэхүүнээ сонгоод хэрэглэвэл жинхэнэ утгаараа утаа багасна.

11. *Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хорилох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?*

Боловсруулсан Түлшний талаар бидэнд хэсгийн ахлагч л баучер тараахдаа үнийн талаар, хэмжээний, нийлүүлэлт түгээх цэгийн талаар мэдээлэл өгсөн. Манайх Хязгаарлалтын бүсэд орж байгаагаа анх зурагтаар л харсан. Зурагтаар гарч байгаа утаагүй өлзий зуух яаж ашиглах талаар зааж байгаа шиг бидэнд түлш яаж ашиглавал болох, ямар зууханд нь илүү таарах, таарахгүй талаар хэн ч юу ч хэлж зааварчилгаа, зөвлөгөө өгөөгүй. Зарим нь асааж түлж чадахгүй байгаа тэр хүмүүст зааж өгөх хэрэгтэй. Сургалт зөвлөгөө анхааруулах зүйл зайлшгүй хэлж өгөх хэрэгтэй. Коксжсон нүүрс их дуу чимээтэй та няс хийж дугардаг. Тэр ямар учиртай талаар түүнээс ядаж айхгүй байж болох талаар, аюул учруулах эсэхийг хэлж өгөх хэрэгтэй шүүдээ.

12. *Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Хороо хориноос түлшний асуудалд хомсдол, хуваарилалтад юу ч хийхгүй байж, түлшний асуудалд оролцоо байхгүй, зохицуулалт байхгүй юм асуухаар нэг мэдэх юм байхгүй байж хэсгийн ахлагч нар цалин авдаг гэсэн. энэ бол буруу. ТВ-ийн мэдээлэл ашиглаж тэр зуух сурталчилж байгаа шиг хүмүүст ойлгуулж өгөх хэрэгтэй. Мөн түлшний хангамжийг нэмэгдүүлэх талаар төр засаг юу хийж байгаа. утаа багасаж байгаа эсэхийг харуулах хэрэгтэй.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага № 6

Огноо: 2011 оны 12-р сарын 21

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 10-р хороо, 8-р хэсэг..... #12-06

Нэр, Овог нэр: Дарьхүү Нас: 65 Хүйс: Эмэгтэй

Гомбоцэрэн Нас: 35 Эрэгтэй

Боловсрол: Бүрэн дунд Ажил эрхлэлтийн байдал: тэтгэвэртээ гарсан.....

Өрхийн гишүүдийн тоо: 3... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 2

Өрхийн сарын орлого: 513,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. Хүүгийн цалин, өөрийн тэтгэвэр, хүний хөгжлийн мөнгө- 63,000

Өрхийн сарын зарлага: 300,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 50,000 сардаа

1. *Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ? Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?*

Манайх одоогоор нүүрс хэрэглэж байгаа. өмнө нь үртсэн шахмал түлш 2-3 уутыг авч ашиглаж үзсэн болмоор санагдсан. Дахиад авах гэсэл дуусчихсан байсан. Одоо борлуулж байгаа коксжсон түлшнээс 10 уутыг авч хэрэглэж үзсэн боловч бүтэхгүй юм байна лээ.

2. *Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?*

Түлш түгээх цэгийг мэднэ. Гэртээ машинаараа зөөж авчирсан. Хамгийн гол нь түлэх түлш нь чанар шаардлага хангахгүй, гайгүй гэсэн нь үйлдвэрлэгчээс ирэхгүй байхад яаж худалдаж авах юм бэ?

3. *Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?*

Борлуулалтын цэгийн хувьд асуудалгүй. Түлшиндээ асуудал байгаа учраас борлуулалтын цэгрүү олон удаа яваагүй.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

Боловсруулсан түлшний үнийн хувьд боломжийн санагдсан. Гэр хорооллын айлууд авч чадахаар байсан. Өрхийн амьжиргаанд ямар нэгэн дарамт учруулахгүй үнэтэй байсан.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

Олгосон баучерийн эрхээсээ 13 уут буюу 500 кг орчмыг л худалдан авсан хэдий ч хэрэглэхгүй тогтмол хэрэглэж чадахгүй байгаа учраас жилийн хэрэгцээг хангах эсэхийг мэдэхгүйб йана.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Боловсруулсан түлшний хувьд ялангуяа коксжсон түлш дээр давуу тал хэлж чадахгүй байна. коксжсон түлш Дулаан ялгаруулалт, хадгалалтын хувьд нүүрсийг гүйцэхгүй муу, дуу чимээ ихтэй, ажиллагаа ихтэй, үнс их ялгардаг.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Одоогоор гадна гараад харахад утаа өмнөх жилүүдийнхтэй адилхан л утаатай байна. утаа багассан байдал мэдрэгдэхгүй байна.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Үртсэн шахмал түлшний хувьд хэрэглэхэд хүндрэлгүй боловч борлуулахгүй тасраад байгаа коксжсон нүүрсний хувьд үнс чулуу ихтэй, хүүгээ байхгүй үед түлж чаддаггүй, тортог хөө ихтэй, байшинтай тул том талбай халааж чадахгүй, асахдаа дуу чимээ ихтэй гэсэн хүндрэлүүд байна. нүүрснээс илүү сайн түлш үйлдвэрлэж байж хүмүүс нүүрстэй адилхан хэрэглэх болно гэдгийг үйлдвэрлэгч нар ойлгох хэргтэй. Нүүрснээс муу л бол хэрэглэхгүй. Коксжсон нүүрсэнд хамгийн чулуутай муу нүүрсийг ашигладаг байх.

Мөн Хязгаарлалтын бүс тогтоож, утааны байцаагч томилсон гэх боловч газар дээрээ биелэлээ олохгүй зохион байгуулалт маш муутай байна. Юу ч хийдэггүй хэсгийн ахлагч нарт цалин өгч байгаа бол юу хийлгэх гэж байгаа тэр ажилаа хийлгэх хэрэгтэй. Эсвэл тэр мөнгөөрөө 10-20 айлыг ч гэсэн утаагүй зуухтай болговол бодит байдлаар утаа багасна.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Түүхий нүүрс хэрэглэхээс өөр юу хэрэглэхэв дээ. Манайх налайхын нүүрсээ хийгээд цог дээр нь хааяа коксжсон нүүрсээ хийдэг юм.

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Түүхий нүүрсийг цаасан дээр хориглосон гэж бичсэнээс биш бодит байдал дээрээ нүүрс хориглоогүй. Түлшээр гүйцэд хангаагүй болохоор нүүрсээ хориглож чадахгүй байгаа юм. Утааг багасгая гэвэл багасгаж болохоор боломжтой бүх хувилбарыг /цахилгаан халаагуур, цахилгааны үнийн хөнгөлөлт утаагүй зуух/ хэрэгжүүлэхгүй бол утаа буурахгүй

11. Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?

Боловсруулсан түлшний талаар иргэдэд ямар нэгэн мэдээлэл хүрээгүй. Түүхий нүүрс түлж болохгүй гэж сонссон, зуух өгөхгүй түлш өгнө гэдэг мэдээлэл хорооноос авсан. өөрөөр хэрэглээний талаар мөн түлшний ач холбогдлын талаар ямар нэгэн мэдээлэл аваагүй.

12. Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?

ТВ-ийн сувгуудыг ашиглаж утааг багасгах талаар иргэдэд ойлгуулах хэрэгтэй. Түлшний талаар ярихаасаа өмнө түлшээ сайн үйлдвэрлэдэг, хэрэглэх боломжтой болгож сайжруулах хэрэгтэй.

Мэдээллээсээ илүү түлшний чанарт анхааран амьдралд нийцүүлж хийх хэрэгтэй. Үртсэн шахмал түлшийг цаашид үйлдвэрлэх нөөц монголд хэр байгааг бид мэдэхгүй, явцгүй ажил хийж цаг хугацаа алдмааргүй байна.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага №. 7

Огноо: 2011 оны 12-р сарын 22

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 23-р хороо, 7-р хэсэг..... #25-11-220

Нэр, Овог нэр: Мөнгөнзаяа Нас: 24Хүйс: Эрэгтэй

Боловсрол: Бүрэн дунд Ажил эрхлэлтийн байдал: хувийн бизнес.....

Өрхийн гишүүдийн тоо: 2... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 2

Өрхийн сарын орлого: 292,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. Хувийн бизнесийн орлого, цалин, хүний хөгжлийн мөнгө- 24,000

Өрхийн сарын зарлага: 150,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: Хэр хэмжээний түлш ашигласан зэргээ тооцоолж үзээгүй

1. Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ? Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?

Манайх боловсруулсан түлш болох 3 төрлийн түлш хэрэглэж үзсэн. Одоогоор коксжсон түлш хэрэглэж байна. 1 хоногт хагас шуудай коксжсон түлш хэрэглэдэг. 10-р сарын 01-ээс хойш хэрэглэж эхлэгсэн. Нэг удаа авахдаа 10 орчим шуудайг авдаг юм.

2. Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?

Манайх түлшээ жижиглэн түгээх цэгээс худалдан авдаг юм. Түгээх цэг манайхаас нилээд хол байдаг ба манайх уулын орой дээр учраас өгсүүр машинаар зөөхөөс өөр арга байхгүй. Түгээх цэгт түлшний хүртээмж янз бүр л байдаг юм. Тогтмол түлшээр хангадаггүй бид хүн бүрт хүртэх боломжоор нь л худалдан авдаг юм.

3. *Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?*

Би худалдан авсан түлшээ машинаараа зөөгөөд авчихдаг юм.Түлшний хэмжээ савлагаа боломжийн санагддаг.Гэхдээ сүүлийн үед харандаан түлшний савлагаа их байсан үнэнд өөрчлөлт ороогүй хэрнээ хэмжээ нь багасаад байгаа. Түлш худалдан авахаар би ээжтэйгээ явдаг юм.

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

Үртсэн шахмал түлш нэг шуудай нь 2000төг, коксжсон түлш нэг шуудай нь 1800-2000төг байх. Үнийг нь сайн мэдэхгүй байна.Ээж мөнгийг нь төлдөг юм.

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

Нэг өрхийн ваучер болох 250000төгрөгийн худалдан авах эрхээс 80000төгрөгний эрхээр нь худалдан авалт хийсэн байгаа.3тн боловсруулсан түлшний эрх нь нэг өрхийн жилийн хэрэгцээг хангаж чадахгүй гэж үзэж байна.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Боловсруулсан үртсэн шахмал түлш хэрэглэснээр утаа багатай, үнс багатай. Коксжсон түлш нь 5-6 цагийн турш маш сайн халдаг. Гэхдээ дулаанаа удаан хадгаладаггүй юм.Үртсэн түлш дээрээ коксжсон түлшээ хийвэл зохимжтой байдаг юм. Түлшний бусад давуу сул талыг ээж сайн мэдэх байх.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Гадна орчны утаа багассан болох нь сайн мэдэгдэхгүй байна. Мэдэгдэхүйц ямар нэгэн өөрчлөлт гараагүй.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Боловсруулсан түлштэй холбоотойгоор ямар нэгэн хүндрэл бэрхшээл байхгүй. Олдоц л сайн байвал хэрэглээд байж болох юм.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Манайх түлш тасарсан тохиолдолд заримдаа нүүрс хэрэглэдэг юм. өөр ямар нэгэн арга байхгүй юм.

10. *Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?*

Боловсруулсан түлш борлуулах цэгийн тоог олон болгох хэрэгтэй байна.ядаж хорооны хэсэг болгон дээр 1-ийг ажиллуулах хэрэгтэй. Үйлдвэрлэгч нарын хувьд ахиухан хэмжээтэйгээр нийлүүлэх хэрэгтэй байна. манайх Японы хөрөнгө оруулалттай байгууллагаас зуухны дулаан баригч, мөн монгол гэрийн хөшигөн халаагуур мөн хэрэглэж байгаа. Энэ мэт бүх айлуудад янз бүрийн байдлаар утааг багасгаж болох бүх боломжийг олгох хэрэгтэй. Манайх утаагүй зуух борлуулвал авна гэж бодож байгаа. боловсруулсан түлшгүй үедээ нүүрсээ түлэхдээ хэрэглэнэ.

11. Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?

Иргэдэд боловсруулсан түлшний талаар ямар нэгэн зааварчилгаа өгөөгүй. Хүмүүс өөрсдөө л нэгнээсээ асууж сураглаж яаж түлвэл болох талаар сонсож хэрэглэж байгаа. Гэхдээ үртсэн махмал түлшийг ямарч зааварчилгаагүй хэрэглэж чадна. МАК-ийн коксжсон түлшийг харин хэрхэн ашиглах талаар сайн зааж өгөх хэрэгтэй.

12. Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?

Бүх иргэдэд бол ТВ-ийн суваг ашиглаж мэдээлэл хүргэх хэрэгтэй. Мөн хэсгийн ахлагч хорооны ажилчдыг Үйлдвэрлэгчдээс мэдээллээр сайн хангаж, сургаж иргэддээ мэдсэн сурсанаа цааш нь дамжуулах талаар хариуцлагатай сайн ажиллуулж байж урамшуулал олгох хэрэгтэй.

Хэрэглэгчтэй хийсэн ярилцлага № 8

Огноо: 2011 оны 12-р сарын 22

Оршин суугаа хаяг: Баянгол дүүрэг, 23-р хороо, 7-р хэсэг..... #25-75

Нэр, Овог нэр: Хоролгарав Нас: 64 Хүйс: Эмэгтэй

Боловсрол: Бүрэн дунд Ажил эрхлэлтийн байдал: тэтгэвэртээ гарсан.....

Өрхийн гишүүдийн тоо: 6... Өрхийн гишүүдээс хэд нь ажил эрхэлдэг вэ? 1

Өрхийн сарын орлого: 511,000 Тодруулах: цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого ба бусад. Хүүгийнхи нь цалин, өөрийнх нь цалин, хүний хөгжлийн мөнгө-24,000

Өрхийн сарын зарлага: 250,000

Түлшинд хэдэн төгрөг зарцуулдаг вэ: 21,000

1. Танайх ямар ямар төрлийн түлш, аль компаний нийлүүлсэн түлшийг нь авч хэрэглэдэг вэ? Өдөрт хэр хэмжээтэйг хэдэн удаа хэрэглэдэг вэ? Өдөрт хэдэн удаа галладаг вэ? Хэдэн сарын турш хэрэглэдэг вэ? Жижиглэнгийн худалдаанаас боловсруулсан түлш нэг удаад хэдий хэмжээтэйгээр худалдан авдаг вэ? Нэг удаа авсан түлшийг хэдэн хоног хэрэглэдэг вэ?

Манайх боловсруулсан түлш болох 3 төрлийн /шахмал /харандаан/, шахмал үртсэн /шар өнгөтэй голдоо нүхтэй/, коксжсон түлш тус тус хэрэглэж байна. манайх 40кг-ийн ууттай коксжсон түлшийг 3-4 хоног түлдэг. 10-р сарын 01-ээс хойш хэрэглэж эхлэгсэн. Нэг удаа худалдаж авахдаа байгаа мөнгө болон даах хэмжээндээ тохируулж авдаг юм. Гэхдээ түлш хүртээмжгүй үед түгээх цэгээс айл бүрт хүртээхийн тулд хуваарилдаг юм. тэр үед нь оногдсоныг нь авдаг.

2. Боловсруулсан түлшийг хаанаас худалдан авдаг вэ? Хороо бүрт хоёр цэг дээр худалдаж байгаа гэж сонссон. Энэ хангалттай байна уу? Цэгүүдийн байршлыг мэдэж байгаа юу? Танай гэрээс хэр зэрэг хол вэ? Борлуулалтын цэг дээр түлш байнга байдаг уу? Агуулахаас тээвэрлэгч компани түлшийг тогтмол хүргэж ирж чадаж байна уу? Түлш тасрах тохиолдол гардаг уу?

Түлш түгээх цэг нь манайхаас зайтай холхон байгаа тэндээс л үргэлж худалдаж авдаг. Болдог бол түгээх цэгүүд нь ойр ойрхон олон байвал зүгээр юм. Түлш бүгээх цэгт коксжсон нүүрс нь сүүлээс ирж тасрахгүй байгаад байгаа үртсэн шахмал түлш нь тасраад удаж байгаа.

3. Борлуулалтын цэгээс гэр хүртлээ түлшээ яаж зөөвөрлөдөг вэ? Түлшний савалгаа хэмжээ боломжийн байна уу? Борлуулалтын цэг хэдээс хэдэн цагийн хооронд ажилладаг вэ? Түлш авахаар танай гэрээс хэн голдуу явдаг вэ?

Би түлшээ чаргаар эсвэл тэргээр зөөдөг юм. өгсүүр газар учраас хүндрэлтэй хэцүү л байдаг юм. Гэхдээ хэцүү гээд яахав дээ. Хүүхдүүдээ дагуулаад хамжаад дөхүүлээд авдаг юм. заримдаа замаар явж байгаа хүмүүс туслаж дөхүүлээд өгдөг юм. Түлшний савлагааны хувьд хэлэх зүйл алга боломжийн байна. Гэхдээ сүүлийн үед шуудайндаа дундарсан мэдрэгдэж байгаа. хиллэж үзэж байгаа биш хэн мэдэх вэ?

4. *Боловсруулсан түлш борлуулах цэгүүдэд ямар үнэтэйгээр зардаг вэ? Энэ борлуулах үнэ нь танай өрхийн хувьд хэр боломжийн үнэ вэ? Түлшинд өрхийн орлогын ойролцоогоор хэдэн хувь нь зарцуулагддаг вэ?*

Коксжсон түлш 25кг-1400төг, 25кг-2800төг, харандаан шахмал түлш 40кг нь -3200төг, үртсэн шахмал түлш 25кг нь 2000 төгрөгөөр тус тус худалдан авдаг юм. Түлшний үнийн хувьд манайд боломжтой сайн хөнгөлөлт үзүүлж байна. сарын орлогынхоо 20 гаруй хувийг түлшиндээ зарчуулдаг

5. *Хязгаарлалтын бүсийн айл өрхүүдэд ваучер олгосон байгаа. Олгосон ваучераар нэг өрх 2,5-3тн боловсруулсан түлш худалдан авч байгаа. Энэ нь танай өрхийн хувьд жилийн түлшний хэрэгцээг хангаж чадах уу? Энэ хэр тохиромжтой хуваарилалт вэ? Ваучер хуваарилалтаас үүсч буй асуудал байна уу? Өнөөгийн байдлаар нийт эрхийнхээ хэдэн хувийг ашигласан бэ?*

Манайх олгосон худалдан авалт хийх эрхээ /ваучер/ бараг л ашиглаад дуусах гэж байна. Дахиад ийм эрх олдох болов уу гэж асууж сураглаад байж байна. дахин нэг ийм хэмжээний эрх авчихвал өвлийг дуустал түлштэйгээ дулаан байж чадна. Одоо айл бүрт олгогдо энэ хэмжээ нь нэг өрхийн жилийн түлшний хэрэгцээг арай л хангахгүй байна. хуваарилалт нь бага байна. Нийт 6 сар түлш хэрэглэхээс 3 сарыг нь л хангаж байна.

6. *Боловсруулсан түлшний давуу талууд юу байна? Түүхий нүүрстэй харьцуулахад хог хаягдал, гэрийн дотоод агааржилт, тоосонцор, тортог, үнсний хэмжээ, үнэр, дулаан ялгаруулалт ямар байна вэ?*

Боловсруулсан коксжсон түлш нь нүүрснээс илүү чанартай байна. Гэрийн дотрох утаа тортог нь гайгүй, Яман нэгэн сул тал байхгүй. үртсэн түлшний хувьд бол маш сайн түлш ямар нэгэн сөрөг нөлөөгүй.

7. *Танай ойр орчмынхон бүгд боловсруулсан түлш хэрэглэснээр гадна орчны агаарын бохирдолд нөлөө гарч байна уу? Танд өөрт ямарваа нэг өөрчлөлт мэдрэгдэж байна уу?*

Гадна яндангаас нүүрсний утаанаас цайвар өнгийн утаа гардаг юм. гэхдээ хаь ойрдоо утаа багассан эрс мэдрэгдэх зүйл алга. Бүх айлууд боловсруулсан түлшийг бүрэн хэрэглэж чадахгүй байна. зарим нь хэрэглэх аргаа сайн олохгүй байна. би бол нэг ширхэг модыг маш нарийхан болгож байгаад галаа асаагаад дээрээс нь коксжсон түлшээ түлчихэж чаддаг бол хүн бүр тэгж чадахгүй асахгүй байна гэх жишээтэй.

8. *Боловсруулсан түлш үйлдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Үйлдвэрлэгч болон тээвэрлэгч компаниудад тавих санал хүсэлт байна уу? Хүндрэлтэй асуудлыг шийдэх өөр ямар арга зам байна вэ?*

Чанартай түлш хүртээмжтэй ирээд байвал хэрэглэхэд бэлэн байна. Үйлдвэрлэгчдэд хандаж хэлэхэд сүүлийн үед чанар , хэмжээ жоохон муудаж байна. заримдаа ачилт буулгахдаа тэгдэг байх нунтаграад заримдаа хэмжээ нь багасаад байгаа юм шиг мэдрэгдэж байна. Сул тал нь Коксжсон нүүрс асатлаа жоохон дуугарч, буудаж оч үсэрдэг юм. Галын аюул гарах магадлал өндөртэй байдаг. би оч үсрэхээс нь хамгаалж зуухныхаа амыг хавтгай төмрөөр хаадаг юм.

9. *Борлуулалтын цэгүүдэд түлшний хомсдол гарсан тохиолдолд танайх түүхий нүүрс хэрэглэдэг үү?*

Хэрэв одоо дуусаж байгаа олгогдсон эрх дуусаад дахин олгогдохгүй бол түүхий нүүрсээ авч түлэхээс өөр аргагүй болно. Боловсруулсан түлш нь модонд маш их хэмнэлттэй байдаг юм. би боловсруулсан түлш хэрэглэснээр нэг ширхэг /1 тайрдасыг олон хуваасны нэг хэсэг/ модоор 2 хоног галладаг юм.

10. Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаар та юу гэж бодож байна вэ? Түүхий нүүрсийг хориглохоос гадна өөр ямар арга замаар агаарын бохирдлыг бууруулж болох вэ?

Боловсруулсан түлш хэрэглэх түүхий нүүрсийг хориглосон шийдвэрийг манайх маш сайнаар хүлээж авч дэмжсэн. Гэтэл зарим нь түүхий нүүрсээ буулгачихаад л хэрэглэж л байгаа тэдэнд тооцох хариуцлага гэж зүйл байхгүй болохоор үр дүнгүй байх шиг байна. Болдог бол түлшээ дуусахаар дахин дахин баучер олгодог бол сайн байна. мөн түлш нь хүртээмжтэй тасралтгүй ирдэг бол өөр зүйл хэрэггүй.

11. Агаарын бохирдлыг бууруулах түүний дотор түүхий нүүрсийг хориглох, боловсруулсан түлшний ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгааг та хэвлэл мэдээллийн хэрэгслээр авдаг уу? Эдгээр ухуулга сурталчилгааны ажлын чанарын талаар та юу гэж бодож байна вэ? Гэр хорооллын оршин суугчдад ямар мэдээлэл мессеж хүргэвэл хамгийн үр дүнтэй вэ?

Иргэдэд боловсруулсан түлшний талаар ямар нэгэн зааварчилгаа өгөөгүй. Түлж чадахгүй байх шиг байна. ер нь энэ тал дээр хэлэхэд манайд Японы хөрөнгө оруулалттай байгууллагаас тусламж болгон дулаан баригч гэж зуухны яндангийн доор байрлуулдаг зүйл өгсөн юм. Хэрэглэхэд сайхан боловч ойрноос утаа гараад хэрэглэхгүй байгаа бодоход хөөдчихсэн юм шиг байна. түүнийг яаж хөөлөлхийг мэдэхгүй байна. Иймд ийм сайнхан бүтээгдэхүүнүүд нийлүүлж байж яаж хэрэглэх хэрэглээний талаар хүмүүст сайн зааж мэдээлэл өгөх хэрэгтэй

12. Хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?

Зарим хүмүүсийн их үзэж уншдаг ТВ-ийн сувгууд болон сонин сэтгүүлд нийтлэх эсвэл жижигхэн хуудсан дээр гаргаад /брошур/ хэвлээд тараагаад өгчихвэл хүмүүс уншиж харах байх.

Жижиглэнгээр борлуулагчид

Жижиглэнгээр борлуулагчидтай хийсэн ярилцлага № 1

Огноо: 2011 оны 12-р сарын 20

Дүүрэг: Баянгол Хороо: 22-1..... Хэсэг: 18-88 гудамж

Овог нэр/Нэр: Ц.Отгонбаатар..... Албан тушаал: Борлуулагч..... Нас: 31..... Хүйс: Эмэгтэй..... Боловсрол: бүрэн дунд.....

1. Танай жижиглэнгээр шахмал түлш борлуулах цэг нь хэдэн төрлийн ямар ямар үнэтэй аль үйлдвэрийн түлш борлуулдаг вэ? Ямар процес шат дамжлагаар иргэдэд түлш борлуулдаг вэ?

Манай жижиглэнгээр түлш борлуулах цэг нь МАК-н хагас коксон түлш, Түнхэлийн үртсэн түлшийг борлуулдаг. МАК-н түлш шууд наашаа хот уруу ирээд тээвэрлэгч компани энд авчирдаг. Түнхэлийн үртсэн түлшийг сайн мэдэхгүй боловч хэд хэдэн шат дамжлаг дамждаг гэж сонссон энд бол түлш зөөвөрлөгч тээврийн компани авчирч өгдөг.

2. Түлшний хэрэгцээ ямар байна вэ? Өдөрт дунджаар хэр хэмжээний түлш борлуулагддаг вэ?

Коксон түлш нь бараг борлуулагддаггүй ба үртсэн түлш тасарч ирдэг 7-30 хоног хүртэл тасардаг. Үртсэн түлш ирсэн өдрөө л бүгд зарагддаг. Коксон түлш нь үртсээрээ ноцож асдаг тул үртсэн түлш байвал коксон түлш зарагдсаар байдаг. Үртсэн түлшний хэрэгцээ маш их байдаг. МАК-ийн хагас коксон түлш нь ноцохдоо муу заавал үртсэн түлшээрээ ноцдог учраас үртсэн түлш маш хурдан дуусдаг. Гэвч үртсэн түлш нь маш их тасарч ирдэг. Өдөрт янз бүрээр борлуулагддаг үртсэн түлш ирсэн даруйдаа л дуусдаг бол үүнийгээ дагаад коксон түлш ч бас эрэлт сайтай болдог. Үртсэн түлш нь ирэхгүй тохиолдолд хагас коксон түлш ойролцоогоор 500кг борлуулдаг.

3. *Хамгийн их борлуулалт сайтай болон хамгийн борлуулалт багатай түлш нь ямар түлш вэ? Ийм түлш байгаа бол ямар учраас ийм ялгаатай байдаг вэ? /Үнэ эсвэл чанар/*

Үртсэн шахмал түлш борлуулалт сайтай. Энэ тухайн түлшний чанараас шууд хамааралтай. Түлш маш сайн асдаг илч дулаан ихтэй бөгөөд хог бага гаргадаг.

4. *Иргэдийн худалдан авах чадвар ямар байна вэ? Шахмал түлшнийг иргэд үнийн хувьд яаж хүлээж авдаг вэ?*

Иргэдийн хувьд худалдан авах чадвар боломжийн бөгөөд үнийн хувьд асуудал байхгүй байгаа гэж бодож байна. Харин нийлүүлэлт маш муу.

5. *Мөн хэрэглэгчид ямар савалгаатайг нь илүү ихээр худалдан авдаг вэ? Яагаад үүнийг сонгодог вэ?*

Савалгааг мөн адил харгалздаггүй. 20кг коксон түлш болон 30-40 үртсэн түлш байдаг.

6. *Иргэд нэг удаадаа хэдэн кг түлш худалдан авдаг вэ?*

Худалдан авалт янз бүр байдагдаа, зарим нь тонноор нь авдаг бол бусад айл нь өдрийн хэрэгцээтэйг авдаг.

7. *Боловсруулсан түлш хэрэглэхийн давуу талууд юу вэ? Боловсруулсан түлш хэрэглэхэд хэр их хаягдал гардаг вэ? Гадаах болон дотоод орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдаж байна уу? Боловсруулсан түлш хэрэглэхэд утаа, эвгүй үнэр, тортог зэрэг бага байна уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа?*

Сайн талууд гэвэл өмхий үнэргүй утаа бага гардаг гэж ярьдаг. МАК-н коксон түлш нь маш их үнс гардаг. Шатаасан нүүрс тэр чигээрээ бүхлээрээ чулуун хэлбэртэйгээрээ гарж байна. Тэгээд гадаа үнсний хаягдал маш их болж байгаа. Утаа тортогны хэмжээ багасч байгаа нь ерөөсөө мэдрэгдэхгүй байгаа учир нь энэ орчмын айлууд бүгд түүхий нүүрсээ түлж байгаа. Иргэдийн хувьд энэхүү боловсруулсан түлшийг түлэх дуртай байгаа ч хангалтгүй байна.

8. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн борлуулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр оновчтой зохицуулалт вэ?*

Түүхий нүүрсийг хориглох үйл ажиллагааны хувьд ямар ч үр дүн гараагүй. Энэ орчим түүхий нүүрсийг борлуулж байна. Иргэд ч худалдан авч түлж байна. Цаанаас түлш хангалтгүй ирж байгаа болохоор иргэд өдөр бүр ийшээ ирсний оронд түүхий нүүрсээ авч түлэх нь дээр гэж үзэж байна.

9. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт, гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

Үртсэн шахмал түлшний чанар маш сайн боловч МАК-н хагас коксон түлшний илч дулаан маш муу хурдан унтардаг. Үртсэн түлш ирэхгүй бол МАК-н борлуулагддаггүй.

10. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Түлш ирэхгүй байгаатай холбоотой иргэдийн бухимдал хэл ам маш их гардаг. Коксон түлшийг түүхий нүүрснээс илч дулаан ялгаагүй гэж үздэг ч муухай үнэр утаа бага угаар байхгүй.

11. *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн ианайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Тогтмол түлшээр хангаж ажиллаж үнэхээр чаддаггүй. Үртсэн түлш сард нэг удаа ирэх ба өдөртөө л дуусдаг. Цаад үйлдвэрлэгч нь түгээж чаддаг боловч энэ нярав хуваарилаж чаддаггүйгээс их тасардаг гэж боддог. Нэг цэгт их түгээгээд манайд ирдэггүй гэж бодож байна.

12. *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Бүх өрхүүд эрхийн бичиг /ваучер/-аа тал нь авсан тал нь аваагүй гэж сонссон гэхдээ энэ талаар сайн мэдэхгүй байна. Энэ хэмжээний хувьд хүрэлцэхгүй ба 3-4 сар л хэрэглэнэ. Ваучер нь үртсэн түлшийг 1тн тооцсон байгаа. Энэ нь бараг дуусаж байгаа. Нөгөө коксон түлшний ваучер тэр чигээрээ үлдэж байна.

13. *Шахмал түлш үйлдвэрлэгчдийн талаар, мөн тээвэрлэлтийн явцын талаар, хэрэглэгчдэд нийлүүлж байгаатай холбоотойгоор таньд ямар нэгэн санал байна уу?*

Сав баглаа боодол байнгын задарч ирдэг. Ингэснээр буцаад бооно иргэд голно. Задарсан түлш килограмандаа хүрдэг үү үгүй эсэхийг мэдэхгүй байгаа.

14. *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц,хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Тээвэрлэлтийн талаар сайн мэдэхгүй.

15. *Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын бохирдлыг бууруулах ба боловсруулсан түлшний талаар олон нийтийн мэдээллийг сайжруулах материал хүлээн авдаг уу? Ухуулга сурталчилгааны үйл ажиллагаануудын чанарын талаар юу гэж бодож байна вэ? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчдад хүргэх ёстой гол санаа юу вэ?*

Хийгдээгүй байх, хэсгийн ахлагч нар сурталчилгаа хийдэггүй ба бид нар өөрсдөө хийдэг. Олон нийтийн хэрэгслээр ерөөсөө сонсоогүй. Зурагтаар цэгүүдээр хангалттай өгч байгаа гэж худлаа мэдээлэл хийж байхыг харсан. НАЧА-н алба Цэвэр агаарын сан зэрэг байгууллага утасаа авахаа больсон асуудал гарангуут ирэхээ больсон.

16. *Таны бодлоор хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Хамгийн үр дүнтэй арга зам нь хэрхэн түлэх зааварчилгааг зааж өгөх. Иргэд ерөнхийдөө сайн мэддэг боловч түгээлт муу байгаа.

Жижиглэнгээр борлуулагчидтай хийсэн ярилцлага № 2

Огноо: 2011 оны 12-р сарын 21 Дүүрэг: Баянгол Хороо: 10-2..... Хэсэг:
Овог нэр/Нэр: Б.Баасандорж.....Албан тушаал: Борлуулагч..... Нас: 51..... Хүис:
Эрэгтэй..... Боловсрол: бүрэн дунд.....

1. *Танай жижиглэнгээр шахмал түлш борлуулах цэг нь хэдэн төрлийн ямар ямар үнэтэй аль үйлдвэрийн түлш борлуулдаг вэ? Ямар процес шат дамжлагаар иргэдэд түлш борлуулдаг вэ?*

МАК-н хагас коксон түлш, Налайхын коксон түлш, харандаан үртсэн түлш, аяга шиг үртсэн түлш нийт 4 төрлийн түлш борлуулдаг. МАК-н түлш шууд наашаа хот уруу ирээд тээвэрлэгч компани энд авчирдаг гэдгийг мэдэж байна. Бусад түлшийг сайн мэдэхгүй боловч хэд хэдэн шат дамжлаг дамждаг гэж сонссон энд бол түлш зөөвөрлөгч тээврийн компани авчирч өгдөг.

2. *Түлшний хэрэгцээ ямар байна вэ? Өдөрт дунджаар хэр хэмжээний түлш борлуулагддаг вэ?*

Нүүрсний хэрэгцээ өдөрт янз бүр байдаг. 350-д айл үндсэндээ надаас худалдан авдаг. Өдөрт зарим нүүрс эхүү байгаа үедтоннавна зарим айлууд нэг уутыг авна.

3. *Хамгийн их борлуулалт сайтай болон хамгийн борлуулалт багатай түлш нь ямар түлш вэ? Ийм түлш байгаа бол ямар учраас ийм ялгаатай байдаг вэ? /Үнэ эсвэл чанар/*

Хамгийн борлуулалт сайтай нь үртсэн түлш айл бүрт 1-2 уут хуваарилагддаг. Ирсэн даруйдаа л дуусдаг. МАК-н нүүрс асуудал ихтэй байсан бууддаг, чулуу ихтэй, хог ихтэй гэдэг байсан боловч одоогоор авж эхэлж байна. Борлуулалт чанараас шалтгаалдаг. Үнийн хувьд харьцангуй хямд байгаа. Түүхий нүүрс жижиг ууттай 5-6кг нь 1500төг гэдэг.

4. *Иргэдийн худалдан авах чадвар ямар байна вэ? Шахмал түлшнийг иргэд үнийн хувьд яаж хүлээж авдаг вэ?*

Иргэдийн хувьд худалдан авах чадвар боломжийн бөгөөд дунд байгаа. Үнийн хувьд асуудал байхгүй байгаа гэж бодож байна. Харин нийлүүлэлт маш муу.

5. *Мөн хэрэглэгчид ямар савалгаатайг нь илүү ихээр худалдан авдаг вэ? Яагаад үүнийг сонгодог вэ?*

Савалгааг мөн адил харгалздаггүй. 6кг, 15кг, 20кг, 25кг, 30кг гэх мэт савалгаагаар ирдэн учраас асуудал гардаггүй.

6. *Иргэд нэг удаадаа хэдэн кг түлш худалдан авдаг вэ?*

Худалдан авалт янз бүр байдаг, ихэнх нь даах даах хэмжээгээрээ авдаг. зарим боломжтой айл түлш нь байвал тонноор нь авдаг бол бусад айл нь өдрийн хэрэгцээтэйг авдаг.

7. *Боловсруулсан түлш хэрэглэхийн давуу талууд юу вэ? Боловсруулсан түлш хэрэглэхэд хэр их хаягдал гардаг вэ? Гадаах болон дотоод орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдаж байна уу? Боловсруулсан түлш хэрэглэхэд утаа, эвгүй үнэр, тортог зэрэг бага байна уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа?*

Сайн талууд гэвэл өмхий үнэргүй унтаж амрахад таатай болсон. Түүхий нүүрс маш өмхий үнэртэй. Утаа нь бага гардаг. Хор багатай гэж ойлгодог. Коксон түлш нь үнс гардаг. Үртсэн түлшний тортог нь ихтэй байна иймээс халалт нь удааширч байгаа. Гэр доторх өмхий үнэргүй сайхан болсон. Иргэдийн хувьд энэхүү боловсруулсан түлшийг түлэх дуртай байгаа ч хангалт маш муу байна.

8. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн борлуулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр оновчтой зохицуулалт вэ?*

Түүхий нүүрсийг хориглох үйл ажиллагааны хувьд ямар ч үр дүн гараагүй. Энэ орчим түүхий нүүрсийг борлуулж байна. Иргэд ч худалдан авч түлж байна. Цаанаас түлш хангалтгүй ирж байгаа болохоор иргэд өдөр бүр ийшээ ирсний оронд түүхий нүүрсээ авч түлэх нь дээр гэж үзэж байна.

9. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт, гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

Үртсэн шахмал түлшний чанар маш сайн боловч МАК-н хагас коксон түлшний илч дулаан сайн байгаа. Энэ хагас коксон түлшийг үртсэн болгож савалгааг сайжруулах хэрэгтэй байна. Хагас коксон түлш нь бууддан тав тухгүй байна.

10. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Хагас коксон түлш бууддаг гэх асуудал их байна. Чулуу ихтэй учраас зуухнаас чулууг түүж авахад хүндрэлтэй. Түлш ирэхгүй байгаагаар холбоотой иргэдийн бүхимдал хэл ам маш их гардаг. Коксон түлшийг түүхий нүүрснээс илч дулаан түлж сурвал ялгаа байхгүй, муухай үнэр утаа бага угаар байхгүй.

11. *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн ианайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Тогтмол түлшээр хангаж ажиллаж үнэхээр чаддаггүй. Үртсэн түлш сард нэг удаа ирэх ба өдөртөө л дуусдаг. Цаад үйлдвэрлэгч нийлүүлж чаддаггүй боловч гэж боддог, үртсэн шахмал түлшний түүхий эд ховор байдаг байх гэж бодож байна.

12. *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Бүх өрхүүд эрхийн бичиг /ваучер/-аа ерөнхийдөө авсан түр оршин суугаа айлууд авсан үгүй мэдэхгүй байна. Ойр орчмын айлууд бол ихэнх нь авсан. Өрхийн хэрэгцээний энэ тоо хэмжээний хувьд хүрэлцэнэ гэж бодож байна. ваучер нь үртсэн түлшийг 1тн, коксон түлш 1тн байхад хүрнэ гэж бодож байна. Ингэхээр ойролцоогоор 1тн хэмнэнэ гэж бодож байна. Харин хэрхэн асаах зэрэг арга замд сурах хэвших хэрэгтэй байна лээ. Ваучерийн системийн үр өгөөжийн хувьд зөв гэж бодож байгаа. Ваучерийг түгээснээр тэгш хуваарилаж байгаа гэж бодож байна.

13. *Шахмал түлш үйлдвэрлэгчдийн талаар, мөн тээвэрлэлтийн явцын талаар, хэрэглэгчдэд нийлүүлж байгаагаар холбоотойгоор таньд ямар нэгэн санал байна уу?*

Сав баглаа боодол байнгын задарч ирдэг. Ингэснээр буцаад бооно иргэд голно. Задарсан түлш кг хүрдэг үү үгүй эсэхийг мэдэхгүй байгаа. Өөрөө өрөнд ордог. Сав баглаа боодлыг сайжруулах эсвэр энэ олон шат дамжлагыг багасгах хэрэгтэй байх.

14. *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц, хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Маш олон шат дамжлага дамждаг гэж сонссон. Энэ олон шат дамжлагыг багасгах хэрэгтэй байх.

15. *Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын бохирдлыг бууруулах ба боловсруулсан түлшний талаар олон нийтийн мэдээллийг сайжруулах материал хүлээн авдаг уу? Ухуулга сурталчилгааны үйл ажиллагаануудын чанарын талаар юу гэж бодож байна вэ? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчдад хүргэх ёстой гол санаа юу вэ?*

Хийгдээгүй байх, хэсгийн ахлагч нар сурталчилгаа хийдэггүй ба бид нар өөрсдөө хийдэг. Би өөрөө хэрхэн түлэх арга замыг нь очиж хийж өгч байна. Олон нийтийн хэрэгслээр нэг удаа сонссон. Олон нийтээр сурталчлах ажил бараг хийгдэдгүй иргэд маш муу мэдээлэлтэй байгаа. Хэрхэн яаж түлэхээ мэдэхгүйгээс болоод түүхий нүүрс түлдэг айл байгаа байх. Нам даралтын зууханд бас асах болон асахгүй тохиолдол байгаа. Ямар зууханд ямар түлш яаж хэрэглэхийг зааж сурталчлах шаардлагатай.

16. *Таны бодлоор хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Үр дүнтэй арга зааварчилгааг маш сайн гарын авлага, зурагт хуудас, зурагтаар түгээх шаардлагатай.

Жижиглэнгээр борлуулагчидтай хийсэн ярилцлага № 3

Огноо: 2011 оны 12-р сарын 21 Дүүрэг: Баянгол Хороо: 10-1..... Хэсэг:1
Овог нэр/Нэр: Д.Баярмаа Албан тушаал: Борлуулагч..... Нас: 40..... Хүйс: Эмэгтэй.....
Боловсрол: бүрэн дунд.....

1. *Танай жижиглэнгээр шахмал түлш борлуулах цэг нь хэдэн төрлийн ямар ямар үнэтэй аль үйлдвэрийн түлш борлуулдаг вэ? Ямар процес шат дамжлагаар иргэдэд түлш борлуулдаг вэ?*

МАК-н хагас коксон түлш, Шарын гол коксон түлш, Хялганат, Түнхэлийн гэж 2 төрлийн үртсэн түлш нийт 4 төрлийн түлш борлуулдаг. МАК-н түлш шууд наашаа хот уруу ирээд тээвэрлэгч компани энд авчирдаг гэдгийг мэдэж байна. Бусад түлшийг сайн мэдэхгүй боловч хэд хэдэн шат дамжлаг дамждаг гэж сонссон энд бол түлш зөвөөрлөгч НАЧА-с авчирч өгдөг.

2. *Түлшний хэрэгцээ ямар байна вэ? Өдөрт дунджаар хэр хэмжээний түлш борлуулааддаг вэ?*

Нүүрсний хэрэгцээ өдөрт янз бүр байдаг ба коксон түлш өдөрт 1тн, үртсэн шахмал түлш байгаа үед борлуулалт маш сайн байдаг. Ойролцоогоор 10тн орчим борлогддог. Учир нь энэ үртсэн шахмалаар коксоо ноцоодог.

3. *Хамгийн их борлуулалт сайтай болон хамгийн борлуулалт багатай түлш нь ямар түлш вэ? Ийм түлш байгаа бол ямар учраас ийм ялгаатай байдаг вэ? /Үнэ эсвэл чанар/*

Хамгийн борлуулалт сайтай нь Түнхэлийн харандаан үртсэн түлш. Ирсэн даруйдаа л дуусдаг. МАК-н нүүрс асуудал ихтэй байсан бууддаг, чулуу ихтэй, хог ихтэй, асалт удаан. Бууддагаас нь болоод гал гарах аюул ихтэй байна гэдэг. Үнийн хувьд төрөөс хөнгөлж байгаа болохоор харьцангуй хямд байгаа гэж боддог. Зарим айлууд түүхий нүүрснээс ч үнэтэй гэдэг. Тэгээд МАК-н хагас коксон түлш нь асахдаа ажиллагаа ихтэй маш хүчтэй галанд асдаг гэж ярьдаг.

4. *Иргэдийн худалдан авах чадвар ямар байна вэ? Шахмал түлшнийг иргэд үнийн хувьд яаж хүлээж авдаг вэ?*

Иргэдийн хувьд худалдан авах чадвар боломжийн бөгөөд боломжоороо авч байгаа. Үнийн хувьд асуудал байхгүй байгаа гэж бодож байна. Харин нийлүүлэлт маш муу.

5. *Мөн хэрэглэгчид ямар савалгаатайг нь илүү ихээр худалдан авдаг вэ? Яагаад үүнийг сонгодог вэ?*

Савалгааны хувьд коксон түлшийг 1800 төг-р борлуулдаг түлшийг их авдаг. Харин үртсэн түлшийг савалгаа харгалзахгүй авдаг, хааяадаа нэг ирээд шууд дуусдаг.

6. *Иргэд нэг удаадаа хэдэн кг түлш худалдан авдаг вэ?*

Худалдан авалт янз бүр байдаг, хамгийн бага авахдаа 2 уут 40кг, бусад янз бүр байна. Зарим боломжтой айл түлш нь байвал тонноор нь авдаг бол бусад айл нь өдрийн хэрэгцээтэйг авдаг.

7. *Боловсруулсан түлш хэрэглэхийн давуу талууд юу вэ? Боловсруулсан түлш хэрэглэхэд хэр их хаягдал гардаг вэ? Гадаах болон дотоод орчинд мэдээдэхүйц өөрчлөлт ажиглагдаж байна уу? Боловсруулсан түлш хэрэглэхэд утаа, эвгүй үнэр, тортог зэрэг бага байна уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа?*

Сайн талууд гэвэл өмхий үнэргүй утаа багатай. Үнэ бусад зүйлийн хувьд давуу тал байхгүй гэж бодож байна. МАК-н коксон түлш нь үнс чулуу их гардаг. Энэ доош унадаггүй учраас заавар чимхүүрээр авах шаардлагатай болдог. Гэр доторх өмхий үнэргүй сайхан болсон. Ханан пийшинд угаарын хий бага байдаг, үнсний хувьд ялгаа байхгүй. Иргэдийн хувьд энэхүү боловсруулсан түлшийг түлж сураад дуртай болж байгаа ч хангалт маш муу байна.

8. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн борлуулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр оновчтой зохицуулалт вэ?*

Маш муу байгаа. Үртсэн түлшний захиалга байнга өгдөг боловч ерөөсөө ирдэггүй. Тэр чигээрээ хүнд сурталтай болцон. Нүүрсний Түүхий нүүрсийг хориглох үйл ажиллагааны хувьд ямар ч үр дүн гараагүй. Энэ орчим түүхий нүүрсийг борлуулж байна. Иргэд ч худалдан авч түлж байна. Цаанаас түлш хангалтгүй ирж байгаа болохоор иргэд өдөр бүр ийшээ ирсний оронд түүхий нүүрсээ авч түлэх нь дээр гэж үзэж байна.

9. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт , гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

Үртсэн шахмал түлшний чанар маш сайн боловч МАК-н хагас коксон түлшний илч дулаан сайжирсан. МАК-н түлш сүүлийн үед нойтон байгаа, хүмүүс хатааж түлдэг болсон. Шарын голын хагас коксон түлшийг хүмүүс болж байна гэж байсан сүүлийн үед ерөөсөө ирээгүй.

10. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Давуу тал нь утаа үнэхээр бага байдаг. Сүүлийн харьцангуй гомдол багасч байгаа ч цаанаас зохицуулалт үнэхээр муу байдаг. Чулуу ихтэй учраас зуухнаас чулууг түүж авахад хүндрэлтэй. Түлш ирэхгүй байгаатай холбоотой иргэдийн бухимдал хэл ам маш их гардаг. Коксон түлшийг түүхий нүүрснээс илч дулаан түлж сурвал ялгаа байхгүй, муухай үнэр утаа бага угаар байхгүй.

11) *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн ианайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Тогтмол түлшээр хангаж ажиллаж үнэхээр чаддаггүй. Нэгийг нь өгөөд нөгөөг нь өгөхгүй байгаагаас зодолдох, хоорондоо муудалцах явдал маш их гардаг. Үртсэн түлш сард нэг удаа ирэх ба өдөртөө л дуусдаг. Үртсэн шахмал долоон хоногтоо нэг удаа ирж байна, ирэхдээ 5тоннгэх мэтээх ирж байна. Бүх шатны компаниар ярьсан, НАЧА-тай ярихад нөөцөлж байна гэж байсан. Нөөцлөх нь маш буруу үр нөлөө үзүүлж байгаа. Тэд үйлдвэрлэгч компаниудтай ярилцсан боловч зохимтой хариулт авч чадаагүй юм. Тэд НАЧА-тай ярихад түлшийг яаралтай үед хэрэглэх зорилгоор нөөцөлж байгаа гэж хэлсэн юм. Тэрээр хүмүүст имй өндөр эрэлт үүсээд бахад Агаарын чанарын алба яагаад түлш нөөцлөх шаардлагатай ойлгохгүй байгаагаа хэлсэн юм. Хэрэ хүмүүс агуулахад түлш нөөцлөгдсөн гэдгийг сонсвол иргэдийн төрд итгэх итгэл алдагдахад нөлөөлж болзошгүй.

12) *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Бүх өрхүүд эрхийн бичиг /ваучер/-аа аваагүй болов уу? 50 хувь орчим нь авч байгаа байх манай хорооны хувьд 2000 өрх бүртгэлтэйгээс манайрхаас 600-700 орчим нь авдан нөгөө борлуулах цэгээс 300 гаран гэж сонссон. Тийм ч учраас айл өрхүүдийн бараг хагас нь ваучерээ аваагүй эсвэл боловсруулсан түлш худалдаж авахгүй байна. Тэрээр гэр хорооллын оршин суугчид/хэрэглэгчдээсээ 2.5-3 тонн нэг жилийн хэрэгцээг хангахад хангалтгүй хэмжээ гэдгийг дуулсан байна. Ваучерийн системийн үр өгөөж нь сайн боловч урт хугацаа шаардлагатай байна. Боловсруулсан түлш борлуулах цэгт ирэхэд хүмүүс авах гэж урт очер дараалал үүсгэдэг ба борлуулагчид ваучерийг шалгаж, тэмдэглэх шаардлагатай болдог байна. Үүнд их хугацаа ордог ба ялангуяа хүйтний улиралд борлуулагчид ваучерийг шалгарад их бухимддаг байна.

13. *Шахмал түлш үйлдвэрлэгчдийн талаар, мөн тээвэрлэлтийн явцын талаар, хэрэглэгчдэд нийлүүлж байгаатай холбоотойгоор таньд ямар нэгэн санал байна уу?*

Сав баглаа боодол байнгын задарч ирдэг. Ингэснээр буцаад бооно иргэд голно. Задарсан түлш кг хүрдэг үү үгүй эсэхийг мэдэхгүй байгаа. Өөрөө өрөнд ордог. Сав баглаа боодлыг сайжруулах эсвэл энэ олон шат дамжлагыг багасгах хэрэгтэй байх. Мөн иргэдэд хүргэх арга замыг боловсронгуй болгож өгөхийг их хүсэж байгаа.

14) *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц,хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Маш олон шат дамжлага дамждаг гэж сонссон. Энэ сайн мэдэхгүй.

15) *Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын бохирдлыг бууруулах ба боловсруулсан түлшний талаар олон нийтийн мэдээллийг сайжруулах материал хүлээн авдаг уу? Ухуулга сурталчилгааны үйл ажиллагаануудын чанарын талаар юу гэж бодож байна вэ? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчдад хүргэх ёстой гол санаа юу вэ?*

МАК-н гарын авлага нэг удаа өгсөн. Хийгдээгүй байх, хэсгийн ахлагч нар сурталчилгаа хийдэггүй ба бид нар өөрсдөө хийдэг. Би өөрөө хэрхэн түлэх арга замыг нь очиж хийж өгч байна. Олон нийтийн хэрэгслээр хэд хэдэн удаа сонссон. Олон нийтээр сурталчлах ажил бараг хийгдэдгүй иргэд маш муу мэдээлэлтэй байгаа. Хэрхэн яаж түлэхээ мэдэхгүйгээс болоод түүхий нүүрс түлдэг айл байгаа байх. Нам даралтын зууханд бас асах болон асахгүй тохиолдол байгаа. Ямар зууханд ямар түлш яаж хэрэглэхийг зааж сурталчлах шаардлагатай.

16) *Таны бодлоор хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Үр дүнтэй арга зааварчилгааг маш сайн гарын авлага, зурагт хуудас, зурагтаар түгээх шаардлагатай. Энэ эргээд цэвэр агаарт нөлөөлж эрүүл мэндэд сайн гэдгийг мэдүүлэх хэрэгтэй, иргэд сайн мэдэх болсон байгаа.

Мөн энэхүү үртсэн шахмал түлшийг Хөвсгөлийн дугаартай машин нэг уутыг нь 8500төг-р зарж байна гэсэн. Энэ нь цаад нягтлан зохион байгуулж байгаа гэж бодож байна.

Жижиглэнгээр борлуулагчидтай хийсэн ярилцлага № 4

Огноо: 2011 оны 12-р сарын 22 Дүүрэг: Баянгол Хороо: 23-2.....

Хэсэг:1

Овог нэр/Нэр: Даваасүрэн Албан түшаал: Борлуулагч..... Нас: 30..... Хүйс: Эмэгтэй.....

Боловсрол: бүрэн дунд.....

1. *Танай жижиглэнгээр шахмал түлш борлуулах цэг нь хэдэн төрлийн ямар ямар үнэтэй аль үйлдвэрийн түлш борлуулдаг вэ? Ямар процес шат дамжлагаар иргэдэд түлш борлуулдаг вэ?*

МАК-н хагас коксон түлш, Хялганат, Түнхэлийн гэж 2 төрлийн үртсэн түлш нийт 3 төрлийн түлш борлуулдаг. МАК-н түлш шууд наашаа хот уруу ирээд тээвэрлэгч компани энд авчирдаг гэдгийг мэдэж байна. Энд авчирч өгөхдөө НАЧА-с авчирч өгдөг. Тээвэрлэгч авчирч өгөхдөө утсаар урьдчилан авчирдаг.

2. *Түлшний хэрэгцээ ямар байна вэ? Өдөрт дунджаар хэр хэмжээний түлш борлуулагддаг вэ?*

Нүүрсний хэрэгцээ өдөрт янз бүр байдаг ба коксжон түлш өдөрт 1тн хүрэхтэй үгүйтэй байна. Үртсэн шахмал түлш байгаа үед борлуулалт маш сайн байдаг.

3. *Хамгийн их борлуулалт сайтай болон хамгийн борлуулалт багатай түлш нь ямар түлш вэ? Ийм түлш байгаа бол ямар учраас ийм ялгаатай байдаг вэ? Үнэ эсвэл чанар/*

Хамгийн борлуулалт сайтай нь Түнхэлийн харандаан үртсэн түлш. Ирсэн даруйдаа л дуусдаг. МАК-н хагас коксон түлш бууддаг, чулуу ихтэй, хог ихтэй, асалт удаан. Үнийн хувьд төрөөс хөнгөлж байгаа болохоор харьцангуй хямд байгаа. МАК-н хагас коксон түлш нь асахдаа ажиллагаа ихтэй маш хүчтэй галанд асдаг гэж ярьдаг.

4. *Иргэдийн худалдан авах чадвар ямар байна вэ? Шахмал түлшнийг иргэд үнийн хувьд яаж хүлээж авдаг вэ?*

Иргэдийн хувьд худалдан авах чадвар боломжийн бөгөөд боломжоороо авч байгаа. Үнийн хувьд асуудал байхгүй. Харин нийлүүлэлт маш муу.

5. *Мөн хэрэглэгчид ямар савалгаатайг нь илүү ихээр худалдан авдаг вэ? Яагаад үүнийг сонгодог вэ?*

Савалгааны хувьд хагас коксон түлшийг 20кг их авдаг. Харин үртсэн түлшийг савалгаа харгалзахгүй авдаг, хааяадаа нэг ирээд шууд дуусдаг.

6. *Иргэд нэг удаадаа хэдэн кг түлш худалдан авдаг вэ?*

Худалдан авалт янз бүр байдаг, хамгийн бага авахдаа нэг уутыг авна, 2 уутыг авах айл байна, бусад янз бүр байна. Зарим боломжтой айл түлш нь байвал тонноор нь авдаг бол бусад айл нь өдрийн хэрэгцээтэйг авдаг.

7. *Боловсруулсан түлш хэрэглэхийн давуу талууд юу вэ? Боловсруулсан түлш хэрэглэхэд хэр их хаягдал гардаг вэ? Гадаах болон дотоод орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдаж байна уу? Боловсруулсан түлш хэрэглэхэд утаа, эвгүй үнэр, тортог зэрэг бага байна уу? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчид боловсруулсан түлш хэрэглэж байгаадаа мөн өөрчлөлт ажиглагдаж байгаад баяртай байгаа?*

Сайн талууд гэвэл өмхий үнэргүй утаа багатай. МАК-н коксон түлш нь үнс чулуу их гардаг. Энэ доош унадаггүй учраас заавар чимхүүрээр авах шаардлагатай болдог. Гэр доторх тоос шороо мэдэгдэхүйц өөрчлөгдсөн. Иргэдийн хувьд энэхүү боловсруулсан түлшийг түлж сураад дуртай болж байгаа ч шахмал түлш ирэхгүйгээс коксон түлшээ худалдан авахгүй, хангалт маш муу байна.

8. *Түүхий нүүрсийг хориглох шахмал түлшийг нийлүүлэх ажлын шат дамжлага /үйлдвэрлэгч- тээвэрлэгч, жижиглэн борлуулах цэг, хэрэглэгч/ тус бүрийн үйл ажиллагаа ямар байна вэ? Энэ хэр оновчтой зохицуулалт вэ?*

Маш их дамжлага дамждаг гэж сонссон. Энэ шат дамжлагаас үүдээд хүнд сурталаас түлш олдохоо больсон гэж бодож байна. Үртсэн түлшний захиалга байнга өгдөг боловч ерөөсөө ирдэггүй. Түүхий нүүрсийг хориглох үйл ажиллагааны хувьд ямар ч үр дүн гараагүй. Энэ орчим түүхий нүүрсийг борлуулж байна. Иргэд ч худалдан авч түлж байна. Цаанаас түлш хангалтгүй ирж байгаа болохоор иргэд өдөр бүр ийшээ ирсний оронд түүхий нүүрсээ авч түлэх нь дээр гэж үзэж байна.

9. *Үйлдвэрлэгчдийн нийлүүлж байгаа шахмал түлшний чанар хэр байна вэ? Илч дулаан ялгаруулалт ямар вэ? Иргэд энэ тал дээр ямар нэгэн санал хүсэлт, гомдол гаргаж байна уу? Хэрэв ямар нэгэн асуудал байгаа бол аль компаний нийлүүлсэн ямар төрлийн түлш хамгийн их шүүмжлэгдэж байна вэ?*

Үртсэн шахмал түлшний чанар маш сайн боловч МАК-н хагас коксон түлшний илч дулаан сайжирсан боловч иргэд хэрэглэж сураагүй бололтой.

10. *Иргэдэд шахмал түлш хэрэглэхэд хүндрэлтэй асуудлууд байдаг уу? Таны бодлоор хэрэглэгчдын хувьд боловсруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад давуу болон сул тал юу вэ?*

Давуу тал нь утаа үнэхээр бага байдаг. Сүүлийн харьцангуй гомдол багасч байгаа ч цаанаас зохицуулалт үнэхээр муу байдаг. Чулуу ихтэй учраас зуухнаас чулууг түүж авахад хүндрэлтэй. Түлш ирэхгүй байгаатай холбоотой иргэдийн бүхмидал хэл ам маш их гардаг. Коксон түлшийг түүхий нүүрснээс илч дулаан түлж сурвал ялгаа байхгүй, муухай үнэр утаа бага угаар байхгүй. Түлж чадахгүйгээс болоод үртсэн шахмал түлшээ нэхээд энэ түлш ирсэн дохиолдолд зодоон, хэрүүл салдаггүй хэцүү байдаг.

11. *Хороо бүрт түлш түгээлтийн 2 цэг ажиллаж байгаа гэсэн ианайх тогтмол түлшээр хангаж ажиллаж чаддаг уу? Түлш хэр тогтмол ирдэг вэ? Түлш тасрах үе байдаг уу? Хэрэв байгаа бол аль шалтгаан нь юу вэ?*

Тогтмол түлшээр хангаж ажиллаж үнэхээр чаддаггүй. Нэгийг нь өгөөд нөгөөг нь өгөхгүй байгаагаас зодолдох, хоорондоо муудалцах явдал маш их гардаг. Үртсэн түлш сард нэг удаа ирэх ба өдөртөө л дуусдаг. Үртсэн шахмал долоон хоногтоо нэг удаа ирж байна, ирэхдээ 5тоннгэх мэтээр ирж байна. Зарж байгаа бид нар заналхийлэлд өртөөд хэцүү байна. Цаанаас асуухаар агуулахад хангалттай байгаа гэдэг энэ ямар учиртай байгааг ерөөсөө ойлгохгүй байгаа.

12. *Хороо гэр хорооллын оршин суугчдад ваучер тарааж байгаа гэж бид сонссон. Бүх айл өрх өвлийн улирлын турш хэрэглэх ваучер авсан уу entire winter season? Нэг айлд ноогдож буй түлшний 2.5-3тонны хязгаарлалтын талаар та юу гэж бодож байна вэ? Энэ нь айл өрх бүтэн өвлийн турш хэрэглэхэд хүрэлцээтэй юу? Ваучерын системийн үр өгөөжийг та хэрхэн үнэлэх вэ?*

Бүх өрхүүд эрхийн бичиг /ваучер/-аа авсан. Нийт жилийн тооцоолсон хэрэгцээ хүрнэ байх гэж бодож байна. Үртсэн шахмал түлш бага ирж байгаа болохоор ваучерийн хангалттай хүрнэ. Ваучерийн системийн үр өгөөж нь боломжийн боловч маш их цаг хугацаа авдаг. Үртсэн шахмал ирсэн үед маш их ойчир дараалал үүсдэг. Зарим иргэд ваучераа дуусахаар хаанаас авах уу гээд ваучер дамлах асуудал ч үүсэж болзошгүй.

13. *Шахмал түлш үйлдвэрлэгчдийн талаар, мөн тээвэрлэлтийн явцын талаар, хэрэглэгчдэд нийлүүлж байгаатай холбоотойгоор таньд ямар нэгэн санал байна уу?*

Сав баглаа боодол байнгын задарч ирдэг. Ингэснээр буцаад бооно иргэд голно. Задарсан түлш кг хүрдэг үү үгүй эсэхийг мэдэхгүй байгаа. Өөрөө өрөнд ордог. Сав баглаа боодлыг сайжруулах эсвэл энэ олон шат дамжлагыг багасгах хэрэгтэй байх. Мөн иргэдэд хүргэх арга замыг боловсронгуй болгож өгөхийг их хүсэж байгаа.

14. *Шахмал түлш үйлдвэрлэгчдэд, мөн тээвэрлэлтийн явц,хэрэглэгчдэд нийлүүлж байгаад хандан хэлэх таньд ямар нэгэн санал байна уу?*

Маш олон шат дамжлага дамждаг гэж сонссон. Энэ сайн мэдэхгүй.

15. *Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын бохирдлыг бууруулах ба боловсруулсан түлшний талаар олон нийтийн мэдээллийг сайжруулах материал хүлээн авдаг уу? Ухуулга сурталчилгааны үйл ажиллагаануудын чанарын талаар юу гэж бодож байна вэ? Таны бодлоор гэр хорооллын оршин суугчдад хүргэх ёстой гол санаа юу вэ?*

МАК-н гарын авлага нэг удаа өгсөн. Хийгдээгүй байх, хэсгийн ахлагч нар суртачилгаа хийдэггүй ба бид нар өөрсдөө хийдэг. Олон нийтийн хэрэгслээр хэд хэдэн удаа сонссон. Олон нийтээр суртачлах ажил бараг хийгддэггүй ч иргэд бүгд ерөнхийдөө мэдэж байгаа. Хэрхэн яаж түлэхээ мэдэхгүйгээс болоод түүхий нүүрс түлдэг айл байгаа байх. Нам даралтын зууханд бас асах болон асахгүй тохиолдол байгаа. Ямар зууханд ямар түлш яаж хэрэглэхийг зааж суртачлах шаардлагатай.

16. *Таны бодлоор хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ухуулга сурталчилгаанд ашиглавал гэр хорооллын оршин суугчдад хамгийн үр дүнтэй вэ?*

Үр дүнтэй арга зааварчилгааг маш сайн гарын авлага, зурагт хуудас, зурагтаар түгээх шаардлагатай. Энэ эргээд цэвэр агаарт нөлөөлж эрүүл мэндэд сайн гэдгийг мэдүүлэх хэрэгтэй, иргэд сайн мэдэх болсон байгаа. Мөн хэрхэн яаж асаах аргазүйг зурагтаар заах зэрэг.

Баянгол дүүргийн 10-р хорооны оршин суугчидтай хийсэн (H form) дасгалын тойм

Оролцогчид	Боловсруулсан түлшний ханган нийлүүлэлт, түгээлтийг хэрхэн үнэлэх вэ??		
	Эерэг хүчин зүйлс	Сөрөг хүчин зүйлс	Цаашид хийгдэх шаардлагатай ажлууд
<p>Халиунхүү Баасанжав Баянжаргал Шулмаранз Мягмарсүрэн Цэцэгбал Гончиг Отгоо Цэдэнсодном Баяржаргал Нянгар Туяа Гантулга Эрдэнэжаргал Гантулга Долгормаа Алтангадас</p> <p>Багийн үнэлгээ 10 онооноос нэг оноо</p>	<ul style="list-style-type: none"> - Үртсэн шахмал /харандаан /түлш нь маш сайн чанартай. /3/ - Үртсэн шахмал /харандаан/ түлшний шаталт сайн/2/. - Хагас коксжуулсан түлш нь янз бүрийн үнэр гарахгүй, гадна утааны бохирдол багатай нь сайн. 	<ul style="list-style-type: none"> - Боловсруулсан түлшний хүрэлцээ маш муу байна. /7/ - Түгээх цэгт ирсэн түлш тэр дороо дуусаж байна. хүрэлцээ муутай байна. - Боловсруулсан түлшний хангалт маш муу байна. сүүлийн үед долоон хоногт нэг удаа машинаар бууж байна. - Коксжсон түлшний чанар муу байна. - Коксжуулсан түлш маш муу шатаж байна. - Коксжуулсан нүүрс асахгүй байна./2/ - Хагас коксжуулсан түлш дуу чимээ ихтэй./3/ - Хагас коксжуулсан түлш үнс ихтэй. - Шарын голын Эко хомоол шиг түлш тортог үнс ихтэй /2/ - Шарын голын түлш шатахгүй байна /3/ - Шарын голын түлш зарим нь сайн зарим нь шаталт муу барьцалдаад шатахгүй байна - Эко буюу шарын голоос ирсэн коксжсон нүүрс нь хүрэлцээ муу /2/ - Шарын голын Коксжсон түлшнээс маш их чулуу хог үнс гарч байна - Коксжуулсан нүүрс илч багатай, чанар муутай байна, /2/ - Үртсэн шахмал түлшинд яндан их хална. Гал түмэр гарах магадлалтай. - Боловсруулсан түлш борлуулах цэгийн байршил муу, сонголт муу /2/ - Боловсруулсан түлш борлуулах цэг цөөхөн байна./2/ - 1,2,3-р хэсгүүдэд түгээх цэг байхгүй байршил хол байна - Түлш түгээх цэгрүү түлш авахаар унаа хөлслөөд очихоор ямар ч түлш байхгүй илүү зардал гарч байна. - Түлшээ аваад унаа хөлслөхөд 10000төг-өөр унаа хөлсөлж байна. 	<ul style="list-style-type: none"> - Бүх төрлөөр утаагүй болгох арга хэмжээг нилээд эрчимтэй авах - Бүх өрхийг Утаагүй зуухаар хангах/2/ - Жижиглэнгээр түлш борлуулах цэгийг нэмж олон болгох/6/ - Бүх төрлийн утаагүй түлшийг хүрэлцээтэй хэмжээгээр жижиглэн түгээх цэгийг хангадаг болох хэрэгтэй /2/ - Цахилгааны хүчдэл бага ордог шалны халаагуур айлуудад төсөлөөр тавьж өгөх - Төрөл бүрийн цахилгаан халаагуур нийлүүлэх - Эрчим хүчний бодит хөнгөлөлт баймаар байна. - Агаарын чанарыг сайжруулахад хог ачилт зайлшгүй шаардлагатай. Хогоо ачих хэрэгтэй байна. Хог ачих асуудлыг эрчимжүүлэх. - Үртсэн шахмал түлшний үртэсний нөөц хэр байгаа вэ? - Түлш боловсруулж буй технологийг сурталчилах болон хэрэглээг зааж өгөх сурталчилах хэрэгтэй. - ДЦС-2-ын шахмал түлшийг түргэн хугацаанд ашиглалтад оруулж зориулалтын түлшээр

Боловсруулсан түлшний ханган нийлүүлэлт, түгээлтийг хэрхэн үнэлэх вэ??		
